

С
363.2
Б-342

Албан хэрэгцээнд зориулав

ЦАГДАА СУДЛАЛ

Онол арга зүйн
улирал тутмын
сэтгүүл

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Баянмөнх

Хэвлэлийн хуудас: 9.9 х/х

Цаасны хэмжээ: А.4

Өрөлтөд орсон огноо: 2024.03.02

Дугаарыг эрхлэн гаргасан: Доктор (Ph.D) Б.Баянмөнх

ISBN 978-99962-8882-2-7

2024 №1 (38)

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга: **Ж.Болдбаатар** Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Зөвлөлийн гишүүд:

Ж.Долгорсүрэн Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Ж.Болдбаатар Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Б.Пүрэв Хууль зүйн доктор (Ph.D), хүндэт профессор

Ж.Заанхүү Түүхийн шинжлэх ухааны доктор, (Sc.D), дэд профессор

Г.Гантөмөр Хууль зүйн доктор, (Ph.D), профессор

Ч.Нямсүрэн Хууль зүйн доктор (Ph.D), профессор

З.Төрмандах Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Т.Оюунчимэг Хууль зүйн доктор (Ph.D), профессор

Сэтгүүлийн эрхлэгч: Хууль зүйн доктор (Ph.D), профессор **Бө.Бат-Эрдэнэ**

Нарийн бичгийн дарга: Хууль зүйн доктор (Ph.D) **Б.Баянмөнх**

Сэтгүүлийн редакцийн зөвлөл:

Т.Бямбаа Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

О.Цэцэгмаа Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Д.Энхжаргал Хэл шинжлэлийн ухааны доктор (Ph.D)

Д.Мягмарцэрэн Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Ш.Ариунбилэг Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Б.Баянмөнх Хууль зүйн доктор (Ph.D)

Г.Бямбадорж Хууль зүйн доктор (Ph.D)

*Манай хаяг: Дотоод хэргийн их сургууль Баян зүрх дүүрэг, Цагдаагийн Академийн өргөн чөлөө, хилчиний гудамж-1, утас: 99878219
мэйл хаяг: b.bayadaa2007@gmail.com*

ЦАГДАА СУДЛАЛ
Онол арга зүйн улирал тутмын сэтгүүл
(дугаар 2024 №1)

АГУУЛГА

ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Батжаргал. Монгол Улсад кибер орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал.....	4
Б.Ганболд. Мета өгөгдлийг ашиглан гэмт хэрэгтэй тэмцэх, өөрийн аюулгүй байдлаа кибер орчинд хэрхэн хамгаалах талаарх ойлголт.....	9

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Баярболд. Хүүхдийн гэмт хэргийн холбогдогч, хохирогч болоход нөлөөлөх хүчин зүйлүүд.....	14
Б.Алтангэрэл. Монгол Улс дахь амиа хорлох үйлдлийн нөхцөл байдал.....	23
Д.Бямбахүү. Монгол Улсын Эрүүгийн хуульд орсон зарим нэмэлт өөрчлөлт.....	29

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Одбаатар. Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангахад анхаарах зарим асуудал.....	36
Б.Баянмөнх. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хөшүүргийг татах аргыг ашиглах ба анхаарвал зохих зарим асуудал.....	46
Б.Алтанзул. Байгууллагын соёлд хамт олны сэтгэл зүй нөлөөлөх нь	53
Б.Батбаяр. Хойшлуулшгүй ажиллагааны явцад цагдаагийн алба хаагчид тулгарч буй хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга зам	59

ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ОНОЛ ПРАКТИК

А.Баасанцэрэн. Монгол Улсын гадаад харилцаанд баримтлах бодлого ба үндэсний аюулгүй байдал.....	65
Г.Төртулга. Цагдаагийн байгууллагаас төрийн тусгай хамгаалалтын газартай хамтран ажиллахад анхаарах зарим асуудал.....	78

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Д.Энх-Амар. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхэд нутгийн захиргааны байгууллагын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах нь	83
С.Эрдэнэбаяр. Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд гадаадын зарим орны туршлагыг нэвтрүүлэх нь	91
Б.Чинтамир. Жагсаал, цуглааны үеийн замын цагдаагийн албаны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт.....	98

ДОТООДЫН ЦЭРГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

П.Оюунболд. Монгол Улсын Дотоодын цэргийн алба хаагчдыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх удирдлагын үйл ажиллагааны туршлага.....	106
--	-----

ХҮНИЙ ЭРХИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Х.Уянга. Олон нийтийн сүлжээн дэх хүний эрхийн зөрчлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал.....	114
--	-----

**МОНГОЛ УЛСАД КИБЕР ОРЧИНД
ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН БАЙДАЛ
TRENDS OF CYBER CRIMES IN MONGOLIA**

Б.Батжаргал
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Гүйцэтгэх ажлын тэнхимийн ахлах багш,
Цагдаагийн дэд хурандаа
Batjargal B,
Police lieutenant colonel,
senior lecturer of the
Department of Criminal intelligence
at the Police school of the
University of Internal Affairs Mongolia

Хураангуй. Кибер орчинд үйлдсэн гэмт хэрэг нь үндэсний аюулгүй байдлын орчин үеийн аюул заналуудын нэг болоод байна. Энэхүү өгүүлэлд 2022 онд Цагдаагийн байгууллагын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын статистик мэдээлэлд үндэслэн мэдээллийн аюулгүй байдал, тэр дундаа кибер гэмт хэргийн хөгжилтэй холбоотой үндсэн хүчин зүйлүүдийг тодорхойлохыг зорьсон болно.

Abstract. Cyber crime refers to one of the modern threats to national security. The article provides the main factors that determine the development of cybercrime. In addition, the statistics "On the state of crime of Mongolia" of 2022 are analyzed, characterizing the states and trends of development as crimes committed using information technologies.

Түлхүүр үгс: кибер гэмт хэрэг, залилан, сошиал инженер

Key words: cyber crime, fraud, social engineering

Үндсэн хэсэг. Сүүлийн арван жил мэдээллийн технологи гэрлийн хурдаар хөгжиж байна. Энэ нь бидний амьдралын хэв маягт асар том өөрчлөлт авчирч байгааг бид бараг анзаарах сөхөөгүй мэт хэмнэлээр амьдарч байгаа билээ.

Орчин үеийн компьютерийн технологи, ухаалаг гар утас, хөдөлгөөнт интернэтийн тусламжтайгаар хүмүүс үлэмж хэмжээний мэдээлэлд холбогдон орон зай, цаг хугацаанаас үл хамааран суралцах, мэдээ, мэдээллийг шууд хүлээн авах, дуу дүрстэй дуудлага хийх, худалдан борлуулах, худалдан авалт хийх гэх мэт харилцаа холбооны хэрэгслээс, санхүүгийн үйл ажиллагаа, эрүүл мэндийн үйлчилгээг хүртэл бүхий л салбарт шинэ шинэ боломжууд нээгдэж байна.

Мэдээллийн технологи нь байгууллага, компанийн үйл ажиллагаанд үлэмж нөлөөтэй болсон. Мөнгөн гүйлгээ, бараа, үйлчилгээ хүлээн авах, нийлүүлэх, санхүү бүртгэл, харилцагчтайгаа харилцах зэрэг бүхий л үйл ажиллагааг программын тусламжтай гүйцэтгэдэг.


Бүхэлдээ мэдээллийн технологи цаашид хурдацтай хөгжихийн чацуу бидний амьдралд тэр хэрээр нөлөөлөх нь дамжиггүй юм. Ирээдүйд хүлээж байгаа энэхүү их өөрчлөлт нь түүний үзүүлэх сөрөг нөлөө, аюулгүй байдлын асуудлын талаар анхаарах ёстой

болохыг сануулж, гэмт хэргээ үйлдэх зэвсэг хэрэгсэл, орчин нь болж байгаа мэдээллийн технологи бол төр засгийн орчин үеийн аюул занал болж, түүнд үзүүлэх үр дүнтэй хариу арга хэмжээг шаардаж байна.

Монгол Улсад кибер орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо тасралтгүй өсөж байгааг статистикийн мэдээллээс харж болно.¹

График 1.

Монгол Улсад 2015-2022 онуудад бүртгэгдсэн
Кибер орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо



2022 онд 35340 гэмт хэрэг бүртгэгдсэнээс нийт илрүүлэлт 54,2%, үүнээс өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 21493 буюу нийт хэргийн 60,8%, залилан (МУ-ын ЭХТА 17.3 зүйл анги) 11839 буюу нийт хэргийн 33,5%, мэдээллийн технологи ашиглан үйлдсэн гэмт хэрэг 8563 бүртгэгдсэнээс 7708 буюу 90 гаруй хувь нь 17.3 зүйл ангиар бүртгэгдсэн байна.²

Хүснэгт 1.

Монгол Улсад 2021-2022 онуудад бүртгэгдсэн
Кибер орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн байдал

Гэмт хэргийн төрөл	2021	2022	2021 онтой харьцуулсан өсөлт	Тухайн төрөлд эзлэх 2022 онд бүртгэгдсэн кибер орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн хувь
Нийт	4825	8563	77,5	
Залилах	3858	7708	99,8	90
Худал мэдээлэл тараах	126	124	-1,6	1,4
Кибер орчинд хууль бусаар халдах	150	256	70,7	3
Хулгай	92	126	37	1,5
Мөрийтэй тоглоом зохион байгуулах	487	69	-85,8	0,8
Заналхийлэх	17	40	23	0,5
Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах	2	37	1750	0,4

Монгол улсын Кибер аюулгүй байдлын тухай хуульд виртуал орон зайг “кибер орон зай” гэж тусгасан бөгөөд интернэт болон бусад мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ,

¹ Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал., -Уб.,2023, 208 дахь тал.

² Мөн бүтээл. 207 дахь тал.

тэдгээрийн ажиллагааг хангах мэдээллийн дэд бүтцийн хамааралтай цогцоос бүрдсэн биет болон биет бус талбар³ гэж тодорхойлсон.

Мэдээлэл харилцаа холбооны сүлжээ “интернэт”-ийн олон талт харилцааг техник, технологи дангаараа зохицуулж чадахгүй нь тодорхой⁴ тул тус харилцаанаас үүсэж буй асуудлыг эрх зүйгээр зохицуулах шаардлага гарч байна.

Монгол улсын Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэгт Кибер аюулгүй байдлын эсрэг хоёр төрлийн гэмт хэргийг тусгайлан зааж өгсөн байдаг. Кибер гэмт хэргийн онцлог нь аливаа улсын нутаг дэвсгэрээр хязгаарлагдахгүй бөгөөд мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ “интернэт”-ээр дамжуулан аль ч улс орноос үйлдэх боломжтой тул тухайн гэмт хэрэгтэй тэмцэх, кибер аюулгүй байдлыг хангахад олон улсын хамтын ажиллагаа, нэгдмэл байдал чухал байр суурь эзэлдэг.⁵

Мөн улс орнууд кибер гэмт хэргийн талаарх мэдээлэл солилцох механизм бий болгож байна. Тухайлбал, АНУ-ын Холбооны мөрдөх товчоо интернэт гэмт хэргийн гомдол хүлээн авах төв www.ic3.gov веб сайт ажиллуулж гомдол мэдээллийг хүлээн авахаас гадна сүүлийн үеийн аюул заналын талаар, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх мэдээллийг хүргэн ажиллаж байна.⁶

Манай улсын тухайд 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Кибер гэмт хэрэгтэй тэмцэх төвийн үйл ажиллагааг албан ёсоор нээсэн бөгөөд уг төв нь 2023 оны 11 дүгээр сарын 03-наас 12-ны өдрийн хооронд 102 тусгай дугаарын утсаар интернет банкны халдлага цахим залилан, цахим мөрийтэй тоглоом, фэйсбүүк цахим халдлагад өртөж их хэмжээний мөнгөө алдаж хохирсон иргэдийн нийт 81 дуудлага, мэдээлэл хүлээн авч, арилжааны холбогдох банкнуудтай хамтран нийт 74.500.000 төгрөгийн хохирол учирсныг шилжилт хөдөлгөөнийг нь нэн даруй, шуурхай хязгаарлан гэмт үйлдлийг таслан зогсоож, гэмт этгээдүүд гэмт хэргийн замаар олсон мөнгөн хөрөнгийг завших, иргэдэд хохирол учрахаас сэргийлж ажилласан байна.⁷ Ийнхүү Цагдаагийн байгууллагад Прокурорын байгууллага, арилжааны банк, үүрэн телефоны үйлчилгээ үзүүлэгч нараар бүрдсэн Кибер гэмт хэрэгтэй тэмцэх төв нээгдэж, 102 тусгай дугаарын утсаар болон фэйсбүүкийн Кибер гэмт хэрэгтэй тэмцэх төв пэйж хуудсаар дуудлага, мэдээлэл хүлээн авч ажиллаж эхэлжээ.

2023 оны 12 дугаар сарын байдлаар Монгол улс дахь фэйсбүүк хэрэглэгчийн тоо 2,9 сая гаруй буюу энэ тоо нь нийт хүн амын 86,8%-тай тэнцэнэ.⁸

Дээр өгүүлсэнчлэн одоо үед ихэнх үйл ажиллагаа кибер орчинд шилжсэн учраас Кибер эрх зүй гэдэг ойлголт үүссэн. Кибер гэмт хэргийг зохицуулж буй зохицуулалтуудыг судалж үзэхэд Будапештийн конвенц нь кибер гэмт хэрэгтэй тэмцэх анхны хамгийн чухал олон улсын гэрээ бөгөөд Кибер гэмт хэргийн тухай Будапештийн конвенцыг 2001 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Европын холбооны зөвлөлөөс дэмжин баталсан. 2024 оны 01 дүгээр сарын байдлаар дэлхийн 99 улс нэгдэн орсон байна.⁹

³ Монгол улсын кибер аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь хэсэг.

⁴ МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхим. Дэлхийн эрүүгийн загвар хууль ба орчин үе. - УБ., 2013, 7 дахь тал.

⁵ Нээлттэй нийгэм форум. Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа. -УБ., 2022, 16 дахь тал.

⁶ <https://www.ic3.gov/>

⁷ <https://information.police.gov.mn/a/5471>

⁸ <https://napoleoncat.com/stats/facebook-users-in-mongolia/2023/12/>

⁹ [Budapest Convention - Cybercrime \(coe.int\)](https://www.budapestconvention.org/)

Зураг 1. Будапештийн конвенцод нэгдэн орсон улсууд.

Albania	Czechia	Lithuania	Moldova (Republic of)
Andorra	Denmark	Luxembourg	Romania
Argentina	Dominican Republic	Malta	San Marino
Armenia	Estonia	Mauritius	Senegal
Australia	Finland	Monaco	Serbia
Austria	France	Montenegro	Slovakia
Azerbaijan	Georgia	Morocco	Slovenia
Belgium	Germany	Netherlands	Spain
Bosnia and Herzegovina	Ghana	Nigeria	Sri Lanka
Brazil	Greece	North Macedonia	Sweden
Bulgaria	Hungary	Norway	Switzerland
Cabo Verde	Iceland	Panama	Tonga
Canada	Israel	Paraguay	Türkiye (Republic of)
Cameroon	Italy	Peru	Ukraine
Chile	Japan	Philippines	United Kingdom
Colombia	Latvia	Poland	United States of America
Costa Rica	Liechtenstein	Portugal	
Croatia			
Cyprus			

Тус конвенцод компьютерын систем, сүлжээ, өгөгдлийн нууцлал, бүрэн бүтэн байдал, ашиглалтын эсрэг чиглэсэн халдлагыг таслан зогсоох, энэ төрлийн халдлагыг гэмт хэрэг болгон хуульчлах, түүнийг дотоодод болон олон улсын түвшинд илрүүлэх, мөрдөх, яллах, тухайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй хууль тогтоомж батлах, олон улсын хамтын ажиллагааг шуурхай зохион байгуулах зэрэг асуудлыг зохицуулсан. Мөн Будапештийн конвенцын удиртгал хэсэгт дурдсанаар конвенц нь компьютерын сүлжээ, өгөгдөлтэй холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах, зүйлчлэх, гэмт хэргийн цахим нотлох баримт цуглуулах ажиллагааг зохицуулдаг онцлогтой.

Хүснэгт 2. Будапештийн конвенцоор тодорхойлсон кибер гэмт хэргийн төрөл.¹⁰

1	Компьютерын өгөгдөл болон системийн нууцлал, бүрэн бүтэн, хүртээмжтэй байдлын эсрэг гэмт хэрэг (Offences against the confidentiality, integrity and availability of computer data and systems)	2 дугаар зүйл - Хууль бус нэвтрэлт 3 дугаар зүйл - Хууль бусаар саад хийх 4 дүгээр зүйл - Өгөгдөлд хөндлөнгөөс орлцох 5 дугаар зүйл - Системд хөндлөнгөөс оролцох 6 дугаар зүйл - Тоног төхөөрөмж зүй бусаар ашиглах
2	Компьютер ашигласан гэмт хэрэг (Computer-related offences)	7 дугаар зүйл - Компьютер ашигласан хуурамч баримт 8 дугаар зүйл - Компьютер ашигласан залилан
3	Контент (агуулга)-тай холбоотой гэмт хэрэг (Content-related offences)	9 дүгээр зүйл - Хүүхдийн порнографтай холбоотой гэмт хэрэг
4	Зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн зөрчилд холбогдох гэмт хэрэг (Offences related to infringements of copyright and related rights)	10 дугаар зүйл - Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөрчилд холбогдох гэмт хэрэг

Цахим хэрэгсэл ашиглан бусдыг залилах гэмт хэргийг өмчийн эсрэг, “кибер орчинд” хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан гэмт хэргийг хүүхдийн эсрэг, зохиогчийн

¹⁰ Нээлттэй нийгэм форум. Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа. УБ., 2022, 18 дахь тал.

эрх болон түүнд хамаарах эрхийн зөрчилд холбогдох гэмт хэргийг эдийн засгийн гэмт хэрэгт тус тус хамааруулан зохицуулсан. Эрүүгийн хуулиар зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөрчилд хамаарах гэмт хэргийн объектив шинжид “цахим орчин”, “цахим хэрэгсэл”, “цахим төхөөрөмж” ашигласан эсэхийг нарийвчилж тусгаагүй тул тухайн төрлийн гэмт хэрэг үйлдэхэд эдгээр аргыг ашиглахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хамааруулан үзэх нь эргэлзээтэй байна.¹¹

Дүгнэлт

1. Иргэд хэрэглэгчийн нэвтрэх нэр, нууц үгийг өөрийн нэр, төрсөн сар өдөр, утасны дугаар гэх зэргээр бусдад тааварлаж болохуйц хялбар байдлаар үүсгэн ашигладаг. Хоёр алхамт баталгаажуулалтын талаар мэдлэг муу. Цахим мэдээллийн хэрэгслийг зохих түвшинд ашиглах мэдлэг дутмаг бөгөөд “богино хугацаанд мөнгө ихээр олох, хүссэн газраасаа хийх боломжтой ажил”, “зээл олгоно”, “илгээмж явуулна”, “сугалаанд хожсон” гэх мэт иргэдийг төөрөгдөлд оруулж, амар хялбар аргаар мөнгө олох гэсэн санаа, сэдлийг нь ашиглан өгөөш (phishing) бүхий мэдээллийг уншихаар сонирхон дарж нэвтрэх нэр, нууц үгээ алддаг, цахим мэдээллийн хэрэгслээр түгээгдэж буй мэдээлэл үнэн зөв эсэх талаар нягтлан үздэггүй. Цахим орчинд хүүхдэд тавих хараа хяналт сул байгаа нь нь хүүхэд бүх төрлийн сөрөг мэдээллийг авах, хохирогч болох боломж нээлттэй байна.

2. Мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, бүх шатны боловсролын байгууллагад сургалтын тогтолцоог бий болгож нийгэм дэх ойлголт, мэдлэгийг төлөвшүүлэх шаардлагатай.

3. Кибер аюулгүй байдал, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиуд батлагдан хэрэгжиж байгаа боловч эдгээр эрх зүйн зохицуулалтын үзэл баримтлал, ач холбогдлын талаар мэдээлэл олон нийтэд хүрээгүй;

4. Олон улс нэгдэн орж, үр дүнтэй, хамтран ажиллаж байгаа Будапештийн конвенцод гишүүнээр нэгдэн орох нь манай улсын хувьд цаг хугацааны асуудал бөгөөд энэ талаар эрдэмтэн судлаачид, мэргэжилтэн, холбогдох төрийн байгууллагууд хэлэлцэн шийдвэрлэх шаардлагатай байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал., УБ., 2023.
2. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхим. Дэлхийн эрүүгийн загвар хууль ба орчин үе. УБ., 2013,
3. Нээлттэй нийгэм форум. Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа. УБ., 2022.
4. Монгол улсын кибер аюулгүй байдлын тухай хууль <https://www.legalinfo.mn>
5. АНУ-ын Холбооны мөрдөх товчоо <https://www.ic3.gov/>
6. Цагдаагийн ерөнхий газар <https://information.police.gov.mn/a/5471>
7. RTV House <https://napoleoncat.com/stats/facebook-users-in-mongolia/2023/12/>
8. Европын холбооны Эрүүгийн эрх зүйн хороо [Budapest Convention - Cybercrime \(coe.int\)](https://www.coe.int/t/t20/Budapest_Convention_-_Cybercrime)

¹¹ Нээлттэй нийгэм форум. Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа. -УБ., 2022, 19 дэх тал.

**МЕТА ӨГӨГДЛИЙГ АШИГЛАН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, ӨӨРИЙН
АЮУЛГҮЙ БАЙДЛАА КИБЕР ОРЧИНД ХЭРХЭН ХАМГААЛАХ
ТАЛААРХ ОЙЛГОЛТ**
**UNDERSTANDING HOW TO FIGHT CRIME AND PROTECT YOURSELF
IN CYBER ENVIRONMENT USING META DATA**

Б.Ганболд,
Дотоод Хэргийн Их Сургуулийн
Цагдаагийн сургуулийн Гүйцэтгэх
ажлын тэнхимийн багш, цагдаагийн
ахмад

B. Ganbold,
lecturer of the Department of Criminal
intelligence at the Police School of the
University of Internal Affairs, police
captain

Товч агуулга: Хэн нэгэнд илгээсэн энгийн файл эсвэл зураг таны бусадтай хуваалцахыг хүсээгүй мэдээллийг дотроо агуулж байдаг гэдгийг мэдэх үү. Бусдад илгээсэн гэрэл зураг нь тухайн зурагт байгаа мэдээллээс гадна зураг дарсан газар орны байршил, огноо, ямар төхөөрөмжөөс авсан зэрэг мэдээллийг танд мэдэгдэлгүй бусдад дэлгэж байдаг. Эдгээр мэдээлэл нь файлын мета өгөгдөл дотор хадгалагдаж байдаг. Файлын мета өгөгдөл гэж юу болохыг хүн бүр мэддэггүй. Хэн нэгэнд илгээх гэж байгаа зураг болон бусад файлд агуулагдаж байгаа мета өгөгдлөө хамгаалснаар болзошгүй гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлж чадах юм.

Abstract: Did you know that a simple file or photo that you send to someone can contain information you don't want to share with others? In addition to the information contained in the photo, the photos sent to others reveal information such as the location of the photo taken, the photo date, and the device from which it was taken without your knowledge. This information is stored in the file's metadata. Not everyone knows what file metadata is. By protecting the metadata contained in the images and other files you are sending to others, you can prevent yourself from becoming a potential victim of crime.

Түлхүүр үгс: Нийгмийн инженерчлэл, Фишинг халдлага, мета өгөгдөл.

Keywords: Social engineering, Phishing attack, meta data.

Удиртгал

Мета өгөгдлийн аюулын талаар: Юуны өмнө мета өгөгдөл нь өгөгдлийн талаарх өгөгдөл гэдгийг ойлгох хэрэгтэй. Жишээлбэл, танд олон нийтийн сүлжээнд байршуулсан зураг байна. Тэр зургийн файл дараах мета өгөгдлийг дотроо агуулж байдаг - зургийг хаана, хэзээ, хэдэн цагт, ямар төхөөрөмж ашиглан авсан гэх мэт мэдээллийг дотроо агуулж байдаг. Тэхээр та зарим мэдээллийг бусдад илгээх үед бусадтай огт хуваалцахаар төлөвлөөгүй мэдээллээ хамт илгээж болох нь харагдаж байна.

Хүний онлайн орчинд хийж буй бүх үйлдлүүд болох гэрэл зураг авах, файл илгээх, пост нийтлэх, хөгжим сонсох, онлайн худалдан авалт хийх зэрэг бүх зүйлд бидний өөрийн оруулсан мэдээллээс гадна тоон ул мөр давхар үлдэж байдаг. Энэ тоон ул мөр нь мета

өгөгдлийн улмаас үүсдэг. Ихэнхдээ хүмүүс энэ талаар мэдэхгүйн улмаас аль эсвэл мэдсэн ч энэ баримтыг үл тоомсорлох нь араасаа аюул заналхийллийн эрсдэл дагуулж байдаг. Жишээлбэл, нийгмийн сүлжээн дэх гэрэл зургуудыг гэмт хэрэгтэн судалснаар ирээдүйд хохирогч болох хүний тогтмол явдаг маршрутыг тогтоохоос гадна түүний очих дуртай газар зэргийг олж мэдэх боломжтой. Энэ өгөгдөл дээр үндэслэн гэмт этгээд фишинг халдлага хийхэд бэлтгэх эсвэл нийгмийн инженерчлэлийн арга ашиглан залилан мэхлэх замаар гэмт хэрэг үйлдэх боломжтой юм.

Нийгмийн инженерчлэл гэдэг нь бусдаас мэдээлэл авах эсвэл ямар нэг үйлдэл хийлгэх зорилгоор тухайн нөхцөлд тааруулж зохиомол нөхцөл байдал үүсгэн, бусдад нөлөөлөх замаар бусдыг удирдах сэтгэлзүйн заль мэх юм.

Фишинг халдлага гэдэг нь кибер орчинд хамгийн түгээмэл тархсан нийгмийн инженерчлэлийн халдлагын нэг төрөл юм¹². Үндсэндээ фишинг гэдэг нь иргэдийн нэвтрэх нэр нууц үгийг олж авахад чиглэсэн байдаг. Хуурамч цахим шуудан ашиглах, эсвэл хууль ёсны мэт харагдах веб хуудас ашиглан бусдын нууц үгийг хулгайлдаг. Заримдаа гэмт этгээд хохирогчийг зээлийн картын мэдээлэл эсвэл бусад хувийн мэдээллээ өгөхийг албадах оролдлого хийдэг. Мөн илүү дэвшилтэт халдлагууд мөн ransomware¹³ гэх мэт илүү аюултай халдлагууд ихэвчлэн фишинг халдлагаас эхэлдэг.

Мета өгөгдөл нь хэрэглэгчийн оролцоогүйгээр автоматаар үүсэх бөгөөд тэдгээр нь ихэвчлэн файл үүсгэсэн огноо, газар, ашигласан техник, файлд нэмсэн тохиолдолд зохиогчийн өгсөн тайлбар, түүнийг үүсгэсэн программын хувилбарын талаарх мэдээллийг агуулдаг. Зарим тохиолдолд мета өгөгдөл нь хэрэглэгч хооронд шилжүүлэн дамжсан түүх, файлын өөрчлөлтийн талаарх мэдээллүүдийг хэлж чаддаг тул нэлээд эмзэг бөгөөд хувийн шинж чанартай мэдээллүүдийг агуулж байдаг.

Яагаад мета өгөгдөл хэрэгтэй байдаг вэ? Мета өгөгдлийн гол зорилго бол тухайн файлын албан ёсны лицензийн хязгаарлалтыг тогтоох, мөн зохиогчийг тодорхойлоход оршиж байдаг. Мөн сайтууд болон аппликешнүүдэд байрлуулсан файлуудын агуулгыг цэгцлэх, тодорхойлоход тусалдаг. Жишээлбэл, харилцаа холбооны операторууд мета өгөгдөл дээр тулгуурлан хэрэглэгчдийн үйл ажиллагааг хянах боломжтой байдаг.

Нийгмийн сүлжээ, интернэтэд үлдээсэн тоон ул мөр буюу мета өгөгдөлд дүн шинжилгээ хийснээр зорилтот хэрэглэгчдийн сонирхол, сонголт, байршил, дадал зуршил, үйл ажиллагааны талбарын талаарх мэдээллүүдийг ангилах боломжтой болдог.

Мета өгөгдлөө хэрхэн хамгаалах, эсвэл устгах вэ? Мета өгөгдөл нь ердийн өгөгдлийн нэгэн адил хамгаалагдсан байдаг, ялангуяа энэ нь энгийн хэрэглэгч гэхээсээ илүү байгууллагатай холбоотой байдаг. Энгийн хэрэглэгчийн хувьд хувийн мэдээллээ бусадтай хуваалцахыг хүсэхгүй байгаа бол өөрийн дижитал ул мөр буюу мета өгөгдлийг илгээх гэж байгаа файлаасаа устгаж байх хэрэгтэй.

iPhone гар утас ашиглан зурган файлаас мета өгөгдлийг устгах амархан:

1. Photos программыг нээгээд мета өгөгдлийг устгахыг хүссэн зургаа сонгоно уу.
2. Дэлгэцийн баруун доод буланд байрлах Хуваалцах дүрс дээр товшоод мета өгөгдлийг бүү хадгалах сонголтыг сонгоно.
3. "Дууссан" товчийг дарна.

¹² Руководство по защите от хакеров/ Коул Эрик. Пер. с англ. – М. Издательский дом «Вильямс», 2002.

¹³ Ransomware гэдэг нь хохирогчийн төхөөрөмж дээрх файлуудыг шифрлэн түгжиж барьцаалдаг хортой вирус бөгөөд түгжээтэй файлуудыг тайлахын тулд хохирогчоос мөнгө нэхдэг.


Андройд дээрх файлын мета өгөгдлийг үзэхийн тулд та Google Photo-г татаж авах шаардлагатай бөгөөд устгахын тулд гуравдагч талын програмыг ашиглах шаардлагатай болно. Төхөөрөмжийн тохиргоо руу орох, эсвэл ямар нэг программ татаж авахгүйгээр мета өгөгдлийг устгаж болох бас нэг арга бол файлаа илгээхээсээ өмнө мет өгөгдөл устгах зорилгоор бүтээсэн сайтуудыг ашиглах боломжтой. Үнэгүй ашиглах хувилбаруудад файлын хэмжээ хязгаарлагдмал байдаг бөгөөд ихэвчлэн 5 МБ хүртэлх хэмжээтэй файлын мета өгөгдлийг устгах боломжтой байдаг. Мөн Explorer ашиглан Windows үйлдлын систем дээр ийм өгөгдлийг устгахад маш хялбар байдаг.

Та Windows Explorer программыг нээж, хүссэн зураг руугаа очоод хулганы баруун товчийг дараад "Properties" -ийг сонгоод, "Details" табыг сонгоод Remove properties and personal information сонголтыг дарж хялбархан устгах боломжтой.

Мета өгөгдлийг хамгаалах хамгийн сайн стратеги бол баримт бичгийг илгээхээс өмнө нууц мэдээллийг илчлэх мета өгөгдлийг устгах явдал юм. Үүнээс гадна шаардлагатай бол мета өгөгдлийг файлд хадгалахгүй байх тохиргоог программ хангамжид урьдчилан тохируулж болно.

1. <https://www.adarsus.com/en/remove-metadata-online-document-image-video/>
2. <https://www.metacleaner.com/>
3. <https://www.imgonline.com.ua/eng/delete-exif.php> зэрэг холбоосоор орж мета өгөгдлын мэдээллийг устгах боломжтой.

EXIF өгөгдлүүд нь зургийн техникийн чухал мэдээллийг агуулдаг. Тэд таны камер, утасны марк, загвар, зургийг хэзээ авсан, зураг авсан байршил тэр ч байтугай камер, зураг авахад асдаг флаш гэрлийн тохиргоог хэлж чадна. Жишээлбэл: Ухаалаг гар утас нь GPS-ийн (Global Positioning System - Дэлхийн байршил тогтоох систем) байршлын мэдээллийг авсан зураг дээрээ суулгаж байдаг. www.linangdata.com веб хуудсанд байрлах EXIF data viewer хэсэгт сонирхол татсан зургийг оруулж тухайн зургийг авсан төхөөрөмжийн нэр марк дугаар, он сар өдөр цаг минут, хаяг байршил (зураг дарах үед GPS асаалттай байсан тохиолдолд) зэрэг мэдээллийг харах боломжтой.



Зураг: Дээрх зургийг жишээ болгон ашиглав.

Мөн энгийн хэрэглэгч ч гэсэн заримдаа хаана, хэзээ ямар файл үүсгэсэн эсвэл хэзээ зураг авснаа санах хэрэгтэй болдог шүүдээ. Гэхдээ нөгөө талаас авч үзвэл мета өгөгдлийн хамгаалалт байхгүй тохиолдолд гэмт этгээд таны мета өгөгдлийн мэдээллийг авч, таны эсрэг ашиглах боломжтой юм.

Жишээлбэл, гэмт этгээд кибер халдлага хийх хэрэгслээ сонгохдоо хохирогчийн ашиглаж байгаа программ хангамжийн нэр, хувилбар болон ашигладаг төхөөрөмжүүдийн талаарх бусад мэдээллийг олж авах шаардлагатай болдог. Таны нийгмийн сүлжээнд тавьсан жирийн нэг зураг гэмт этгээдэд дээрх мэдээллүүдийг өгч энэ хорт санаа бодлоо амжилттай хэрэгжүүлэхэд нь тусалж байж болох юм.

Ашигласан материал

1. Эрүүгийн мөрдөгч: гарын авлага төсөл 2023 он
2. <https://www.kaspersky.com>
3. <https://www.cisco.com>
4. <https://www.crowdstrike.com>
5. <https://www.csoonline.com>

**ХҮҮХДИЙН ГЭМТ ХЭРГИЙН ХОЛБОГДОХ, ХОХИРОГЧ
БОЛОХОД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛҮҮД**
FACTORS INFLUENCING CHILD CRIME INVOLVEMENT AND VICTIMIZATION

Б.Баярболд

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн
багш, цагдаагийн ахлах дэслэгч
/хууль зүйн магистр/

Bayarbold B.

Police school at University of Internal Affairs,
Department of criminal law and criminology,
lecturer, police senior lieutenant
/master of law/

Хураангуй: Монгол улсад сүүлийн жилүүдэд хүүхдийн эсрэг үйлдэгдэх гэмт хэргийн тоо өсөн нэмэгдэж, түүнтэй тэмцэх талаар олон төрлийн ажил, арга хэмээг төрийн зүгээс хэрэгжүүлэх хэдий ч гэмт хэргийн гаралтад тухайлан өөрчлөлт гарахгүй байна. Хууль, эрх зүйн хүрээнд тухайн төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх тухай зохицуулалтыг хийж байгаа нь сайшаалтай хэдий ч урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хэрэгжүүлэхэд, гэмт хэргийн хохирогч болоход чухамхүү юу нөлөөлж байгааг судлан харуулахыг зорьсон.

Abstract: In Mongolia, the number of crimes committed against children has been increasing in recent years, and despite the implementation of various measures and measures by the government, there is no change in the crime rate. Although it is commendable that regulations are being made to combat this type of crime within the framework of the law, it is intended to study and show what exactly affects the implementation of preventive measures and becoming a victim of crime.

Түлхүүр үг: Хүүхдийн гэмт явдал, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүрээлэл, гэр бүлийн хараа хяналт, эрх зүйн мэдлэг, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Keywords: Child crime, crime against children, circle and family supervision, legal knowledge and preventive measures

Бидний амьдарч буй нийгмийн нэгэн гол эд эс болох хүүхдийн эрхийг хамгаалж буй хамгийн гол баримт бичиг нь Нэгдсэн үндэстний байгууллагаас баталж гаргасан Хүүхдийн эрхийн тухай конвенц юм. Энэхүү конвенцод хүүхэд гэж хэнийг хэлэх, тэд ямар эрх эдлэх, тэдгээр эрхийг эдлэхэд төр ямар үүрэгтэйг тайлбарласан байх ба хүүхдийн бүх эрх хоорондоо салшгүй холбоотой, бүгд эн тэнцүү ач холбогдолтой, тэдгээрийг хүүхдээс булаан авах эрх хэнд ч байхгүй гэдгийг тунхагласан хамгийн гол баримт бичиг юм.

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэм хэмжээ, заалтуудыг Дэлхийн олон улс орны засгийн газар, төрийн бус байгууллагууд, хүний эрхийн зүтгэлтнүүд, хуульчид, эрүүл мэндийн мэргэжилтнүүд, боловсрол ба хүүхдийн хөгжлийн мэргэжилтнүүд, шашны зүтгэлтнүүд хамтран 10 гаруй жилийн хугацаанд хэлэлцэн зөвлөлдөж 1989 онд баталсан

байдаг. Уг баримт бичигт 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэж тодорхойлсон байх ба тухайн хүүхдэд амьдрахад шаардлагатай наад захын баталгааг хүүхдийн эрх гэсэн ойлголтоор томъёолсон. Иймд хүүхэд бүр ямар ч алагчлалгүйгээр хүүхэд хамгааллын тусламж, үйлчилгээ хүртэх, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж, бие хүн болж төлөвших, авьяас, чадвараа бүрэн дүүрэн нээн хөгжүүлэх боломжоор хангагдаж, аз жаргал, хайр энэрэл, ойлголцол бүрдсэн орчинд өсөн торних зэрэг нь хүүхэд бүрт байх ёстой наад захын баталгаа буюу эрх юм.

Хүүхдийн эрхийн тухай Монгол улсын хуулиар Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх, хүүхдийн хөгжих эрх, хүүхдийн хамгаалуулах эрх, хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрхийг баталгаажуулсан байдаг. Тэгвэл бодит байдал дээр эдгээр эрхийн хэрэгжилт зохих түвшинд хүрч чадаж байгаа эсэх, хамгийн их зөрчигдөж байгаа эрх мөн хүүхдийн эрхийг хамгаалах явдалд төрийн байгууллагуудын оролцоо хэр чухал болохыг харуулахад илтгэлийн зорилго оршино.

Хүүхэд гэдэг бол эцэг эхийн өмч биш. Мөн зөвхөн тусламж дэмжлэг авахаас цаашгүй чадваргүй хүмүүс биш. Хүүхэд бол юун түрүүнд бусдын адил хүн, тиймээс өөрийн гэсэн хүний эрхээ эдлэх ёстой. Орчин үед хүүхдийг гэр бүл, олон нийтийн бие даасан гишүүн, насандаа тохирсон эрх, үүрэг бүхий хувь хүн гэдэг талаас нь харах болсон. Хүүхдийн эрхийг ийнхүү хүлээн зөвшөөрөх нь хүүхдийг бүхэлд нь авч үзэх боломж олгосон ба мөн хүүхэд бүрт тулгамдаад буй эрэлт хэрэгцээг тэдний хууль ёсны хүний эрх хэмээн үзэх болсон. Өмнө нь тусламж, дэмжлэг хүртэгч идэвхгүй бүлэг хэмээн хүүхдийг үздэг байсан бол одоо хүүхэд эрх эдлэгч болсон байна. Тэгвэл энэ байдал нь тэдний эрх зөрчигдөх үндсэн нөхцөлийг бүрдүүлээд байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

2.1 Хүүхдийн эрх, аюулгүй байдлын тухай

Хүүхдийн эрх зөрчигдөхөд хүргэдэг гол шалтгааны нэг нь тухайн хүүхдийн амьдарч буй орчин юм. Ямар орчинд төрж хүмүүжсэнээс хамааран хүүхдийн ирээдүйн амьдрал болон зөв хүн байх тэр дундаа нийгмийн сайн бүтээгдэхүүн болох зэрэг нь ихээхэн шалтгаалдаг. Тиймээс хүүхдийн эрхийг түүний амьдарч буй орчин тойронд хангах нь зүй ёсны асуудал юм. Өөрөөр хэлбэл 1000 өдрийн аялал 1 өдрийн аяллаас эхэлдэг шиг хүүхдийн эрхийг хангах асуудал нь тухайн хүүхдийн амьдарч буй орчны аюулгүй байдлаас эхэлдэг.

Хүүхдийн амьдарч буй орчин нь /living condition/ тэдний эрүүл мэнд, сэтгэл зүй болоод ирээдүйд ямар хүн болж төлөвшихөд том нөлөө үзүүлдэг. Тиймээс гэр бүл бүр орон сууц, орчин нөхцөлийн стандартыг баримтлан хүүхдээ эрүүл аюулгүй, тохилго ногоон байгууламж, цэвэр цэнгэг агаар бүхий газар өсгөж торниулах нь бидний үүрэг болж байна. Английн судлаач Lisa Harker болон Shelter нарын хамтран гаргасан "Chance of a lifetime" (COAL) судалгаагаар орчны нөхцөл тааруухан газар амьдарч буй хүүхдийн ирээдүйн эрүүл мэнд муу байх болон хойшид хөдөлмөрийн чадвараа алдах магадлал 25%-аар их байх нь тогтоогдсон байна. Түүнчлэн хүүхэд стандартын шаардлага хангаагүй орчинд өсөн торнисноор менингит, астма, зүрхний өвчлөлтэй болох магадлал ихэсдэг төдийгүй сурах чадвар, зан төлөв, ирээдүйд ажил эрхлэх чадвар зэрэгт ч сөргөөр нөлөөлдөг¹⁴ байна.

Иймд хүүхдийн аюулгүй байдлыг “Хүүхдийн эрхийн конвенц”, “Хүүхдийн эрхийн аюулгүй байдлыг хангах протокол” зэргээр хамгаалдаг. Тус баримт бичигт тодорхойлсноор

¹⁴ <https://info.ncd.mn/blog/>

“хүүхдийн аюулгүй байдал гэдэг бол хүүхдийг бүх хэлбэрийн зүй бус харьцаа, мөлжлөгөөс хамгаалах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах бидний нийтлэг үүрэг хариуцлага юм”¹⁵ гэж тодорхойлсон байдаг. Тиймээс хүүхдийг аюулгүй орчинд аюулгүй байдлыг нь ханган амьдруулах нь хүүхдийн эрхийг хангаж буй баталгаа юм.

2.2 Гэмт хэргийн шалтгаан, хүчин зүйл, түүнд ногдуулах хариуцлагын механизм

Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг нийгмийн болон биологийн олон талын анализ, харьцуулсан судалгаа үр дүнд тулгуурлан тодорхойлсон байдаг. Тухайлбал Farrington нь эрсдэлт хүчин зүйлийг “гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх эхлэл тавигдах, давтамж, үргэлжлэх хугацааны эрсдэлийг нэмэгдүүлж байдаг урьдач нөхцөл байдал” хэмээн тодорхойлдог¹⁶. Үүнд:

*Хувь хүний эрсдэлт хүчин зүйлс*¹⁷. Хүүхэд залуучуудын хувьд тодорхой зохисгүй ааш хэмжээнд авир гаргах, сайн муу үр дагавраас үл хамааран шинэ, сонирхолтой гэсэн зүйлсийг туршиж үзэх, хувь хүний бие даасан байдлыг эрэлхийлэх зэрэг нь тэдний хувьд түгээмэл байдаг. Харин зан байдлын хувьд асуудалтай, сэтгэл зүйн эсвэл сэтгэцийн ямар нэгэн эмгэгтэй, хичээл сурлагадаа муу байх тохиолдолд цаашид гэмт хэрэг үйлдэх, нийгмийн эсрэг зан үйлтэй болох эрсдэл өндөр байдаг.

Судалгаанаас харахад дор дурдсан эрсдэлт хүчин зүйлс нь хүүхэд, залуучуудыг гэмт хэрэг үйлдэх эрсдэлт зан үйлийг бий болгоход хамгийн их нөлөөлдөг гэж үздэг байна. Үүнд: хэт идэвхтэй, хөдөлгөөнтэй, өөрийгөө хянах чадвар сул, огцом түргэн зантай, асуудал шийдвэрлэх болон хийсвэр ойлголтыг төсөөлөн бодох чадвар сул, бусдыг ойлгох чадвар сул, сурлага тааруу, танин мэдэхүйн ур чадвар бага хөгжсөн, суралцах ур чадварын бэрхшээл, сэтгэцийн эмгэгүүд зэрэгт хүчин зүйлүүд хамаарч байна.

*Нийгмийн эсрэг эрт үеийн зан үйл*¹⁸. Litschge Wasserman нарын үзэж буйгаар өсвөр насныхны хүүхдүүдийн үзэж буй түрэмгийлэл, зөрчил, хүчирхийлэл зэрэг нийгмийн эсрэг зан үйлийг сурталчилсан зүйлүүд тухайн хүүхдүүдийн цаашдынх нь амьдралд асар их нь нөлөө үзүүлдэг. Нийгмийн эсрэг зан үйл нь эрт үед буюу бага насанд илрэх тусмаа насанд хүрээд гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг маш их нэмэгдүүлж байдаг бол бага наснаасаа эхлэн байнгын түрэмгий зан үйл илэрхийлэн гаргаж байвал 13 нас хүрэхээсээ өмнө гэмт хэрэг, зөрчил үйлдэх эрсдэлтэй гэдгийг цорын ганц шинж хэмээн тайлбарлажээ.

Tornberry-гийн судалснаар 13 нас хүрэхээсээ өмнө гэмт хэрэг, мөн зөрчил үйлдсэн бол ноцтой, хор уршиг ихтэй, хүчирхийллийн гэмт хэрэгтэн болох эрсдэл маш өндөр байх бөгөөд бусад насны бүлэг буюу 13 наснаас хойш гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүмүүсээс илүү эрсдэлтэй байдаг. Өсвөр насныхны хувьд нийгмийн тогтсон хэм хэмжээг зөрчих, нийгмийн эсрэг үйлдэл хийх нь хэвийн үзэгдэл байдаг ч бага наснаасаа байнгын, ноцтой, хор уршиг ихтэй хүчирхийллийн зан үйлийг хийж буй илрэл нь цаашлаад гэр бүлээсээ холбоо тасрах, эсхүл тэднийг бусниулах, сонгууль өгөх зэрэг улс төрийн оролцооны эрхээ эдэлж чадахгүй болох, ажилгүйчүүдийн эгнээнд орох, мансуурах бодист хамааралтай болох гэх мэт эрсдэлүүдийг агуулж байдаг.

Lösel болон Bender нарын судалснаар бага насандаа нийгмийн хэм хэмжээг зөрчсөн зан үйл бүхий үйлдэл хийсэн хүүхдүүдийн гуравны нэг нь насанд хүрээд хор хохирол ихтэй

¹⁵ <https://www.savethechildren.mn/uploads/publication/201805/>

¹⁶ Өсвөр насны хүүхэд, залуусын дундах дээрэлхэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалтын гарын авлага., УБ., 2022 он., 16 дах тал

¹⁷ Мөн тэнд

¹⁸ Мөн тэнд

гэмт хэрэг үйлдэх, хүчирхийлэгч болох эрсдэл нэмэгдэх болон сэтгэцийн бусад асуудлууд үүсдэг байна.

Promising Practices Network on Children Families and Communities-ын судалгаанаас харахад бага насанд бий болдог нийгмийн эсрэг зан үйл нь дараах 3 үндсэн хүчин зүйлээс шалтгаалдаг гэх судалгаа байдаг. Үүнд:

Нэгдүгээрт. Үр хөврөлийн үе дэх мэдрэлийн хөгжлийн эмгэг. Тухайлбал архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээтэй эхээс төрсөн хүүхдүүд энэ төрлийн эмгэгт өртөх нь түгээмэл байдаг.

Хоёрдугаарт. Эцэг эхийн хүүхдээ гэх асрамж, халамж дутуу, хүүхэдтэйгээ эрүүлээр харилцах харилцаа сул, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлдэггүй байх зэрэг хүчин зүйл.

Гуравдугаарт. Эхийн амьдралын үе шат, хөгжлийн асуудлыг авч үздэг. Улсын халамжид байдаг, гэрлээгүй, эсхүл нөхөргүй, дунд сургуульд сураагүй, эсвэл гурав болон түүнээс дээш хүүхэдтэй эхээс төрсөн хүүхдүүд зан үйлийн асуудалтай байдаг зэрэг хүчин зүйлүүд ордог байна.

Хэт хөдөлгөөнтэй/идэвхтэй байх (hyperactivity). Судалгаануудаас харахад хүүхэд хэт хөдөлгөөнтэй буюу Хэт идэвхжилтэй байх нь насанд хүрээд зөрчил гаргах, гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг нэмэгдүүлж байдаг хэмээн таамагладаг. Түүнчлэн энэ нь Анхаарал дутмагшил, хэт хөдөлгөөнт эмгэгтэй (ADHD) хавсрах тохиолдолд хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэх эрсдэл маш өндөр байдаг. Энэхүү сэтгэлзүйн эмгэг нь хүүхдийн сурах явц (хичээлдээ төвлөрөх, хийсвэр ойлголтыг ойлгохгүй байх гэх мэт), танин мэдэхүйн чадвар, үе тэнгийнхэнтэйгээ харилцаа хэвийн холбоо тогтоох зэрэгт сөргөөр нөлөөлөх, түрэмгий зан байдлыг улам өдөөж өгснөөр хүүхдийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд шууд бусаар нөлөөлж байдаг. Сэтгэлзүйн, танин мэдэхүйн, зан үйлийн зэрэг эрсдэлт хүчин зүйлсийн адил хэт хөдөлгөөнтэй байх нь дангаараа гэмт хэрэг, зөрчил үйлдэх шалтгаант нөхцөл болохгүй ч шууд бусаар хүүхдэд энэ төрлийн хэв шинжүүдийг бүрдүүлэхэд нөлөөлдөг.

Өөрийгөө хянах чадвар сул, хэт цочмог түргэн зан авир. Farrington-bl үзэж буйгаар хэт цочмог зан авир, түргэн ууртай байх шинж тэмдэг нь гэмт хэрэг үйлдэхэд томоохон түлхэц болдог хүчин зүйл юм. Судалгаануудаас харахад хүүхэд эрт үедээ буюу бага насандаа хэт цочмог, түргэн уурлах зан байдлаа илэрхийлэх нь цаашлаад нийгмийн хэм хэмжээг зөрчих, архи, мансууруулах бодис хэрэглэх, гэмт хэрэг үйлдэх эхний алхам болдог гэж үзжээ. Хэт цочмог, түргэн зан авиртай хүүхдэд орчны сөрөг нөлөөлөл нэмэгдвэл насанд хүрэхээсээ гэмт хэрэг, зөрчил үйлдэх эрсдэлийг бий болгодог байна.

Асуудал шийдвэрлэх болон хийсвэрлэн бодох чадвар сул байх. Хүүхэд өөрийнхөө аливаа үйлдлийг шүүн тунгааж, бүтээлчээр сэтгэн, асуудал шийдвэрлэх чадваргүй байх, өөрийн хийсэн үйлдлийн үр дагаврыг ойлгохгүй байх, мөн эерэг үр дүнд хүрэх үйлдэл хийх эрмэлзэл, чадваргүй байх зэрэг багтдаг. Өөрөөр хэлбэл бодож тунгаах болон үйлдэл хийх хоёр нь хоорондоо уялддаггүй гэсэн үг юм. Судалгаануудаас харахад ихэнх давтан гэмт хэрэгтэн, зөрчил үйлдэгчид нь өөрсдийн үйлдлийн үр дагаврыг боддоггүй, хэт цочмог, түргэн зан авиртай, шаардлагагүй эрсдэлийг өөртөө үүрч байдаг. Танин мэдэхүйн болон зан үйлийн эдгээр эмгэгүүд сул нь учир асуудал шийдвэрлэх чадвар, асуудлын шалтгааныг тунгаах чадваргүй эсвэл боломжит бодохыг хүсдэггүй, шийдлийг эрэлхийлдэггүй, аливаа асуудлыг эергээр шийдвэрлэх чадваргүй зэрэгтэй холбон авч үзжээ.

Бусдыг ойлгож, мэдрэх сэтгэлгүй байх (empathy). Бусдыг зөвшөөрөх, ойлгох, тэдний хүлээн оронд өөрийгөө тавьж үзэх хүсэлгүй эсвэл чадваргүй байх нь хүүхэд залуучуудын дунд гэмт хэрэг, зөрчил үйлдэх, хүчирхийлэл үйлдэх эрсдэлт хүчин зүйл болдог. Өөрөөр хэлбэл ихэнх гэмт хэрэгтнүүд өөрийгөө ямагт нэгдүгээрт тавьдаг, бусдыг ойлгож энэрэх

сэтгэл байдаггүй, бусдын оронд өөрийгөө тавьж бодож үзэх, асуудлыг өөр талаас нь тунгаах чадваргүйгээс гадна бусдын үг, үйлдлийг ташаа ойлгох нь түгээмэл байдаг. Мөн бусдын санал бодол, мэдрэмжийг ойшоож үздэггүй, ойлгох чадваргүй байх нь бусадтай таагүй харилцаатай байх, тэдний зан үйл хүмүүст таагүй мэдрэмж, үр дагавар бий болгодог. Эдгээр хүмүүс нь ерөнхийдөө харилцааны ур чадвар муу, хүнтэй харц тулгарах, нүд рүү нь харж ярихаас зайлсхийдэг, бусдыг сонсох, тэдэнд анхаарал хандуулахыг хүсдэггүй байдгаар илэрдэг. Ихэнх тохиолдолд сургууль завсардсан хүүхдүүд өөртөө итгэлгүй, бусдад хаягдсан мэт мэдрэмжтэй үлддэг бөгөөд энэ нь цаашлаад ур чадвар, мэргэжил боловсрол эзэмшиж амжилтад хүрэх боломжгүй санагдаж, бусад гэмт зан үйл бүхий хүүхдүүдтэй найзалж, нөхөрлөж эхэлдэг.

Сэтгэцийн эрүүл мэнд болон архи, мансууруулах бодисын хэрэглээ. Сэтгэцийн эмгэгүүд нь гэмт хэрэг, хүчирхийлэл үйлдэх, давтан гэмт хэрэг, зөрчил гаргах болон гудамжинд гарах, архи, хар тамхи хэрэглэх гэх мэт бусад эрсдэлүүдийг нэмэгдүүлж байдаг.

Гэр бүл (эцэг, эхийн)-ийн эрсдэлт хүчин зүйлс. Гэр бүлийн орчин нь хүчирхийлэгч, гэмт үйлийг зан бий болгоход нөлөөлдөг хамгийн том эрсдэлүүдийн нэг болдог. Гэр бүлийн орчин, эцэг эхийн хүмүүжил, харилцааны арга барил нь хүүхэд ирээдүйд гэмт хэрэгтэн, хүчирхийлэгч болох эсэхэд ихээхэн нөлөөлдөг. Хүүхэд нь гэмт хэрэгтэн, хүчирхийлэгч болох эрсдэлтэй гэр бүлд эцэг эх нь нийгмийн эсрэг эсвэл гэмт зан үйлтэй, хүүхэд хүмүүжүүлэх арга барилгүй (хараа хяналт тавьдаггүй, хүйтэн хөндий харилцаатай, хүүхдээ үл хайхардаг), бие махбодын шийтгэл оногдуулдаг, хүүхдийнхээ хийсэн буруу зүйлд өөр өөрөөр хариу үйлдэл үзүүлдэг, хүүхдээ хүчирхийлдэг, тэдэнтэй зүй бус харьцдаг, хүүхдээ үл тоомсорлох зэрэг зэрэг хэв шинж байна¹⁹.

Сургуулийн эрсдэлт хүчин зүйлс. Сургууль нь хүүхдийг нийгэмшүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг нөгөө талаас хүүхдийг нийгэмд харш зан үйл төлөвшүүлэхэд нөлөөлж байдаг. Олон сурагчтай, цөөн багштай сургуулийн хувьд багш нар хохирогч болох нь түгээмэл байдаг багш Мөн дотоод дүрэм журам нь хэрэгждэггүй, удирдлагын хамтын хоорондын ажиллагаа сул сургуулиудад багш нар хохирох үзэгдэл их байдаг бөгөөд багш нар сэтгэл дундуур байх нь хүүхдэд хүмүүжлийн доголдол бий болоход нөлөөлдөг байна. Мөн түүнчлэн дүрэм, журмаа хэрэгжүүлж чадахгүй байх нь цаашлаад зарим сурагчид хохирогч болох эрсдэлийг бий болгодог байна.

Оршин суугаа газар, орон нутгийн эрсдэлт хүчин зүйлс. Гэмт хэрэг, зөрчил, хүчирхийллийн шинж чанар бүрэлдэхэд нөлөөлдөг бас нэг нийгмийн чухал хүчин зүйл нь амьдарч буй орчин, орон нутгийн нөхцөл байдал юм. Тухайн орон нутаг буюу оршин суугаа газар нь өөрөө гэмт хэргийн суурь шалтгаан болж гэмт хэргийн гаралт ихсэхэд нөлөөлдөг байна. Өөрөөр хэлбэл, тухайн амьдран сууж байгаа газрын орчин нөхцөл нь хүчирхийлэл, нийгэмд харш зан үйлийг төлөвшүүлж байдаг.

Үе тэнгийнхний эрсдэлт хүчин зүйлс. Гэмт буй нь гэмт зөрчилд хүүхэд, хэрэг, холбогдож залуучууд зөрчил хэрэг, үйлдсэн хүмүүстэй найзалж, нөхөрлөх нь түгээмэл байдаг. Өсвөр насны хүмүүсийн гэмт хэрэг, зөрчилд холбогдож буй үндсэн хоёр хүчин зүйлд: 1) гэмт зан үйл бүхий хүмүүстэй нөхөрлөх, нийлэх; 2) үеийнхнээсээ гадуурхагдах явдал багтдаг. Wasserman тэргүүтэй судлаачид дараах 3 эрсдэлт хүчин зүйлс нь өсвөр насандаа гэмт хэрэгтэн болох, улмаар давтан гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлдөг гэж үзсэн байна. Үүнд: 1) хувь хүний нийгмийн эсрэг зан үйл, хандлага; 2) үе тэнгийнхэндээ

¹⁹ Өсвөр насны хүүхэд, залуусын дундах дээрэлхэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалтын гарын авлага., УБ., 2022 он., 20 дах тал

гадуурхагдах, үл тоогдсоноос үүдсэн сөрөг үр дагавар, хандлага; 3) гэмт зан үйл төлөвшсөн тэнгийнхэнтэйгээ найзалж нөхөрлөх зэрэг хамаардаг байна.

Био – нийгмийн (biosocial) хүчин зүйлс. Орчин үеийн криминологийн судлаач Moffit биологийн болон нийгмийн орчны онолын эрсдэлт хүчин зүйлсийн хоорондын уялдаа холбоо, харилцан хамаарал нь гэмт хэрэг үйлдэгдэхэд хэрхэн нөлөөлдгийг судалсан байна. Тэрээр Амьдралын үечлэлийн онолоороо, мэдрэл-сэтгэл зүйн эмгэг (гений эсвэл тархины гэмтэл гэх мэт) болон гэр бүлийн хүчирхийлэлтэй, Эцэг эх нь гэмт зан үйлтэй, хүүхдээ үл хайхардаг гэр бүлийн орчинд өссөн хүүхэд цаашдаа архаг, ноцтой гэмт хэрэгтэн болж төлөвшдөг байна²⁰.

2.3 Хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэг, түүний нөхцөл байдал

Монгол дахь хүүхдийн эрхийн хамгийн ноцтой зөрчил бол хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үл хайхрах явдал юм. Засгийн газрын тайлагд дурдсан хууль тогтоомжууд нь хүүхдийг хүчирхийллээс ангид аюулгүй орчинд амьдрах эрхийн бүрэн баталгаа болж чадахгүй байна. Учир нь:

- Гэр бүлд болон нийгмийн бусад орчинд хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүхий л хэлбэрүүд хэвийн үзэгдэл мэт оршиж, үүнийг өөгшүүлсэн уламжлалт зан үйл хэвээр хадгалагдсаар байна.
- Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үл хайхрах явдлыг мэдээлэх, бүртгэх, хариу арга хэмжээ авах тогтолцоо байхгүй байна. Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах төв, хүчирхийллийн эсрэг үндэсний төв гэдэг төрийн бус 2 байгууллага л энэ чиглэлээр ажиллаж байгаа ба мэргэшсэн төрийн байгууллага, алба байхгүй байна.
- Зөвхөн хүүхдийн амь нас хохирсон, маш ноцтой гэмтэж, бэртэж эмнэлгийн болон хууль хяналтын байгууллагаас тусламж, дэмжлэг авсан тохиолдол л бүртгэгдэж байна.
- Дундговь, Төв, Сэлэнгэ, ховд зэрэг дөрвөн аймаг, Улаанбаатар хотод эмэгтэйчүүд, хүүхдийг хамгаалах цөөн ортой байр ажиллаж байна. Бусад аймаг, суманд яаралтай тусламж авч, хамгаалагдах шаардлагатай хүүхэд, эмэгтэйчүүдийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй хэвээр байна.

Хүүхдүүд ихэнх цагийг гэр бүл, сургуулийн орчин болон найз нөхдийн хүрээлэлд өнгөрөөж байх ба хүүхдийн эрхэнд халдсан гэмт хэрэг, зөрчил зэрэг нь олон төрлийн субъектээр үйлдэгдэх бол түүнээс ихэвчлэн үе тэнгийнхний зүгээс болон сургуулийн орчинд үйлдэгдэж байгаа явдал их байна. Үүний шалтгаан нь бусдын эрхийг зөрчиж буй үе тэнгийнхэн болон хамт суралцаж буй үе тэнгийнхэн нь хэд хэдэн хүчин зүйлээс хамааран зөрчил, гэмт үйлдлийг үйлдэж байна.

Оросын Холбооны Улсын Эрүүгийн хуулийн хорь дугаар бүлэгт “Насанд хүрээгүй хүний эсрэг гэмт хэрэг” буюу хүүхдийн эсрэг гэмт хэргийг насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэгт татан оролцуулах, насанд хүрээгүй хүнийг нийгэмд харш үйл ажиллагаанд татан оролцуулах, насанд хүрээгүй хүүхдээр согтууруулах ундаа худалдаалуулах, насанд хүрээгүй хүнийг амь насанд нь аюул учруулж болзошгүй үйлдэл хийхэд татан оролцуулах, хүүхдийг солих, хүмүүжүүлэх үүргээ эс биелүүлэх зэргээр зүйлчилсэн байдаг бол Бүгд Найрамдах Хятад Ард Улс нь эрүүгийн хууль дах гэмт хэргүүдийн хүндрүүлэх нөхцөл байдалд хүүхдийн эсрэг хэмээн тусгасан байна.

Харин Монгол Улсын хувьд Эрүүгийн хуулийн арван зургаадугаар бүлэгт “Хүүхдийн эсрэг гэмт хэрэг”-ийг оруулсан байх бөгөөд тус бүлэгт хүүхдийг гэмт хэрэг

²⁰ Мөн тэнд

үйлдэхэд татан оруулах, согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах, хаяр, төөрүүлэх, гуйлга гуйлгах, солих, худалдах, хэрцгий харьцах, садар самууныг сурталчлах, тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх, асран хамгаалах үүргээ үл биелүүлэх зэргээр 11 төрөл зүйлийн гэмт хэргийг зааж өгснөөрөө хүүхдийн эрхийг зөрчигдөхөөс сэргийлж байна.

Мөн түүнчлэн Эрүүгийн хуулийн 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй тодорхой төрлийн гэмт хэрэгт оногдуулах хариуцлагыг илүү хүндрүүлсэн.

Насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдэх гэмт хэрэг нь ерөнхийдөө хүүхдийн эрх, эрх чөлөө тэр дундаа хүүхдийн хүмүүжил төлөвшилд, бие махбод, түүний хөгжилд сөргөөр нөлөөлсөн, ёс суртахуун, оюун санааны хөгжил, хувийн болон гэр бүлийнх нь ашиг сонирхол зэргийг хохироосон, амьд явах эрх, эрүүл мэндийн халдашгүй байдалд шууд нөлөөлөхүйц үйлдлүүд байх ба гэмт хэрэг үйлдсэн хүн хийж буй үйлдлээ хууль бус болохыг ухамсарлан гэм буруугийн санаатай хэлбэрээр буюу хүсэж үйлдсэн байхыг ойлгож болно.

Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгэмд аюултай шинж чанарыг ухамсарлаж, түүнээс учирч болох нийгэмд аюултай хор уршгийг урьдаас мэдсээр атал хүссэн, эсвэл хүсээгүй боловч тэр хор уршигт зориуд хүргэсэн байхыг гэм буруугийн санаатай хэлбэр гэнэ. Хүсэж үйлдэх гэдэгт гэмт этгээд өөрийн үйлдлээр тодорхой нэг хор уршгийг учруулахыг хүсэж, түүнийг өөрийн оюун ухаан, сэтгэхүйд дүрслэн, чухамхүү тэр хор уршгийг учруулахад өөрийн гэмт санаа бодол, үйл ажиллагаагаа чиглүүлэхийг ойлгох бөгөөд тэр хор уршгийг учруулах нь гэмт этгээдийн хувьд хүсэл эрмэлзлэл, гэмт хэрэг үйлдэх зорилго нь болсон байдаг. Ийм учраас гэм буруугийн шууд санаагаар үйлдэгдэх гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын үндсэн шинж нь гэмт хэрэг үйлдсэн зорилго байдаг²¹.

2019 онд гэмт хэргийн улмаас 30,782 иргэн хохирсноос 5.19% буюу 1598 нь 18 насанд хүрээгүй хүн байна. 2019 онд хохирсон иргэдээс 3,7% буюу 1137 сурагч, 0.03% буюу 11 сургууль завсардсан хүүхэд байна. Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүүхэд 2019 онд өмнөх оноос 144-өөр өссөн үзүүлэлттэй байна. Дээрх судалгаанаас үзэхэд, 2018 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 796 хүн хохирч үүнээс 6.4% буюу 51 нь насанд хүрээгүй хүн, 2019 онд 7.2% буюу 65 насанд хүрээгүй хүн хохирсон байна. Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогчоор 2019 онд 359 хүүхэд, 2020 онд 333 хүүхэд тус төрлийн гэмт хэргийн хохирогчийн 66.3% ийг хүүхэд эзэлж байна. Хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирсон 406 хүний 248 буюу 61.1% ийг хүүхэд эзэлж байна²². 2020 оны байдлаар гэмт хэргийн улмаас 1181 хүүхэд хохирч, 99 хүүхэд нас барж, 516 хүүхэд гэмтсэн. Эрүүгийн хуулийн тусгай ангийн арван зургаадугаар бүлэгт “Хүүхдийн эсрэг гэмт хэрэг” гэж тусгайлан заасан ба тус гэмт хэрэг нь 2019 онд 31, 2020 онд 27, 2021 онд 7, 2022 онд 8 гэмт хэрэг тус тус гарсан байна²³.

График №8. Монгол улсад бүртгэгдсэн Хүүхдийн эсрэг гэмт хэрэг /2018-2022 он/

²¹ Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги., С.Гантулга, Б.Энхболд., УБ., 2020 он. 246-247дах тал

²² Өсвөр насны хүүхэд залуусын дундах дээрэлхэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх модуль сургалтын гарын авлага., УБ., 2022 он., 23 дах тал

²³ [ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД 2021 ОНЫ ЭХНИЙ 11 САРД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ \(police.gov.mn\)](https://www.police.gov.mn)



Гэмт хэргийн төрлөөр нь үзвэл:

График №9. Хүүхдийн эсрэг гэмт хэргийг төрлөөр нь үзвэл /2018-2022 он/²⁴



Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэгт заасан Хүүхдийн эсрэг гэмт хэргийн төрлөөр нь авч үзэхэд дээрх 2 төрлийн гэмт хэрэг түлхүү үйлдэгдэх бөгөөд улсын хэмжээнд Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэргийн гаралт 24-өөр өссөн байгаа тул тухайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах шаардлагатай байна.

Дээрх судалгаанаас үзэхэд насанд хүрээгүй хүн буюу хүүхдийн эсрэг үйлдэгдэх гэмт хэрэг нь хэдий цөөн тоогоор үйлдэгдэж байгаа мэт харагдах боловч эрүүгийн хуулийн арван зургаадугаар бүлгээс бусад гэмт хэргүүдийн хохирогчдын хүн ам зүйн судалгаанаас харахад хүүхдэд гэмт хэргийн хохирогч болж байгаа тохиолдол их байх ба үзүүлэлт дорвитой буурах хандлага ажиглагдахгүй байна.

ДҮГНЭЛТ

Монгол улсын хувьд үндсэн хуульд зааснаар төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээсэн ёсоор хүүхдийн эрхийн тухай конвенц, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхдэд хамгааллын тухай хууль, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль зэргээр хүүхдийн эрхийг хамгаалдаг. Мөн түүнчлэн эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэгт тусгайлан хүүхдийн эрхийн эсрэг үйлдэлд, мөн хүүхдийн эсрэг үйлдэгсэн бусад төрлийн гэмт хэрэгт хүлээлгэх харицлагыг чангатгасан зохицуулалт шинэчлэн батлагдаж, хүүхдийн эрхийг хамгаалж байна.

Гэвч хүүхдийн эсрэг үйлдэгдэх гэмт хэргийн болон өөрсийнх нь үйлдэж буй гэмт хэргийн тоо буурахгүй байгаа нь асуудал дагуулж байна. Эрүүгийн хуульд насанд хүрээгүй хүүхдэд хүлээлгэх хариуцлагын хэмжээ насанд хүрсэн хүнд оногдуулах хариуцлагаас 2 дахин бага байдаг ч асуудлын учир шалтгаан нь гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх ажил хангалттай бус байгааг илтгэж байна.

Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд зөвхөн хууль хяналтын байгууллагын оролцоо, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хуулийн боловсронгуй

²⁴ [Статистик тоон мэдээлэл \(police.gov.mn\)](http://police.gov.mn)

зохицуулалт шаардлагаас гадна гэр бүлийн оролцоо, багш, сурган хүмүүжүүлэгчийн үлгэрлэл зайлшгүй шаардлагатай байна.

Криминологийн социологийн онолын үндсэн үзэл баримтлал “Хүүхэд бол цагаан цаас, хэнээс төрөхөөс үл шалтгаалж хаана, хэний дэргэж өсөж, хүмүүжиж байгаагаас ирээдүй нь шалтгаална” хэмээсэн байдаг. Тэгэхлээр хүүхдийн гэмт явдлыг таслан зогсооход нийгмийн факторуудыг илүү нарийн судалж, хүүхдэд чиглэсэн ажил арга хэмжээг эрчимжүүлэхэд анхаарах асуудал нэн чухал шаардлагатай байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. С.Гантулга., Б.Энхболд., Эрүүгийн эрх зүй тусгай анги., УБ. 2020он.
2. Өсвөр насны хүүхэд, залуусын дундах дээрэлхэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалтын гарын авлага., УБ., 2022 он.
3. [Статистик тоон мэдээлэл \(police.gov.mn\)](http://police.gov.mn)
4. <https://info.ncd.mn/blog/>
5. <https://www.savethechildren.mn/uploads/publication/201805/>
6. [ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД 2021 ОНЫ ЭХНИЙ 11 САРД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ \(police.gov.mn\)](#)

МОНГОЛ УЛС ДАХЬ АМИА ХОРЛОХ ҮЙЛДЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

SITUATION OF SUICIDE IN MONGOLIA

ДХИС-ийн магистрант Б.Алтангэрэл.
University of Internal Affairs of Mongolia,
master's student. B.Altangerel

Хураангуй: Амиа хорлох үйлдлийн талаар дэлхийн болон Монгол Улс дахь нөхцөл байдал, амиа хорлох үйлдлийн төрөл, үйлдлийн арга, тоон үзүүлэлт, тэдгээрт хийсэн дүн шинжилгээ, амиа хорлох үйлдэл хийсэн хүний сэтгэл зүй, зан үйлийн хэв шинж, нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар судалж, цаашид амиа хорлох үйлдээс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлохыг зорьсон.

Abstract: The situation of suicide in the world and in Mongolia, the types of suicide, methods of suicide, quantitative indicators, their analysis, the psychology and behavioral patterns of people who commit suicide, and the influencing factors are studied. , aimed to identify ways to prevent future suicides.

Түлхүүр үгс: Амиа хорлолт, сэтгэл гутрал, сэтгэцийн эмгэг, амиа хорлохыг завдах, амиа хорлох арга, төрөл

Key words: Suicide, depression, mental illness, suicide attempts, methods and types of suicide

Оршил. Монгол Улс төдийгүй дэлхийн улсуудад амиа хорлох үйлдэл сэтгэл эмзэглүүлсэн асуудал болоод зогсохгүй өнөөгийн нийгэмд ч бид эмзэглэн хүлээн авахаа нэгэнт больж байх ёстой хэвийн үзэгдэл мэт хүлээн авах болжээ. Энэ үзэгдлийг цогцоор нь судалж, урьдчилан сэргийлэх, хүний амь эрсдэхээс хамгаалах үйлдэл амин чухал асуудал болоод байна.

ДЭМБ-ын тайланд дурдсанаар 2001 онд дэлхийн хэмжээнд сэтгэцийн эмгэгтэй хүний тоо 450 сая орчим байсан бол 2017 онд 792 сая хүн буюу нийт хүн амын 10.7% (10 тутмын 1 нь) сэтгэцийн ямар нэгэн эмгэгтэй гэжээ. Үүнээс 284 сая нь сэтгэл түгших, 264 сая нь сэтгэл гутрах эмгэгээр шаналж байгаа талаар тайланд тусгасан.

Үндсэн хэсэг. Амиа хорлох гэдэг²⁵ нь хэн нэгэн санаатайгаар өөрийн амийг таслах төрх үйл юм. Амиа хорлох болон хорлох үйлдэл хийх нь манай улсын хувьд төдийгүй дэлхийн олон оронд нийгэм эдийн засгийн болон сэтгэц-нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Энэ үйлдэл нь анагаах ухаан, философи, нийгэм судлал, нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болохоос гадна хүн амын дунд нэмэгдэх хандлагатай байгааг олон судалгаанаас харж болно.

Тэгвэл архи, мансууруулах бодисын шалтгаант сэтгэцийн эмгэгтэй хүний тоо 970 сая буюу нийт хүн амын 13 хувийг эзлэж байна. Эндээс харахад дэлхий нийтэд сэтгэцийн эмгэгтэй болон архи мансууруулах бодисын шалтгаант эмгэгтэй хүний тоо жил ирэх тусам өсөн нэмэгдэж байна.

АНУ болон Өрнөдийн орнуудад ёс зүйн нээлттэй асуудлууд хэмээх ойлголт яригдах болсон бөгөөд энэ нь мэргэжлийн хүмүүсийн дотор маргаантай асуудлыг үүсгэдэг байна. Тухайлбал амиа хорлох үйлдлийг хуулиар зөвшөөрч болох эсэх талаарх хэлэлцүүлэг зохион

²⁵<https://mn.wikipedia.org>

байгуулах болсон. Амиа хорлох талаар эртний гүн ухаантан О.Шпенглер²⁶ “Амиа хорлолт нь соёл иргэншлийн төгсгөлийн шатны мөхлийг билэгддэг том хотын соёлын үр дагавар бөгөөд энэ утгаараа нэлээд орчин үеийн үзэгдэл мөн” хэмээн тодорхойлсон. Орчин үед амиа хорлох, амиа хорлохоор завдах үйлдлийн шалтгаан сэдэл, нөлөөлөх хүчин зүйлийг судлан тогтоох асуудал нь бие даасан шинжлэх ухааны салбар болтлоо хөгжиж байна.

Хүн амын дундах амиа хорлох үйлдлийг суицид (suicide, fatal suicide), амиа хорлохоор завдах тохиолдлыг парасуицид (parasuicide, non fatal suicide) хэмээн шинжлэх ухааны нэршлээр нэрлэдэг. Амиа хорлох үйлдэл, төрх үйл хэмээх ойлголтонд амиа хорлох бодол үүсэх, төлөвлөгөө зохиох, оролдлого хийх, амиа хорлох гэсэн ойлголт хамаардаг ба өөр хоорондоо харилцан хамааралтай үйл явц юм.

Амиа хорлох бодол гэдэг нь сэтгэц, нийгэм, сэтгэлзүй, биологийн шалтгаанаар амьд явах хэрэггүй, үхэх юмсан гэсэн бодол төрөхийг хэлэх бөгөөд энэ үед хорлох ямар нэг арга сонгоогүй зөвхөн бодол санааны түвшинд байдаг. Амиа хорлох бодол гүнзгийрсэн үед тухайн хүн амиа хорлож болох аргыг өөртөө төлөвлөдөг. Харин тодорхой аргыг сонгосон бол тухайн үйлдлийг хийх боломжтой орчин нөхцлийг хайж, тохироо бүрдсэн үед уг үйлдлээ хэрэгжүүлдэг онцлогтой. Амиа хорлох үйлдэл бүр нь үхэлд хүргэхгүй байж болох бөгөөд үүнийг завдсан хэмээн тооцдог хэдий ч зарим тохиолдолд бусдад үзүүлэх хэлбэрийн үйлдэл байдаг

Э.Дюркгейм амиа хорлох тохиолдлыг анх 1887 онд судалж нийгмийн харилцаа, түүнд оролцох байдлаар нь 3 ангилсан байдаг. Үүнд:

1. Аминч буюу эгоист амиа хорлолт - нийгмээр баримталдаг хэм хэмжээ гажуудан, амьдралд нийцэхгүй хууль, дүрэм, журам олноор батлагдах, нийгмийн халамж дутагдсаны улмаас хувь хүн нийгэм хамт олноос тасран, амьдрал нь утга учиргүй болсон мэт санагдан өөрийгөө амьдралд гарах гарцгүй болсон хэмээн амиа хорлохыг хэлнэ.

2. Хамтач буюу альтруист амиа хорлолт - хувь хүн өөрөө шийдвэр гаргах, сонголт хийх боломж, эрх чөлөө, бие даасан байдлаа алдан хувийн эрх ашиг, сонирхол нь хамтын эрх ашигт захирагдах болсноос хувь хүн тэсвэрлэшгүй байдалд орж амиа хорлохыг хэлнэ.

3. Аноми амиа хорлолт - нийгмийн бүтцийн гэнэтийн өөрчлөлт, эдийн засгийн өсөлт, уналтын улмаас хүмүүс хуучин үнэт зүйлсийн баримжаагаа алдан, шинэ үнэт зүйл нь бүрдэж амжаагүй завсрын үед нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсч, хүмүүс нийгэмд тогтсон хэм хэмжээг мөрдөхийг хүсэхгүй амиа хорлохыг хэлнэ.

Ийм үйлдэл хийж буй хүмүүсийг сэтгэцийн эрүүл мэндийн байдлаар нь харьцангуй эрүүл, сэтгэцийн эмгэгтэй хэмээн 2 ангилж үздэг боловч харьцангуй эрүүл хэмээн үнэлэгддэг хүмүүс нь нийгэм, сэтгэлзүйн тулгамдсан асуудалтай хүмүүс байдаг.

Амиа хорлох үйлдэл хийхэд биологи, нийгэм, сэтгэлзүйн хүчин зүйлс нөлөөлдөг гэж үздэг. Тухайлбал: амиа хорлосон хүмүүсийн удамд урд нь имй үйлдэл хийж байсан хүн байх, эдгэшгүй өвчнөөр өвчлөх, цаг агаарын байдал, ажилгүйдэл, хүн хоорондын харилцаа, сэтгэлзүйн хүчирхийлэлд өртөх, стресс бухимдлаа зөв тайлах, даван туулах чадваргүй байх зэрэг хүчин зүйлс хамаарна. Сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүмүүсийн амиа хорлоход хүргэж буй нөхцөл байдлыг шалтгаан гэдэг бол сэтгэцийн эмгэгийн улмаас уг үйлдлийг хийж буй шалтгааныг сэдэл гэж нэрлэдэг. Эмнэлзүйн тохироо бүрдсэн үед сэтгэцийн ямар ч эмгэгтэй хүн амиа хорлож болох боловч сэтгэцийн эмгэгүүд дотроос сэтгэл гутрал, шизофрени, архи болон мансууруулах бодисын хамааралд өртсөн, хүчтэй стрессийн улмаас сэтгэлзүйн гэмтлийн дараах хариу урвал, дасан зохицохуйн хямралд өртсөн хүмүүс илүү

²⁶ (O.Spengler der Sohnenuntergang in der Abendland)

амиа хорлох үйлдлийг хийдэг бөгөөд үйлдлийн сэдэл нь өвчний байдлаас хамааран харилцан адилгүй байдаг.

Амиа хорлоход насны байдал нөлөөлдөг бөгөөд хувь хүний насны үечлэл бүрд харилцан адилгүй сэтгэлзүйн тааламжгүй нөлөө үүсч байдаг. Тухайлбал хүүхэд амиа хорлох үйлдэл хийхэд гэр бүлийн хүмүүжлийн өв тэгш бус байдал, бага насны сэтгэлзүйн гэмтэл, амиа хорлосон хүмүүсийг дуурайх (даган дуурайх сэдэл, Вертерийн хамшинж) сэдэл нөлөөлдөг бол бага насандаа хүчирхийлэлд өртөж байсан ялангуяа бэлгийн хүчирхийлэлд өртөгсөд (14.8%) амиа хорлох эрсдэл өндөр байдаг²⁷ гэсэн судалгаа байна. Хүүхэд насны биемахбод, бэлгийн хүчирхийллийн улмаас хүүхдэд сэтгэл гутрал, сэтгэлзүйн гэмтлийн дараах хариу урвал, сэтгэл түгшилт үүсч амиа хорлох бодол үүсэх буюу тийм эрсдэлд оруулдаг²⁸.

Амиа хорлох үйлдлийн хэлбэр нь өөрийгөө боомилох, өндрөөс үсрэх, амин эрхтэн рүүгээ хугалах, галт зэвсэг ашиглах, өндөр хүчдэлд цохиулах, усанд живэх, хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгсэл доогуур санаатайгаар орох, хортой эм, химийн бодис, хий ашиглах зэрэг олон төрөлтэй ба улс орны ёс заншил, байгалийн орчин, тогтоц зэрэг онцлогоос хамаардаг.

Судалгаанаас үзэхэд сэтгэцийн хувьд харьцангуй эрүүл болон сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн амиа хорлох хэлбэр нь адил байдаг гэж үздэг ба ихэнх тохиолдолд ганцаараа амиа хорлодог.

зарим тохиолдолд хоёр ба түүнээс дээш хүн урьдчилан үгсэн тохиролцож, төлөвлөж амиа хорлох явдал байдаг. Үүнийг хамтарсан амиа хорлолт гэдэг. Өөрөө амьдрах аргагүй болсон эсвэл ойр дотны хүмүүс нь зовж шаналж байна гэж итгэл үнэмшилд автаж ойр дотныхоо хүмүүсийг хорлож (гомицид- бусдыг алах), дараа нь өөрийгөө хорлох (суицид) үйлдэл хийхийг хамтарсан амиа хорлолт гэсэн нэр томъёогоор илэрхийлдэг. Энэ нь сэтгэцийн эмгэгтэй, ялангуяа сэтгэл гутралтай өвчтөнүүд үйлдэх эрсдэл өндөртэй гэж үздэг.

Амиа хорлохоос урьдчилан сэргийлэх хамгийн гол арга нь тухайн хүний тулгамдсан асуудлыг илрүүлэх, эмнэлзүйн ярилцлага хийх, асуудлыг шийдвэрлэхэд туслах зэрэг зан төлөвт нөлөөлөх явдал юм.

Ийм төрлийн хүмүүс нь амиа хорлох бодол, төлөвлөгөөгөө бусдаас нуудаг ба амиа хорлож болзошгүй сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай хүмүүст танин мэдэхүй, төрх үйл, сэтгэл хөдлөлийн өөрчлөлтүүдээр илэрдэг гэж үздэг. Тухайлбал:

- Танин мэдэхүйн өөрчлөлт нь – ирээдүйд итгэх итгэлгүй, өөрийгөө бусдаас доогуур үнэ цэнэтэй, бусдад тус дэм үзүүлж чадахгүй, эд хөрөнгөгүй, гэр бүл нийгэмдээ хэрэггүй хүн, амьдрал утга учиргүй болсон гэх мэт буруу итгэл үнэмшил төрөх
- Төрх үйлийн өөрчлөлт нь – нийгмийн дунд биеэ авч явах байдал нь өөрчлөгдөх, дасан зохицох чадвар муудах, сэтгэлийн бухимдлаа тайлах гэсэн шалтгаар архи, мансууруулах бодис хэрэглэх, найз нөхдөөсөө хөндийрөх, хэн нэгэнд захиас сургаал хэлэх, бусдад түрэмгий төрх үйл гаргах, нийгмийн хэв журам зөрчих зэрэг шинжүүдээр
- Сэтгэл хөдлөлийн өөрчлөлт нь - уурлаж бухимдах, гуниглах, хэн нэгнийг үзэн ядах, тулгамдсан асуудлаа даван туулж чадахгүй болсон мэт мэдрэмж төрөх, айдас түгшүүр төрөх зэрэг шинжүүдээр тус тус илэрдэг.

²⁷ (John. M Grohol. 2008).

²⁸ (Mehmet Eskin. 2012).

Харин сэтгэцийн эмгэгтэй хүмүүст сэтгэцийн эмгэгийн шинж тэмдэг, хамшинжээс хамааран харилцан адилгүй шинжүүд²⁹ илрэх бөгөөд 28 хамшинжийн жагсаалтыг батлан практикт мөрдлөг болгон ашигладаг.

ДЭМБ-ын 2014 оны “Амиа хорлохоос урьдчилан сэргийлэх” тайлангаас үзвэл өнөөгийн байдлаар дэлхийд 800000 хүн амиа хорлодог бөгөөд дунджаар 40 секундэд нэг хүн амиа хорлодог гэсэн үзүүлэлт байна. Дэлхийн амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх олон улсын холбоо нь (International Association for Suicide Prevention- IASP) жил бүрийн 9-р сарын 10-ны өдрийг амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх өдөр болгон, тодорхой уриан дор олон улсын түвшинд тэмдэглэдэг³⁰.

Амиа хорлолт нь бага болон дунд орлоготой орнуудын түвшинд өндөр байгаа төдийгүй 15-29 насныхны нас баралтын шалтгааны хоёрдугаарт амиа хорлолт орж байгаа³¹ нь анхаарал хандуулах асуудлын нэг болсон гэж дүгнэж байна. ДЭМБ-ын 2012 оны судалгаанаас үзэхэд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 2 дахин илүү амиа хорлож байна

Амиа хорлолтын улмаас нас барах тохиолдол нь дэлхийн хүн амын нас баралтын 1.4%, нас баралтын шалтгааны 15-рт эрэмбэлэгдэж байгаа нь өндөр хувь эзэлж байна. Дээрх тайлангаас үзэхэд аль ч улсад хамгийн их хэрэглэдэг арга нь өөрийгөө боомилох (50%), галт зэвсгээр өөрийгөө хөнөөх (18%) аргууд байна. Галт зэвсэг хэрэглэж амиа хорлох тохиолдол нь АНУ зэрэг өндөр хөгжилтэй орнуудад их байдаг бол хөдөө аж ахуй сайн хөгжсөн орнуудад хөдөө аж ахуйд хэрэглэдэг химийн бодисууд ялангуяа пестицид хэрэглэх, Гонг-Конг, Хятад, Сингапур зэрэг өндөр барилга бүхий улс орнуудад өндрөөс үсрэх, угаартах, химийн бодисын холимог хэрэглэх (Япон) зэрэг аргуудыг илүүтэй хэрэглэдэг.

Судалгааны дүнгээс үзвэл амиа хорлох нь ядуурал, дайн байлдаан, ялгаварлан гадуурхалт, эмнэлгийн тусламжийн хангалтгүй байдал, хүмүүсийн харилцааны зөрчил, сэтгэцийн эмгэг, архи мансууруулах бодисын хортой хэрэглээ, хүчтэй өвдөлт бүхий архаг өвчнүүд нөлөөлдөг болохыг тогтоожээ. Амиа хорлоход хүргэдэг сэтгэцийн өвчнүүдийн дотор сэтгэл хөдлөлийн эмгэг (12%), архины хамааралд орох (7%), шизофрени (5%) зэрэг нь ихэнхи хувийг эзэлдэг.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас амиа хорлох тохиолдлыг бууруулах зорилгоор 2013-2020 он хүртэл Сэтгэцийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан бөгөөд 2020 он гэхэд 10% бууруулна хэмээн төлөвлөсөн. 2010 онд АНУ-д галт зэвсгийн хэрэглээнд хяналт тавих, тээврийн хэрэгсэлд ашигладаг химийн бодист хяналт тогтоох, хүн амд сэтгэл зүй- сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлсний үр дүнд амиа хорлолтыг 20%-аар бууруулсан. Амиа хорлох тохиолдлыг бууруулахад тусгайлсан бодлого, хөтөлбөр шаардлагатай байгаа бөгөөд өнөөгийн байдлаар амиа хорлох үйлдлийг бууруулах асуудлыг тусгасан ямар нэг баримт бичиг боловсруулсан 50 орон байгаагаас 7 улс нь үндэсний хөтөлбөртэй байна. Манай улсад 2012 оны байдлаар амиа хорлох тохиолдол 100.000 хүн амд 15.5 тохиолдол байгаа нь дэлхийн дунджаас (11.4) дээгүүр байжээ³².

²⁹ Эрүүл Мэндийн Сайдын тушаал. Сэтгэцийн эмгэгтэй хүний эмчилгээ, үйлчилгээ, түүнд хяналт тавих журам. Уб.,2014. 180 дугаар тушаалын хавсралт.

³⁰ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тайлан. Уб.,2014. 29 дэх тал.

³¹ Хүүхдийн эрүүл мэнд, сэтгэц. Уб.,2019. Эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. 45 дахь тал.

³²З.Хишигсүрэн, Д.Оюунсүрэн, Г.Цэцэгдарь, С.Бямбасүрэн, Най.Туяа. Монгол Улсын хэмжээнд амиа егүүтгэсэн, амиа егүүтгэх оролдлого хийсэн тохиолдлыг судалсан судалгаа. Уб.,2003-2008. 36 дахь тал.

ДЭМБ-ийн 2022 оны мэдээнээс үзэхэд Монгол улс 2018 онд амиа хорлох тохиолдлын тоо 100.000 хүн амд 18.67 гэж мэдээлсэн байна. Өөрийн орны судлаачдын судалгаанаас үзэхэд ДЭМБ-ийн санхүүжилтээр 2013 онд ЕБС-ийг түшиглэж хийсэн судалгаанд Монгол Улсын 13-17 насны өсвөр насныхан сүүлийн 1 жилийн дотор 23 хувь нь амиа хорлох талаар бодож үзсэн бол 9.3 хувь нь амиа хорлох оролдлого хийсэн өөрөөр хэлбэл 4 хүүхэд тутмын 1 нь амиа хорлох бодолтой байгаа бол ойролцоогоор 10 хүүхэд тутмын 1 нь амиа хорлох оролдлого хийгээд үзсэн байна. Эндээс харахад хүүхэд өсвөр насныхны дунд амиа хорлох эрсдэл өндөр байгааг харуулж байна.

Жилд дунджаар 400 орчим хүн амиа хорлож байгаагаас гадна өсвөр насны хүүхэд болон 29 хүртэлх насны залуусын дундах амиа хорлолт жил бүр өссөөр байгаа нь бүх талдаа анхаарлаа хандуулах нөхцөл бий болж байгааг судалгааны дүн харуулсан³³.

Сурагчдын дунд явуулсан судалгаагаар, сүүлийн 12 сарын хугацаанд амиа хорлох талаар нухацтай бодож байсан гэж хариулсан нь судалгаанд хамрагдагчдын 26.1 хувь, амиа хорлохыг завдаж байсан гэж 10.7 хувь нь хариулсан³⁴.

Дүгнэлт

- Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас гаргасан амиа хорлолтын тоо хэмжээг харуулсан 2017 оны тоо баримтаар Монгол Улс 100,000 хүн тутамд 28.1 амиа хорлодог гэжээ. Энэ үзүүлэлт нь дэлхийн индексээр өндөр түвшинд байгаагийн илрэл юм.
- Монгол Улсад амиа хорлосон, хорлох оролдлого хийсэн тохиолдлын тархалтын судалгаа 3 удаа хийгджээ.
- Амиа хорлох үйлдлийг бодитой бүртгэгдэх боломжтой гэдгийг дэлхийн ихэнх улс хүлээн зөвшөөрч байна. Энэ үйлдэлд хэрэглэсэн арга нь тухайн хүний амь насанд аюул багатай үед эмнэлэгт хандахгүй, эмнэлгийн тусламж авдаггүйтэй холбоотой бүртгэлээс гадна үлдэх, нуугдмал байдалд байх явдал байсаар байна.
- Амиа хорлох үйлдэл хийсэн хүмүүсийн 50%-иас дээшх хувь нь амьдралын боломж муу, ядуурал, ажилгүйдэл, боловсролын түвшин доогуур байх тохиолдол харьцангуй их байна. Өсвөр насны хүний эцэг, эхийн хараа хяналт дутмаг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд тэдэнд ялгавартай хандах, гадуурхах, доромжлох, дээрэлхэх, тэгш бус хандах зэрэг байдал нь амиа хорлох шалтгаан, нөхцөл болж байна.
- Гэр бүлийн гишүүдээ сэтгэлийн хямралд оруулахгүй байх, тэдэнтэй байнга харилцан ярилцаж нээлттэй байх, тэдний хэрэглээ, найз нөхдийн хүрээлэл, хүсэл сонирхолыг ажиглаж, хянаж байх, сэтгэл зүйчид хандаж тогтмол зөвлөгөө авах нь энэ төрлийн үйлдэл хийхээс урьдчилан сэргийлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Санал

- Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт сэтгэл зүйн хичээлийг суралцагчийн түвшингээс хамаарч үе шаттай зохион байгуулж хэвших, байнга ярилцдаг байх. Дээрх арга туршлагыг хэрэгжүүлсэн Япон улсад гэхэд сүүлийн хоёр жилийн хугацаанд амиа хорлолт 18 хувиар буурсан гэх мэдээлэл бий.
- Монгол Улсын хэмжээнд амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хорлосон тохиолдлыг бүртгэх ажиллагааг нэгдсэн сүлжээтэй болох

³³ Монгол Улсын Ерөнхий прокурорын газар. Судалгааны тайлан. Уб.,2017. 12 дахь тал.

³⁴ Монголын Үндэсний телевиз. Шууд нэвтрүүлэг. Уб.,2023. 12 сарын 17-ны өдөр.

- Судалгааны үр дүнд суурилсан тусламж үйлчилгээг зохион байгуулах, утсаар зөвлөгөө өгөх тогтолцоог боловсронгуй болгох
- Гэр бүлийн, үе тэнгийнхний дарамт, хүчирхийллийг бууруулах
- Сэтгэл зүйн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, чанарт анхаарах, орчин үеийн арга техникүүдийг нэмэгдүүлэх, эмч, сэтгэл зүйчийн тоо, цалин, нийгмийн баталгааг нэмэгдүүлэх шаардлага байна.

Ашигласан эх сурвалж:

1. З.Хишигсүрэн, Д.Оюунсүрэн, Г.Цэцэгдарь, С.Бямбасүрэн, Най.Туяа. Монгол Улсын хэмжээнд амиа егүүтгэсэн, амиа егүүтгэх оролдлого хийсэн тохиолдлыг судалсан судалгаа. УБ.,2003-2008.
2. O.Spengler. der Sohnenuntergang in der Abendland.Hbg. 2004.
3. John. M Grohol. L.,2008
4. Mehmet Eskin. ҮН.,2012
5. Эрүүл Мэндийн Сайдын тушаал. Сэтгэцийн эмгэгтэй хүний эмчилгээ, үйлчилгээ, түүнд хяналт тавих журам. УБ.,2014. 180 дугаар тушаалын хавсралт.
6. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тайлан. УБ.,2014.
7. Хүүхдийн эрүүл мэнд, сэтгэц. УБ.,2019. Эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл.
8. Монгол Улсын Ерөнхий прокурорын газар. Судалгааны тайлан. УБ.,2017.
9. Монголын Үндэсний телевиз. Шууд нэвтрүүлэг. УБ.,2023. 12 сарын 17-ны өдөр.
10. <https://mn.wikipedia.org>

**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ОРСОН
ЗАРИМ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ
INCLUDED IN THE CRIMINAL LAW OF MONGOLIA
SOME ADDITIONAL CHANGES**

Д.Бямбахүү
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн ахлах багш, цагдаагийн
дэд хурандаа
D. Byambakhau
Senior teacher of police Law department,
Police school of University of Internal Affairs,

Хураангуй. Энэхүү өгүүлэлд Монгол Улсын 2015 оны Эрүүгийн хуульд 2017 оноос хойш өнөөдрийг хүртэл хугацаанд гарсан хуулийн давхардал хийдэл, зөрчлийг арилгах, эрүүгийн хариуцлагын төрөл хэмжээг тогтоох, эрүүгийн хууль тогтоомжийг нэг мөр ойлгож хэрэглэх, өөр хооронд нь нийцүүлэх талаар авч үзсэн болно.

Abstract. In this article, the 2015 Criminal Law of Mongolia has been discussed since 2017 to eliminate the duplication of laws and violations, to determine the types of criminal liability, to understand and apply the criminal laws in one line, and to harmonize them with each other.

Түлхүүр үг. Эрүүгийн хууль, нэмэлт өөрчлөлт, харьцуулалт
Key word. Criminal Law, amendment, comparison

Үндсэн хэсэг. Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга нь 30 бүлэг, 287 зүйлтэй. 2015 оны Эрүүгийн хуульд гэмт хэргийн тухай ойлголтыг “Энэ хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцно” гэж хуульчилсан байна.

Монгол Улсын 2015 оны Эрүүгийн хуульд 2017 оноос хойш өнөөдрийг хүртэл хуулийн давхардал хийдэл, зөрчлийг арилгах, эрүүгийн хариуцлагын төрөл хэмжээг тогтоох, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүн нь адил хэмжээний ял хариуцлага оногдуулахаар заасан байгааг ялгамжтай байхаар өөрчлөх, зарим гэмт хэргийг шинээр нэмж хуульчлах, авлигын гэмт хэргээр ял шийтгэгдсэн ялтанг хорих ялаас хугацаанаас нь өмнө суллахгүй байх, бага насны хүүхдийг алах, бага насны хүүхдийг хүчиндэх, согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн болон согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож хүний эрүүл мэндэд хохирол учруулсан, амь насыг нь хохироосон үйлдэлд хүлээлгэх хариуцлагыг чангатгах хэрэгцээ шаардлагыг үндэслэн Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар 26 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна.

2017 оноос 2023 оны хооронд 2015 оны шинэчилэн найруулсан Эрүүгийн хуулийн³⁵ Ерөнхий болон тусгай ангийн зүйл хэсэгт 1-5 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна. Үүнийг хуульд өөрчлөлт орсон оноор жагсаавал:

³⁵ Эрүүгийн хууль 2015 он

2017 онд Хуулийн давхардал хийдэл, зөрчлийг арилгах, эрүүгийн хариуцлагын төрөл хэмжээг тогтоох зорилгоор Эрүүгийн хуулийн бүлэг тус бүрд өөрчлөлт орсон.³⁶

2018 онд Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлгийн зарим зүйл хэсэгт өөрчлөлт орсон, мөн хуулийн 15 дугаар бүлэгт “Хүний цус, эд, эд эрхтэнийг шаардлага хангаагүй нөхцөлд бэлтгэх, шилжүүлэн суулгах” гэмт хэрэг, 29 дүгээр бүлэгт “Үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэмт хэргийг нэмж хуульчилсан.³⁷

2019 онд Эрүүгийн хуулийн 20, 29 дүгээр бүлэгт заасан гэмт хэргийн зарим зүйл хэсгийг өөрчилөн найруулсан,³⁸

2020 онд Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэгт заасан зарим гэмт хэргийн гарчиг болон энэ бүлгийн зарим зүйл хэсгийг өөрчлөн найруулсан,³⁹

2021 онд Эрүүгийн хариуцлага хүлээлгэх, чөлөөлөх үндэслэл журам болон Эрүүгийн хуулийн 13, 16, 18, 21 дүгээр бүлгийн зарим зүйл хэсгийг өөрчлөн найруулсан, 24.10 дугаар зүйлд Гентек нөөц, генетик нөөцтэй холбоотой мэдлэгийг хууль бусаар ашиглах гэмт хэргийг нэмж хуульчилсан, Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлгийг өөрчлөн найруулсан,⁴⁰

2022 онд Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа, торгох ялын хэмжээ, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэхтэй холбоотой зарим зүйл хэсэгт өөрчлөлт оруулсан, Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэгт “Эрдэнэсийн сангийн үндсэн санг хууль бусаар зарцуулах” гэмт хэргийг нэмж хуульчилсан, Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялыг хүндрүүлсэн.⁴¹

2023 онд Эрүүгийн хуулийн 10, 12, 21, 27 дугаар бүлгүүдэд нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд уг өөрчлөлтөөр бага насны хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож, хохирогчийг арван найман насанд хүрсний дараа тоолж эхлэх, эрүүгийн хэрэгт оногдуулах ялыг хүндрүүлэн өөрчлөлт оруулжээ.⁴²

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Хуулийн агуулга Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт “Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулах хуулийн төслийг Засгийн газар санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.”⁴³ Энэ тохиолдолд өөрчлөлт оруулж байгаа хууль тус бүрд үзэл баримтлалыг тодорхойлох шаардлагагүй” гэж заасны дагуу хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараахь хууль зүйн болон практик шаардлага тулгарсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 34 дүгээр тогтоолын Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг баталсантай холбогдуулан хууль хоорондын давхардал, зөрчлийг арилгах үүднээс холбогдох хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгаснаас гадна Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1-д “Тогтвортой, хариуцлагатай улс

³⁶ Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай/ 2017

³⁷ Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай/ 2018

³⁸ Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль 2019

³⁹ Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль 2020

⁴⁰ Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль 2021

⁴¹ Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль 2022

⁴² Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль 2023

⁴³ Хууль тогтоомжийн тухай хууль

төрийн соёлыг төлөвшүүлж, хүчтэй, чадамжтай, хууль дээдэлсэн төрт ёсыг бэхжүүлэх зарчмыг баримтална” гэж, 5.3-т “Хууль заавал хэрэгждэг, хүн бүрд эрх тэгш, алагчлалгүй, шударга үйлчилдэг, итгэл хүлээсэн хүний эрхийн мэдрэмжтэй, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх зарчмыг баримтална.” гэж, 5.1.3-т “Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах хүрээнд салбар бүрд батлагдан хэрэгжиж буй бодлогын уялдаа холбоог хангаж, боловсронгуй болгон үргэлжлүүлнэ.” гэж, 5.2.11-д “Хууль, эрх зүйн актуудын давхардал, зөрчилтэй заалтуудыг илрүүлэх, арилгах,...” гэж, 5.4.1-д “Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш, шударгаар үйлчлэх эрх зүйн орчинг цогцоор нь бүрдүүлнэ.” гэж⁴⁴ тус тус заасан байна.

Монгол Улсын Их Хурлаас шинээр аливаа хууль хэлэлцэн батлах бүрт тухайн хуулиар зохицуулсан хориглосон, үүрэг болгосон хэм хэмжээг зөрчсөн үйлдлийг шинээр зөрчилд тооцон Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид тусгах эсэх асуудлыг тухай бүрт шийдвэрлэх хэрэгцээ шаардлага үүсэх бөгөөд зарим тохиолдолд үүнтэй уялдуулан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах, Эрүүгийн хууль тогтоомжийг практикт хэрэгжихүйц байх нөхцөлийг хангах шаардлага тулгарсан. Тухайлбал: гэмт хэрэг, зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох зохицуулалтыг уялдуулах, зарим зөрчилтэй уялдуулан гэмт хэргийн шинжийг өөрчлөн найруулах хэрэгцээ, шаардлага үүссэн.

Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад мал хулгайлах гэмт хэргийг өмчлөх эрхийн эсрэг бусад төрлийн гэмт хэрэгтэй адилтган үзэж, ижил хэлбэрийн хариуцлага хүлээлгэхээр тусгасан бол 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад бусдын малыг хулгайлан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулах гэмт хэргийг “Хулгайлах” гэмт хэргээс ялган ойлгож, “Мал хулгайлах” 17.12 дугаар зүйлийг шинээр нэмсэн.

2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар уг зүйлд өөрчлөлт оруулсан. Хохирлын хэмжээ 17.12 дугаар зүйлийн 2 дахь тайлбарт заасан хэмжээ буюу хорин дөрвөн бог, эсвэл найман бодод хүрээгүй тохиолдолд хүндрүүлж үзэх нөхцөл байдлаар ял шийтгэх боломжгүй, түүнчлэн мал хулгайлах гэмт хэргийг хоёр, түүнээс олон хүн санаатай нэгдэж, урьдчилан үгсэн тохиролцон бүлэглэж үйлдсэн бол хүндрүүлж үзэх заалтыг хуульд нэмж тусгах шаардлага үүссэн. Дээрх практик болон эрх зүйн үндэслэл, шаардлагын үүднээс 17.12 дугаар зүйлийн 2 дугаар тайлбар дахь “олон тооны мал”-ын шалгуур тоон үзүүлэлтийг зохистой хэмжээнд хүртэл бууруулан тогтоож, хохирогчид учирсан хохирлыг бодитоор тооцон гэмт хэрэг үйлдэгчдэд ял, шийтгэл хүлээлгэх нь зүйд нийцэх юм гэж хууль санаачлагч үзжээ.

Хуулийн 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар, цөөн тооны мал хулгайлсан этгээдэд оногдуулах ял, шийтгэл нь хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих зэрэг хувилбартай байсан. Шүүхийн практикаас харахад дээрх зүйлийн дагуу цөөн тооны мал хулгайлсан этгээдэд хорихоос өөр төрлийн буюу нийтэд тустай хөдөлмөр эрхлэх шийтгэл хүлээлгэх нь түгээмэл бөгөөд ялын энэ төрлөөр шийтгэгдсэн гэмт этгээдүүдийн дийлэнх нь малчинд учруулсан хохирлоо нөхөн төлөлгүй, гэм буруугаа хүлээн зөвшөөрөхгүй өнгөрөх, малаа алдсан иргэд хохирч үлдэх асуудал практикт гарч байна.

Хорихоос өөр төрлийн ял шийтгэж байгаа тохиолдолд Эрүүгийн хуулийн 6.7 дугаар

⁴⁴ Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр

зүйлийн дагуу гэмт этгээд ял хөнгөрүүлэх зорилгоор гэм буруугаа хүлээн зөвшөөрч, хохирол барагдуулах нөхцөл хангагдахгүй байсан байна. Энэ хуулиар дараах онцлог өөрчлөлт орсон байна. Үүнд: Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолох зохицуулалтыг зөрчлийн хугацаа тоолох зохицуулалттай уялдуулж, улмаар зарим гэмт хэрэг хөөн хэлэлцэх хугацаа тоолох зохицуулалтыг боловсронгуй болгохоор өөрчилсөн.

Гэмт хэргийн хохирол, хор уршгийн ойлголтын хуульд уялдаа холбоотой байхаар зохицуулсан. Эрх хасах, хорих зэрэг зарим ялын хэмжээтэй холбоотой зохицуулалтын зөрчлийг арилгасан. Шүүхийн практикт хуулийг хэрэглэхтэй холбоотой гарч байгаа хүндрэлийг шийдвэрлэх зорилгоор хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулах, үргэлжилсэн гэмт хэргийн зохицуулалтыг практикт нэг мөр хэрэгжихүйц байдлаар нарийвчлан тусгасан.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан зарим төрлийн албадлагын арга хэмжээг практикт хэрэглэхтэй холбогдуулан зохицуулалтыг боловсронгуй болгосон. Түүнчлэн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зарим гэмт хэрэгт оногдуулах ялыг ерөнхий анги болон тусгай ангид заасан бусад ялтай уялдуулах, зарим гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатгах зэрэг зохицуулалтыг тусгасан. Тухайлбал Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мал хулгайлсан этгээдэд оногдуулах ял шийтгэлээс “нийтэд тустай ажил хийлгэх” хувилбарыг хассан, мал хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөлийг илүү тодорхой болгож ялыг ялгамжтай оногдуулах эрх зүйн үндэслэлийг тогтоосон.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.7-д “Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно”⁴⁵ гэж; Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 77-д “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ”⁴⁶ гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Зургаа дахь хэсгийн “Төрийн бүтээмжийн сэргэлт”-ийн 6.5-д “Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгана.”⁴⁷ гэж тусгасны дагуу Монгол Улсад авлигатай тэмцэх эрх зүйн орчин зохих түвшинд бүрдсэн боловч Авлигын индексийн үзүүлэлт огцом буурч байгаа нь авлигатай тэмцэх тогтолцооны үр нөлөөг дээшлүүлэх, Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараахь хууль зүйн болон практик шаардлага тулгарсан байна.⁴⁸

Тухайлбал: Хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан /УИХ-ын гишүүн/ албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолж эхлэх, ...Сэжигтэн мөрдөн шалгах ажиллагаанаас оргон зайлсан бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх

⁴⁵ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө

⁴⁶ Монгол Улсын их хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан Эрүүгийн хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл

⁴⁷ Монгол Улсын их хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого” хэрэгжүүлэх эхний үе шат үйл ажиллагааны хөтөлбөр

⁴⁸ www.Parliament.mn //Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал

хугацаа тоолохыг оргон зайлсан өдрөөс эхлэн зогсоож уг этгээд баригдсан, эсхүл хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолох, ...гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж улсын орлого болгохоор гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулж улмаар авилга албан тушаалыг гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатган зорчих эрхийг хязгаарлах болон хорих ял оногдуулахаар хуульчилсан.

Мөн Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.7-д “Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно”⁴⁹ гэж Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 77-д “...нийгмийн хор аюул, үйлдэгдэж байгаа арга, хэлбэрээс хамаарч зарим гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлагыг оновчтой болгох зорилгоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж тусгасны дагуу Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл, 12.1 дүгээр зүйл, 27.10 дугаар зүйлүүдэд заасан гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараахь хууль зүйн болон практик шаардлага тулгарсан байна.⁵⁰

Тухайлбал: Хууль тогтоогчоос Хүнийг алах гэмт хэргийн халдлагад өртөж нас барсан хохирогчдын тоо өссөн, ихэвчлэн бага насны хүүхдийг биеэ хамгаалж чадахгүй, бага насны хүүхэд гэдгийг мэдсээр байж, өөр гэмт хэргийг нуун далдлах зорилгоор гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж амь насыг нь хөнөөсөн, гэмт этгээд үйлдсэн гэмт хэргээ нуун далдлах, гэмт хэргийн ул мөрөө баллах зорилгоор хохирогч бага насны хүүхдийг алсан тохиолдол цөөнгүй бүртгэгдсэн нь бага насны хүүхдийг алах гэмт хэрэгт оногдуулах ял хариуцлагыг чангатгах бодлого шаардлагатай болсон.

Мөн хүчиндэх гэмт хэргийн гаралт нэмэгдэж гэмт хэргийн улмаас хүүхэд, тэр дундаа бага насны хүүхэд хохирох явдал буурахгүй байгаа нь хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах, хөөн хэлэлцэх хугацааг суртасгах шаардлагатай болсон.

Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах асуудал нэмэгдэж, энэ нь хүний эрх, эрх чөлөөнд халдах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсэхэд хүргээд шалтгааны улмаас хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан үйлдэлд оногдуулах ялыг чангаруулах шаардлагатай болжээ.

Түүнчлэн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил өссөн нь энэ төрлийн зөрчил, гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлага хангалтгүй зэргээс шалтгаалан тоон үзүүлэлт буурахгүй байгаа үндэслэлээр согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн болон согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож хүний эрүүл мэндэд хохирол

⁴⁹ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

⁵⁰ Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал parliament.mn

учруулсан, амь насыг нь хохироосон үйлдэлд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, Авлигатай тэмцэх бодлогын хүрээнд Эрүүгийн хуулийн “Хорин хоёрдугаар” бүлэгт заасан авлигын гэмт хэргээр ял шийтгэгдсэн ялтныг хорих ялаас хугацаанаас нь өмнө суллахгүй байх асуудал тулгарч бйгаа зэрэг хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Улсын хурлаар хэлэлцэн баталжээ. Тухайлбал: Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт “Энэ хуулийн 12.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12.3 дугаар зүйлийн 2.1, 3.2 дахь заалт, 13.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож, хохирогчийг арван найман насанд хүрсний дараа тоолж эхэлнэ.” гэж өөрөөр хэлбэл хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, хохирогчийг арван найман насанд хүрсний дараа тоолж эхлэхээр нэмэлт өөрчлөлт оруулсан. Мөн дээрх гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатган хуульчилсан байна

Эдүгээ дэлхий дахиныг хамарсан даяарчлалын үйл явц хууль зүйн салбарыг тойрч гараагүй бөгөөд түүний үр дагавар, нөлөө нь үндэсний хууль тогтоомжид тусгалаа олсоор байна.⁵¹ Хууль санаачлагчаас хуульд өөрчлөлт оруулахдаа судалгааг дутмаг хийдэг, ялын интерваль хэт өндөр зэргээс шалтгаалан зарим талаар шүүх хуулийг нэг мөр хэрэглэхэд бэрхшээл учирч байна.

Дүгнэлт. Өнөөдрийн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд цахимаар үйлдэгдэж байгаа залилан мэхлэх гэмт хэргийн, харъяалалын талаар эрх зүйн зохицуулалт тодорхой бус учир тухайн заалтуудыг практикт нэг мөр хэрэгжүүлэхийн тулд үндэслэл бүхий судалгаа, эрүүгийн хуулийн зарчимд нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага тулгарч байна. Хууль бол эрх зүйн хэм хэмжээний акт бөгөөд бүх нийт заавал дагаж мөрдөхөөр төрөөс батлан гаргасан дээд хүчин чадал бүхий баримт бичиг байдаг. Тиймээс ч хуулийн заалт бүх хүнд ойлгомжтой, тодорхой байх ёстой гэсэн зарчим бий. Мөн хуулийн зарчим нэг мөр хэрэгжих нь тухайн хуулийг зөв хэрэглэх эхний шалгуур нь болдог гэж дүгнэж болохоор байна.

Санал. Дээрх бүхнээс үндэслэн дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1.. 2015 оны Эрүүгийн хуульд гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж 2 ангилсан нь учир дутагдалтай учир өөрчлөх буюу гэмт хэргийн бүрэлдэхүүний онолын үндэслэл бүхий судалгаа хийж гэмт хэргийн ангилалыг өөрчлөх талаар санал гаргах

2.. Гэмт хэрэгт ял онооход хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг хэрхэн тооцож, үнэлэх талаар аргачилсан зөвлөмж гаргах,

3.. Ерөнхий ангийн хувьд хуульчилсан зарчмын томоохон өөрчлөлтүүдийг хадгалж, цаашид тогтвортой барих бодлого баримтлах /*Эрх зүйн хэм хэмжээний нөхцөл, үндэслэл, заалт, журмууд нь хоорондоо логик зүй тогтлоор холбогдон тэнцвэржиж, хийдэлгүй зөрчилгүй уялдан хуульчлагдсан байх, нөгөө талдаа зарчим алдагдсан заалтуудыг эргэн харж засаж залруулах нэмэлт өөрчлөлт оруулах хуулийг нэг мөр хэрэгжүүлэх*/

Ашигласан материал

1... Legalinfo.mn. Монгол Усын Эрүүгийн хууль.

2... Харьцуулсан эрх зүй Д.Баярсайхан УБ 2012.

3... Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн удиртгал Г.Эрдэнэбат, Ж.Эрдэнэбулган УБ 2004.

⁵¹ Харьцуулсан эрх зүй Д.Баярсайхан 2012

¹⁷ Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн удиртгал Г.Эрдэнэбат, Ж.Эрдэнэбулган УБ 2004

- 4...Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол С.Жанцан УБ 2009.
- 5...Хүний эрх хамгаалагчдад зориулсан хууль тогтоомжийн эмхэтгэл гарын авлага УБ 2023.
- 6...Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр.
- 7...Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал parliament.mn.
- 8...Монгол Улсын их хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан Эрүүгийн хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл.
- 9...Монгол Улсын их хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого” хэрэгжүүлэх эхний үе шат үйл ажиллагааны хөтөлбөр.

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХАНГАХАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ
SOME ISSUES TO CONSIDER IN ENSURING INTERNAL SECURITY
IN THE POLICE AGENCY

Б.Одбаатар

*ДХИС-ийн Удирдлагын академийн Цагдаагийн удирдлага, стратегийн профессорын
багийн профессор, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор,
цагдаагийн хурандаа*

Odbaatar.B

Professor, Professor's Team of Police Strategy Management, Executive Management
Academy, University of Internal Affairs, Mongolia, doctor of law (Ph.D),
Associate Professor, police colonel

Хураангуй: Энэхүү нийтлэлээр цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхэд анхаарал асуудлын талаар судлан судлаачийн байр сууринаас дүгнэлт, санал дэвшүүлэн гаргахыг зорилоо.

Abstract: In this article, we aim to make conclusions and suggestions from the point of view of a researcher about the issues of concern in the implementation of the function of ensuring the internal security of the police organization.

Түлхүүр үгс: цагдаагийн байгууллагын аюулгүй байдал, дотоод аюулгүй байдал, аюулгүй байдлын үндэс.

Keywords: police security, internal security, the basis of security.

Оршил

Аливаа байгууллагын оршин тогтнох үндэс өөрийн дотоод аюулгүй байдлыг хангаж, эрсдэлээ зөв тодорхойлох, түүнээс урьдчилан сэргийлэх, алба хаагчдын ёс суртахуун, сахилга хариуцлагыг дээшлүүлэх явдал байдаг.

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийн хүрээнд хариуцсан нутаг дэвсгэрт иргэн, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх, амар тайван, аюулгүй орчинг бий болгох, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоог хангах, алба хаагчдын нийгмийн баталгааг хангах зэрэг олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлдэг төрийн тусгай чиг үүрэгтэй алба юм. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд “Цагдаагийн албаны тухай хууль”-ийг шинэчлэн батлагдаж цагдаагийн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнд томоохон өөрчлөлт гарч үүнтэй уялдан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнд иргэд олон нийтийн итгэл дэмжлэлгийг хүлээх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинжлэх ухааны ололт дэвшлийг үр бүтээлтэй ашиглах зэрэг томоохон ажлуудыг хийж хэрэгжүүлж байна. Гэвч сайн зүйлийн хажуугаар зарим үед засгийн тогтворгүй байдал, улс төрийн нөлөөллөөс шалтгаалан цагдаагийн удирдах бүрэлдэхүүний томилгоо зарим үед хэт туйлширч байгаагаас нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга, засаг дарга нарын хооронд хамтран ажиллахад үл ойлголцол, хүндрэл учирч байгаагаас нутгийн удирдлагаас хамтран ажиллаж чадахгүй нэрийдлээр удирдах албан тушаалтныг өөрчилдөг сөрөг хандлага бий болсон. Энэ нь цаашид цагдаагийн байгууллагын бие даасан байдал, дотоод аюулгүй байдлаа ханган хэрэгжүүлэх үйл ажиллагаанд сөрөг байдлыг бий болгож байна.

Цагдаагийн байгууллагын удирдлага, алба хаагчид байгууллагын аюулгүй байдлыг хангах, түүнд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тал бүрээс нь судалж эрсдэлийг бууруулах, саармагжуулах зэрэг ажиллагаанд нэгдсэн ойлголт байхгүй, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны чиглэлийг тус тусдаа өөрсдийн онцлогт тохируулан тодорхойлсон зэргээс нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа харилцан адилгүй байгаа нь энэ чиглэлээр нэгдсэн стандарт бий болгож нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага бий болсныг харуулж байна.

Үндсэн хэсэг

Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 1-д “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн⁵²”, Цагдаагийн албаны тухай 14 дүгээр зүйлийн 14.1.3-д “цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, алба хаагч, ажилтан гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж, шалтгаан, нөхцлийг арилгах арга хэмжээ авах, цагдаагийн албаны дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах⁵³” гэж заасан. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3. дахь хэсэгт дотоод аюулгүй байдлыг “Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшилийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн” тодорхойлсон.

Иргэдийн амгалан тайван, айх аюулгүй аж төрөх, ажиллаж хөдөлмөрлөх нөхцлийг бүрдүүлж гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах нь цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг юм.

Үндэсний аюулгүй байдлыг тогтолцоо буюу систем гэж үзвэл цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдал түүний бүрэлдхүүн хэсэг гэж ойлгож болно.

Цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх чадавхаас⁵⁴ үндэсний аюулгүй байдал шууд хамааралтай. Улмаар энэхүү чадавхад нөлөөлөх сөрөг хүчин зүйлийг “аюул занал” хэмээн үзэх жишиг хандлага байна.

Сөрөг хүчин зүйлийг эх сурвалжаар нь 1. гадаад орчны; 2. дотоод орчны гэж ангилна. Эдгээр сөрөг хүчин зүйлүүд дангаар оршихгүй бөгөөд харилцан нөхцөлдсөн байдгаараа онцлогтой.

Цагдаагийн байгууллагын аюулгүй байдалд гадаад орчны зүгээс нөлөөлөх хүчин зүйлийг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- улс төр, нийгмийн тогтворгүй байдал;
- эдийн засгийн хөгжлийн түвшин баян ядуугийн ялгаа;
- иргэд, хуулийн этгээдээс явуулж байгаа хууль бус үйл ажиллагаа;
- гэмт хэрэг, зөрчлийн гаралт, нийгмийн сөрөг үзэгдэлүүд;
- олон нийт, иргэдийн цагдаад итгэх итгэл, нэр хүнд;
- цагдаагийн алба хаагчийн эрх зүйн баталгаа хангалтгүй байх зэрэг нь

цагдаагийн байгууллагын аюулгүй байдалд гадаад орчны зүгээс нөлөөлж буй хүчин зүйл юм. Цагдаагийн байгууллагын аюулгүй байдалд дотоод орчны зүгээс нөлөөлөх хүчин зүйлд:

⁵² Төрийн мэдээлэл эмхэтгэл 1992 он. №1. Монгол Улсын Үндсэн хууль.

⁵³ Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017 он. №8. Цагдаагийн албаны тухай хууль.

⁵⁴ Үүнд хүний нөөцийн, техник, хүч хэрэгсэлийн гээд олон хүчин зүйл багтана.

- алба хаагчийн сахилга харицлага сул, гэмт хэрэг зөрчилд орох.
- хүний нөөцийн сонгох, томилох, сургаж дадлагажуулахад алдаа гарах.
- удирдах ажилтны манлайлал, хяналт сул байх нь сөрөг нөлөөтэй.

Цагдаагийн байгууллагын хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх чадавхид нөлөөлөх сөрөг хүчин зүйл буюу “аюул”-аас дараах аргаар урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг зохион явуулна. Үүнд:

Зураг 1. Цагдаагийн байгууллагын аюулгүй байдалд нөлөөлөх сөрөг хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэлбэр



Цагдаагийн төв байгууллагын удирдлагаас дотоод аюулгүй байдлын асуудалд онцгой анхаарч Цагдаагийн ерөнхий газрын даргын 2010 оны 351 дүгээр тушаалаар (код 113) анх удаа дотоод аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчинг бүрдүүлж, үүгээр нэр томъёог тодорхойлох, аюулгүй байдлыг хангах ерөнхий чиглэлийг тогтоосон⁵⁵. Үүнд:

Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдал – хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах бусад чиг үүргийг гадаад, дотоод орчны нөлөөлөх хүчин зүйлээс үл хамааран үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл бололцоогоор хангагдсан байдал;

Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах – цагдаагийн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны сөрөг хүчин зүйлс нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, учруулж буй хор уршгийг саармагжуулахад чиглэсэн удирдлага, зохион байгуулалт, биет болон инженер техникийн арга хэмжээний цогц гэж тодорхойлжээ.

Хүний нөөцийн аюулгүй байдлыг хангах. Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн удирдлага нь цагдаа, дотоодын цэргийн байгууллагад анх ажиллах иргэнийг судлах, шилж сонгох, ажлын байранд томилох, сургах, дэвшүүлэх, алба хаагчийн ёс зүйг төлөвшүүлэх, хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагаа юм.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 03 сарын 20-ны өдрийн 6/164 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-т

⁵⁵ Энэхүү журмын зорилго нь цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлын төрөл, нэр томъёог тодорхойлох, түүнийг хангах орон тооны бус ажлын хэсэг ажиллах журмыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын эрхэм зорилго, тэргүүлэх чиглэл, түүнчлэн хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхэд гадаад болон дотоод орчны зүгээс нөлөөлөх давуу ба сул тал, боломж ба учирч болох эрсдэл зэргийг тодорхойлон гаргажээ. Тухайлбал, энэхүү бодлогын баримт бичгийн 2.1. дэх хэсэгт цагдаагийн байгууллагын хүний нөөцийн тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 1.

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

	ХҮНИЙ НӨӨЦИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ
1	Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагыг оновчтой тодорхойлж, түүнд тулгуурлан бодлогыг тодорхойлох, хүний нөөцийг бүрдүүлэх.
2	Хүний нөөцийн мэдээллийг удирдлагын шийдвэр гаргах хэрэгсэл болгох.
3	Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх сургалт, хөгжлийн бодлого боловсруулан хэрэгжүүлж, суралцагч байгууллага болох.
4	Карьер хөгжлийн болон цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог ажлын бүтээмжийг дээшлүүлэх хөшүүрэг болгох.
5	Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх хэрэгсэл болгох.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тулгарч болзошгүй эрсдэлд гадаад орчны зүгээс “төр, бизнесийн бүлэглэлийн нэгдэл улс төрийн нам, эвсэлийн хүрээнд бий болж эрх мэдлийн төлөөх өрсөлдөөн, улс төрийн томилгоо нь цагдаагийн байгууллагын удирдлагын үйл ажиллагаанд нөлөөлж, улмаар бие даасан, хараат бус байдал алдагдах эрсдэл” үүсэх аюул байгааг тогтоосон байна.

Нөгөө талаар цагдаагийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэргийн статистик судалгаагаар 2015-2020 онд 326 алба хаагч 291 гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь жилд дунджаар 58,2 сард 4,8 гэмт хэрэгт шалгагдсан байна. Мөн дээрхи хугацаанд давхардсан тоогоор 10061 цагдаагийн алба хаагч 10017 сахилгын зөрчил гаргаж шалгагдсан нь жилд дунджаар 2003, сард 167, өдөрт 5,5 алба хаагч сахилгын зөрчил гаргасан байна⁵⁶. Цагдаагийн алба хаагчдаас гэмт хэрэг, эрх зүйн зөрчилд холбогдох нь нэг талаас алба хаагчийн өөрийн ёс зүй, мэдлэг, ур чадвар сул байгаатай холбоотой боловч, нөгөө талаас анхан болон дунд шатны удирдах албан тушаалтны манлайлал, тэдний удирдан чиглүүлэх арга барил, гүйцэтгэлийн хяналт сул байгаатай шууд холбоотой гэж үзэхээс өөр аргагүй. Энэ талаар цагдаагийн байгууллагын “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг⁵⁷”-ийн 2.2 дахь хэсэгт “дунд шатны удирдлагын менежмент сул, ур чадвар дутагдалтай” гэж дүгнэсэн байна⁵⁸.

Эндээс дүгнэхэд шат шатны удирдах ажилтны үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, тэднийг бэлтгэх, сургах, томилоход бодлогоор хандах шаардлага бий болсон нь харагдаж байна. Иймд цагдаа, дотоодын цэргийн байгууллагад орчин үеийн менежментийн чиг хандлага, удирдлагын шилдэг арга барилыг нэвтрүүлэх замаар алба хаагч, шат шатны удирдах ажилтныг бэлтгэх, сургах, тэдний мэргэжлийн болон зохион байгуулах ур чадварыг хөгжүүлэх, манлайлалыг дээшлүүлэх зайлшгүй шаардлага бий болоод байна.

Өнөөдөр төрийн тусгай чиг үүрэгтэй аль ч байгууллагад алба хаагчдыг сонгон шалгаруулах, томилох үйл явц тодорхой бус, үүнд нэгдсэн бодлого, төлөвлөлт байхгүйн

⁵⁶ Цагдаагийн ерөнхий газар. Дотоод хяналт, аюулгүй байдлын газар. Судалгаа, дүн шинжилгээний төв. Цагдаагийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг, зөрчил, харилцаа, ёс зүйн өнөөгийн байдал. судалгааны ажлын тайлан. 2020.

⁵⁷ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015.03.20-ны өдрийн 6/169 тушаалын хавсралт.

⁵⁸ Цагдаагийн ерөнхий газар. Гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон цагдаагийн алба хаагчдын өнөөгийн байдал. судалгааны ажлын тайлан. 2016.

улмаас зарим тохиолдолд хүний нөөцийн бодлого алдагдах, албан тушаал дэвших, сонгон шалгаруулалт гэхээсээ илүү үзэмжээр хандах явдал ажиглагдах болсон. Түүгээр ч барахгүй удирдлага солигдох бүрт доод тушаалын алба хаагчид солигдох ёстой мэт сөрөг үзэгдэл бий болж, зарим тохиолдолд энэ нь байх ёстой, хэвийн үзэгдэл мэт ойлгогдох хэмжээнд хүрсэн байна. Иймд цагдаа, дотоодын цэргийн байгууллагад орчин үеийн менежментийн чиг хандлага, удирдлагын шилдэг арга барилыг нэвтрүүлэх замаар алба хаагч, шат шатны удирдах албан тушаалтныг бэлтгэх, тэднийг сургах, давтан сургах, мэргэшүүлэх сургалтын тогтолцоог боловсронгуй болгох, сургалтын болон хичээлийн хөтөлбөрийг эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн сайжруулах зайлшгүй хэрэгцээ шаардлага ч үүссэн байна.

Алба хаагчийн аюулгүй байдлыг хангах. Цагдаагийн байгууллага алба хаагчдынхаа аюулгүй байдлыг хангах, сахилга, ёс зүй, хариуцлагыг сайжруулах зорилгоор улирал бүр сахилга, хариуцлагын зөвөлгөөнийг зохион байгуулж, алба хаагчдаас гаргасан санал хүсэлтийг хүлээн авч тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. Төв, орон нутгийн цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд алба хаагчдыг албан үүргээ гүйцэтгэж байгаатай холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон түүний гэр бүлийн гишүүдийн хууль ёсны эрх ашгийг зөрчсөн үйлдэл буурахгүй байна. Энэ талаар алба хаагчдын дунд явуулсан санал асуулгын судалгаагаар 50-иас илүү хувь нь албан үүргээ гүйцэтгэж байхдаа их, бага хэмжээний халдлагад өртөж байгаа судалгаа гарсан байна⁵⁹.

Иймд удирдлагын зүгээс ямар нэг халдлага, зөрчилд өртөж байгаа алба хаагчдын асуудлыг нэгбүрчлэн шалгаж буруутай этгээдэд зохих ёсны хариуцлага ногдуулж ажиллах нь алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, сэтгэл зүйн дэмжлэг болох учиртай. Алба хаагчдаас гэмт хэрэг, сахилга, ёс зүйн зөрчилд өртөх нь буурахгүй байгаад дүн шинжилгээ хийхэд алба хаагч цаг үеийн нөхцөл байдлыг зөв үнэлж дүгнэх чадвар сул, харилцааны ур чадвар, соёлд суралцаагүй, аюулгүй байдлаа хангах мэдлэг сул байгаатай холбоотой.

Түүнчлэн алба хаагч үйл ажиллагаандаа “Цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээний стандарт”-ыг хэрэгжүүлж хэвших, хуулийг дээдлэх хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэх, иргэдтэй соёлтой харьцаж үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллах, алба хаагч нэг нэгэндээ хүндэтгэлтэй хандаж байх зэрэг гол, гол үзүүлэлтээр алба хаагч бүрээр баталгаа гаргуулан аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа ч дутагдал, зөрчил гарсаар байгаа нь ажлын хариуцлага сул байгаатай холбоотой.

Ер нь алба хаагчийн аюулгүй байдлыг аливаа аюул занал учрах нөхцөл үүсэхээс бүрэн сэргийлж, урьдчилан тооцоолон, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцлийг бий болгох, бүрдүүлэх гэж ойлгож болно. Тэгвэл алба хаагчийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл байдлын дараах ангилал, бүлэгт авч үзэж болно.

Зураг 2.

Алба хаагчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны чиглэл

⁵⁹ Цагдаагийн ерөнхий газар. Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтэс. Гарын авлага. – УБ., 2019.



Эдгээр нөхцөл байдал бүрэн хэмжээнд хангагдсан үед алба хаагчийн аюулгүй байдал хангагдсан гэж үзэж болох юм.

Алба хаагчийн хууль, эрх зүйн аюулгүй байдал. Алба хаагчийн эрүүл мэнд, эдийн засгийн хараат бус байдал болох цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийн баталгаа, хөдөлмөрлөх таатай нөхцөл боломж, хөдөлмөрийн аюулгүй үйл ажиллагааны хамгаалалт, сэтгэл санаа бие, эрүүл мэндийн аюулгүй байдал хэрхэн хангагдсан буюу албан үүргээ гүйцэтгэж байгаад болон гүйцэтгэсэнтэй нь холбогдуулан халдсан, хохирол учруулсан тохиолдолд хэрхэн хамгаалах, учирсан хохирлыг барагдуулах, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх гэх мэт асуудлыг хууль эрх зүйн актанд тусгасан тухай асуудал багтана.

Цагдаагийн төв байгууллага Цагдаагийн албаны хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3. дахь хэсэгт зааснаар цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, алба хаагч, ажилтан гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж, шалтгаан, нөхцлийг арилгах арга хэмжээ авах, цагдаагийн албаны дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах үүрэгтэй бол, нутаг дэвсгэр харицсан цагдаагийн байгууллага мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь хэсэгт зааснаар байгууллага, алба хаагч, ажилтны аюулгүй байдлыг хангах, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүрэгтэй.

Алба хаагчийн эдийн засгийн аюулгүй байдал. Өнөөдөр цагдаагийн алба хаагч хуулиар хүлээсэн албан үүргээ хэрэгжүүлэх явцдаа эдийн засгийн хараат бус байдал хангагдаагүй нөхцөлд бусдын эрх ашигт нийцсэн хууль бус шийдвэр гаргаж болзошгүй байгаа нь өөрөө аюултай нөхцөл байдлыг үүсгэж байгаа юм. Ер нь цагдаагийн алба хаагчийн эдийн засгийн аюулгүй байдлыг дотор нь үндсэн хоёр хэсэгт системчлэн шалгуур үзүүлэлт тогтоон авч үзэх боломжтой юм. Үүнд:

1. Алба хаагчийн эдийн засгийн аюулгүй байдлыг хангах шалгуур үзүүлэлт;
2. Үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж буй эдийн засгийн шалгуур үзүүлэлт.

Дээрх хоёр чиглэлийн шалгуур үзүүлэлт нь хэдийгээр тус тусдаа ойлголт мэт боловч аль нэгийг нь бүрэн хангахгүйгээр тэдний эдийн засгийн аюулгүй байдлыг баталгаатай хэмжээнд хангасан гэж үзэх нь өөрөө учир дутагдалтай.

Алба хаагчийн эдийн засгийн аюулгүй байдлыг хангах шалгуур үзүүлэлтэнд түүнд төрөөс өгч байгаа цалин хөлс, бусад нэмэгдэл байгууллагын зүгээс өгч буй эдийн засгийн тусламж дэмжлэг зэрэг хувь хүний амьдралд шууд нөлөөлж буй материаллаг зүйлийг оруулж болно. Цалин хөлс, нэмэгдэл ажилласан жилээс хамааран ялгавартай байдаг. Харин

байгууллагаас өгч буй тусламж дэмжлэгт алба хаагчиддаа зориулж орон сууц барих, байгууллага, төрийн зардлаар гадаад, дотоодын мэргэжлийн сургалтанд хамрагдах зэрэг тусламж, дэмжлэг явуулсаар байгаа нь тэдний эдийн засгийн баталгааг хангахад зохих үр дүнгээ өгч байна.

Үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж буй эдийн засгийн шалгуур үзүүлэлтэд хуульд заасан хэрэгжүүлэхэд гарч буй зардлыг төрөөс хэрхэн хангаж байгаа, түүний хүртээмжийн тухай асуудал багтана.

Сэтгэл зүйн аюулгүй байдал. Ажлын ачаалалаас алба хаагч сэтгэл санааны хувьд стресст орох, уур бухимдалтай болох, ажлын бүтээмж буурах болон гэр бүлдээ анхаарал халамж тавих байдал сулрах зэрэг байдлаар сэтгэл зүйн өөрчлөлтүүд гарсаар байна. Энэ нь нэг талаас алба хаагчийг бэлтгэхдээ мэргэжлийн чиглэлийн хичээлээр мэргэшүүлэн бэлтгэж, харин сэтгэл зүйн хувьд өөрт болон бусдад учирсан стресс, сэтгэл санааны дарамт, бухимдлыг хэрхэн гаргах талаар зааж сургадаггүй зөвхөн хувь хүний хүмүүжил, ажлын туршлагаараа л сэтгэл зүйн асуудлаа шийдвэрлэсээр өдийг хүрсэнтэй холбоотой. Мөн алба хаагчийн сэтгэл санааны бухимдал, стрессийг зөвөөр гаргах нөхцөл боломж хараахан бүрдээгүй байна.

Алба хаагчид сэтгэл зүйн засал, зөвлөгөө өгөх талаар тодорхойлсон боловч хэрэгжихгүй байгаа нь үндсэн чигүүргээ шуурхай явуулахад үйл ажиллагаагаа чиглүүлж алба хаагчийн аюулгүй байдлыг хангахад төдийлөн анхаарал хандуулахгүй байгаагийн нэг жишээ юм.

Бие, эрүүл мэндийн аюулгүй байдал. Ажлын ачаалал ихтэйгээс болоод хүний амарч, ажиллах цаг, хооллох дэглэм алдагдаж биед өвчин үүсэх үндсэн нөхцөл болж байна. Иймд алба хаагчийн бие бялдрыг хөгжүүлэхэд тусгай хөтөлбөрт үйл ажиллагаа явуулах нь нэг талаас эрүүл мэндийг анхаарч байгаа төдийгүй нөгөө талаас бие бялдрын аюулгүй байдлыг хангаж байгаа хэлбэр юм.

Энэ талаар ч мөн хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн бөгөөд “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-ын 932 дугаар зүйлийн 932.2.1. дэх хэсэгт:

➤ алба хаагчийн тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад улсын эмнэлгийн байгууллагад эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд эмнэлгийн байгууллагын дүгнэлт, холбогдох бусад баримтыг үндэслэн эмчилгээний зардлын 60-аас доошгүй хувийг;

➤ алба хаагч биеийн эрүүл мэндийн байдлын улмаас 1 жилээс дээш хугацаагаар албан ажлаа хийхгүйгээр эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон, цагдаагийн байгууллагын шийдвэрээр (*захиалгаар*) гурван сараас дээш хугацааны сургалтаар (*шинэ дадлага, туршлага эзэмших сургалтыг оролцуулан*) бэлтгэгдэх болсон, цэргийн алба хаах болсон, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалалтын арга хэмжээнд хамрагдсан тохиолдолд 3 сар хүртэлх цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг олгож болно гэж заасан байна.

Үйл ажиллагааны аюулгүй байдал. Үйл ажиллагааны буюу хөдөлмөрийн аюулгүй байдал гэж хөдөлмөрлөх явцад хүний эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь эрүүл ахуйн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй байхыг хэлнэ⁶⁰ гэж хуульчилсан байх бөгөөд цагдаагийн алба хаагч

⁶⁰ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2008 он. №21.

нь төрд алба хааж хөдөлмөрлөж буй субъектынхээ хувьд хамгаалуулсан байх нь ойлгомжтой.

Цагдаагийн байгууллагын эрсдлийн үнэлгээний 2019, 2020 оны тайланд цагдаагийн алба хаагч албан үүрэг гүйцэтгэж байхдаа гүтгүүлэх, доромжлуулах, хүчирхийлэл, заналхийлэлд өртөх эрсдэл “5” буюу өндөр үнэлгээтэй гарч, цагдаагийн байгууллага дахь эрсдэл бүхий ажлын байрны жагсаалтыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамд хүргүүлсэн байна⁶¹.

Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаарын тушаалын хавсралтын 1.4. дэх хэсэгт “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийхэд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Стандартчилал, тохиролын үнэлгээний тухай хууль, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл, хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ MNS 5080:2001” стандарт, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин., Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015” стандартыг мөрдлөг болгоно” гэж тогтоожээ.

Эдгээр стандарт шаардлагад ажиллах орчны халуун дулаан, гэрэлтүүлэг, хэт өндөр дуу чимээ, агаарын орчны хорт бодисын зөвшөөрөгдөх хэмжээ, сэтгэл зүй, физиологийн хүчин зүйлээр нь ангилж хөдөлмөрийн тохиромжтой, зөвшөөрөгдсөн, хортой аюултай түвшинд хуваан үзсэн байна. Гэтэл цагдаагийн алба хаагч олон нөхцөл байдалд явагддаг тул дээрх төрөл, түвшний аль нэгэнд шууд хамааруулан үзэх боломжгүй байгаа нь хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахад төвөгтэй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Гурав. Мэдээллийн аюулгүй байдлын хангах. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах нь төр, байгууллагын нууц⁶² алдагдвал байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, улмаар хүний нэр төр, алдар хүндэд халдаж болзошгүй мэдээ, сэлт, биет зүйлийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа юм.

Цагдаагийн албаны тухай хуулийн 6 дугаарын зүйлийн 6.6. дах хэсэг “цагдаагийн байгууллага харьяандаа чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэшсэн нэгж, мэдээлэл нэгтгэн боловсруулах, судалгаа, сургалт дадлагын, албаны зэвсэг, тусгай хэрэгсэл, тусгай зориулалтын техник хэрэгслийн чанар стандартыг судлан тогтоох лаборатори болон инженер техник, засвар үйлчилгээ, үйлдвэрлэл, санхүү, хангалт, спорт, соён гэгээрүүлэх, мэдээллийн технологи, аюулгүй байдал хариуцсан нэгжтэй байж болно⁶³” гэж заажээ. Мөн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дахь хэсэгт зааснаар “Цагдаагийн байгууллага доор дурдсан тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан үүсгэн, үйл ажиллагаандаа ашиглана” гэж заасан бөгөөд одоо нийт 21 төрлийн мэдээллийн сан ашиглан, уг сангийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй ажиллаж байна.

Цагдаагийн байгууллага мэдээлэл, технологийн хөгжлөөс хоцрохгүй, шинэ техник, технологийг нэвтрүүлэх, мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангах талаар нэлээд ажлыг зохион байгуулсан. Цагдаагийн байгууллагын мэдээллийн систем нь бодлого, стратеги, хүний нөөц, програм хангамж, өгөгдлийн сан, техник хангамж гэсэн үндсэн хэсгээс бүрдэж байна. Цагдаагийн байгууллагын мэдээллийн систем, өгөгдлийн сангийн

⁶¹ Цагдаагийн ерөнхий газар. Эрсдэлийн үнэлгээний тайлан. – Уб., 2020.

⁶² Байгууллагын нууц – хүний эрх, нэр төр, алдар хүнд тухайн байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон мэдээ, баримт бичиг, биет зүйл. Байгууллагын нууцын тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1995 он. №7

⁶³ Төрийн мэдээлэл. 20147. №8. Цагдаагийн албаны тухай хууль. 6 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын тогтолцоо.

серверүүд, сүлжээний төхөөрөмжүүдийг нөөц тэжээлийн системд холбож серверүүдийн найдвартай, аюулгүй ажиллагаа сайжирч байна. Мөн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор албаны хэрэгцээнд ашиглаж байгаа компьютеруудыг нууц код, паспорттой болгож хэвшсэн ч ашиглалтын талаарх бүртгэлийг дутуу хөтөлж үйл ажиллагаа жигдрээгүй дутагдал байсаар байна.

Дөрөв. Санхүү /төсвийн хөрөнгө/-гийн аюулгүй байдлыг хангах. Санхүүгийн аюулгүй байдлыг хангах нь төсвийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, түүнийг зориулалтын бусаар зарцуулах, ашиглах, завших, үрэгдүүлэхээс сэргийлэхэд чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагаа юм.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус ажлын хэсэг байгууллагынхаа төсвийн болон мөнгөн хөрөнгө, эд зүй, үнэт цаасны зарцуулалтын тооцоонд сар бүр тогтмол хяналт тавьж, гэнэтийн тооллого явуулан зөрчил, дутагдал илэрвэл засах ажлыг зохион байгуулж санхүүгийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр тодорхой ажлуудыг явуулж байна. Тухайлбал, нийслэлийн цагдаагийн газрын дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус ажлын хэсгээс дүүргүүдийн цагдаагийн газар, хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд тогтмол шалгалт хийж эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн төлбөр, үнэт цаасны тооцоог цаг тухайд нь хийдэггүй, дэлгэрэнгүй бүртгэл хөтөлдөггүй, дотоод ажлын уялдаа холбоо, хяналт шалгалт сул байгаа зэрэг зөрчлийг удаа дараа илрүүлэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байна.

Дүгнэлт.

1. Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдалд гадаад болон дотоод орчны зүгээс дараах хүчин зүйл нөлөөлж байна гэж үзлээ. Үүнд:

Гадаад орчны зүгээс нөлөөлөх хүчин зүйл:

- улс төр, нийгмийн тогтворгүй байдал.
- эдийн засгийн хөгжлийн түвшин /баян ядуугийн ялгаа/.
- иргэд, хуулийн этгээдээс явуулж байгаа хууль бус үйл ажиллагаа.
- гэмт хэрэг, зөрчлийн гаралт, нийгмийн сөрөг үзэгдэлүүд.
- олон нийт, иргэдийн цагдаад итгэх итгэл, нэр хүнд.

Дотоод орчны зүгээс нөлөөлөх хүчин зүйл:

- алба хаагчийн сахилга харицлага сул, гэмт хэрэг зөрчилд орох.
- хүний нөөцийн сонгох, томилоход алдаа гарах.
- удирдах ажилтны манлайлал, хяналт сул байх.

2. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дотоод аюулгүй байдалд гадаад орчны зүгээс нөлөөлөх хүчин зүйлийг:

- Political force буюу улс төрийн орчин
- Economic force буюу эдийн засгийн орчин
- Sociocultural force буюу нийгэм-соёлын орчин
- Technologocal force буюу техник-технологийн орчин
- Legal force буюу хууль, эрх зүйн орчин
- Environmental force буюу хүрээлэн буй орчин зэрэг хүчин зүйлээр цогц

хэлбэрээр авч үзэн нөхцөл байдлаа бодитоор тогтоон үнэлж дүгнэж байх шаардлагатай байна.

Дэвшүүлэх санал.

1. Эрсдэлийн удирдлагыг бүх шатанд нэвтрүүлж эрсдэлээ бүрэн тодорхойлох, түүнийг бууруулах, саармагжуулахад чиглэсэн “Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй

байдлын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө”-г боловсруулан жил бүр үр дүнг тооцож ажиллах.

2. Ажлын байрны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг тодорхой хөрөнгө, төсөв гарган шийдвэрлэн алба хаагчийн ажиллах орчин нөхцлийг сайжруулахад онцгой анхаарах.

Ашигласан эх сурвалж.

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1992 он. №1.
2. Цагдаагийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017 он. №8.
3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2008 он. №21.
4. Байгууллагын нууцын тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1995 он. №7
5. Цагдаагийн ерөнхий газар. Гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон цагдаагийн алба хаагчдын өнөөгийн байдал. судалгааны ажлын тайлан. 2016.
6. Цагдаагийн ерөнхий газар. Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтэс. гарын авлага. – УБ., 2019.
7. Цагдаагийн ерөнхий газар. Эрсдэлийн үнэлгээний тайлан. – УБ., 2020.
8. Цагдаагийн ерөнхий газар. Эрсдэлийн үнэлгээний тайлан. 2020.
9. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 6/169 тушаал. Хүний нөөцийн бодлогын баримт бичиг.
10. ЦЕГ-ын Дотоод хяналт, аюулгүй байдлын газар, Судалгаа, дүн шинжилгээний төв. Цагдаагийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг, зөрчил, харилцаа, ёс зүйн өнөөгийн байдал” судалгааны ажлын тайлан. – УБ., 2020.

**ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД ХӨШҮҮРГИЙГ ТАТАХ
АРГЫГ АШИГЛАХ БА АНХААРВАЛ ЗОХИХ ЗАРИМ АСУУДАЛ**
USING LEVERS IN CRIME PREVENTION AND SOME
ISSUES TO BE AWARE OF

Б.Баянмөнх

Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн эрхлэгч,
доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа
byanmunkh@uia.gov.mn

B. Bayanmunkh

Head of Police Law, University of Internal Affairs
Doctor of Law (Ph. D), Police Lieutenant Colonel
University of Internal Affairs
State Email: bayanmunkh@uia.gov.mn

Хураангуй. Хөшүүргийг татах арга нь асуудалд тулгуурласан үйл ажиллагааны аргыг баримталдаг боловч, асуудалд тулгуурласан үйл ажиллагааны хөтөлбөрүүдээс илүү өргөн хүрээнд олон зорилтуудыг агуулдаг.

Энэхүү өгүүлэлд хөшүүргийг татах аргын тухай ойлголт, түүнийг гэмт хэрэгтэй тэмцэх ажилд хэрхэн ашиглах, юунд анхаарах талаар товч авч үзсэн болно.

Abstract. The leveraging approach follows a problem-based action approach, but includes a broader range of objectives than problem-based action programs.

This article provides a brief overview of the concept of leverage, how it can be used in crime fighting, and what to look out for.

Түлхүүр үг. Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа, хөшүүргийг татах арга, үндсэн элемент, нөөц, хүч хэрэгсэл

Key word. Problem-based policing, lever pulling method, core elements, resources and power tools

Үндсэн хэсэг. Дэлхий даяар нэг жилд л 10-29 насны 200,000 хүүхэд, залуус гэмт хэрэг, хүчирхийллийн улмаас амь насаа алдаж байна. Хүн амины хэрэг нь хүүхэд, залуучуудын нас баралтын дөрөв дэх тэргүүлэх шалтгаан болоод байгаа ба үүнээс гадна хүчирхийлэлд өртсөн сая сая хүүхэд, залуус яаралтай эмнэлгийн тусламж шаардсан гэмтэл, бэртэл авч, үүнээс ч олон залуус хүчирхийллийн улмаас сэтгэцийн эрүүл мэндээрээ хохирч, архи, тамхи, согтууруулах болон мансууруулах бодис хэрэглэх, аюултай бэлгийн харилцаанд орох зэрэг эрсдэлт зан үйлтэй болж байна.

Хүүхэд, залуучуудын дундах хүчирхийлэл нь өртсөн хүн, тэдний хайртай дотнын хүмүүс, найз нөхдөд сэтгэл санааны асар их хор хохирол учруулж, амьдралыг нь сүйтгэдэг. Хүчирхийллээс үүдэлтэй эдгээр үр дагавар нь нийгэмд ч тэр, хохирогчдын ар гэрт ч тэр эдийн засгийн хүнд дарамт болдог.⁶⁴

⁶⁴ Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь: нотлох баримтын тойм. Нээлттэй нийгэм форум. -Уб., 2017. 8 дахь тал

Залуучуудын дундах хүчирхийлэл нь янз бүрийн түвшний хүчин зүйлстэй холбоотой бөгөөд хүний амьдралын янз бүрийн үе шатанд илэрч болно. Хувь хүний түвшний эрсдэлт хүчин зүйлсэд өмнө нь гэмт хэрэг, зөрчилд холбогдож байсан юмуу түрэмгий зан гаргаж байсан түүх; хэт хөдөлгөөншил, зан төлөвийн өөрчлөлт зэрэг сэтгэлзүйн байдал; согтууруулах ундаа, хар тамхины хэрэглээ багтана. Ойрын хүрээллийн эрсдэлт хүчин зүйлсэд:

- эцэг эхийн анхаарал дутмаг нөхцөлд өсөх;
- эцэг эх нь хатуу ширүүн, тууштай бус хүмүүжлийн арга хэмжээ хэрэглэж ирсэн;
- эцэг эх нь гэмт хэрэгт холбогдож байсан;
- хэрэг зөрчил гаргадаг залуустай найзлах зэрэг багтана.

Гэмт хэрэг гарах эрсдэлт хүчин зүйлсэд тухайн нутаг дэвсгэрийн гэмт хэргийн гаралт; гэмт хэрэг гарах нөхцөл; мансууруулах бодис, согтууруулах ундааны хялбар олдоц; ажилгүйдэл; орлогын ялгаа, ядуурал төвлөрсөн байх зэрэг багтана.

Гадаадын улс орнуудад хэрэгжүүлж байгаа залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд нь хүчирхийлэлд хүргэдэг эрсдэлт хүчин зүйлсийн нөлөөллийг багасгах, эсвэл өөр бусад арга замаар хувь хүн, орон нутгийн түвшний эрсдэлт хүчин зүйлсийн сөрөг нөлөөллөөс залуу хүмүүсийг хамгаалах зорилго агуулдаг.

Анх Бостон хотноо өсвөр насны болон залуучууд хүч хэрэглэх явдал газар авч байх үед ашигласан хөшүүргийг татах арга нь хууль сахиулагчдыг нэгтгэн гэмт хэргийн асуудалд дүн шинжилгээ хийлгэж, түүнд тохирсон шинэлэг шийдлийг боловсруулахад хүргэсэн байна.

Үйл ажиллагааны энэхүү арга нь зөрчил гаргагчдыг цаашид гэмт зан үйл үйлдэхээс татгалзуулах хэд хэдэн төрлийн “хөшүүргийг” бий болгодог бөгөөд зөвхөн цагдаагийн үйл ажиллагааг бус, нийгмийн ажил болон орон нутгийн нөөц хүч, хэрэгслийг ашигладаг байна.⁶⁵

Гадаадын зарим оронд нэвтрүүлсэн хөшүүргийг татах арга, түүнийг хэрэглэх хэрэгцээ шаардлага үр дүнгийн талаар зарим зарим ном бүтээл, гарын авлагад хэрхэн тусгасаныг тоймлон авч үзье.

Сурлагаар хоцрох. Залуу хүн хүчирхийлэл үйлдэх, түүнд өртөх нь сурлагаар хоцрох явдалтай холбоотой байна. Хүчирхийлэлд оролцдог залуучууд хичээл сурлагаар тааруу, хичээлээ таслах, сургууль завсардах өндөр эрсдэлтэй байдаг. АНУ-д хийсэн судалгаагаар сурагчдын 6 хувь нь сургууль дээрээ, мөн сургуульд хүрэх, буцах замдаа аюулд өртөхөөс айж судалгаанаас өмнөх нэг сарын хугацаанд нэг ба түүнээс олон хоногоор хичээлдээ яваагүй гэж мэдээлжээ.⁶⁶ Дунд ангийн хүүхэд түрэмгий зан гаргах нь сургууль завсардахын урьтач шинж тэмдэг болдог байна.⁶⁷

⁶⁵ Catalano RF, Oesterle S, Fleming CB, Hawkins JD. The importance of bonding to school for healthy development: Findings from the Social Development Research Group. *Journal of School Health*. 2004;74(7):252–61

⁶⁶ Eaton DK, Kann L, Kinchen S, Shanklin S, Flint KH, Hawkins J, et al. Youth risk behavior surveillance – United States, 2011. *Morbidity and mortality weekly report surveillance summaries* (Washington, DC: 2002). 2012;61(4):1–162

⁶⁷ Kokko K, Tremblay RE, Lacourse E, Nagin DS, Vitaro F. Trajectories of prosocial behavior and physical aggression in middle childhood: Links to adolescent school dropout and physical violence. *Journal of Research on Adolescence*. 2006;16(3):403–28

Эдийн засгийн зардал. Залуучуудын дундах хүчирхийллийг эд зүйлс, дэд бүтцийг эвдэн сүйтгэх явдал дагалдах нь их байдаг бөгөөд хүчирхийллийн “халуун цэг” буюу хүчирхийлэл их гардаг газар⁶⁸ үл хөдлөх хөрөнгийн үнэ ханш буурах хамаарал байдаг.

Насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн хүчирхийлэл нийгэмд онцгой өндөр үнэтэй тусдаг. Хохирогчтой холбоотойгоор эмнэлгийн үйлчилгээний шууд зардал, ирээдүйн орлогын алдагдал, олон нийтийн хөтөлбөр хэрэгжүүлэх төсөв, эд хөрөнгийн хохирол, амьдралын чанарын алдагдал зэрэг зардал гардаг.

Согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ. Хувь хүний түвшинд авч үзэх юм бол согтууруулах ундааны хэрэглээ нь танин мэдэхүйн чадвар, бие махбодын үйл ажиллагаанд шууд нөлөөлж, өөрийгөө хянах, мэдээллийг боловсруулах, эрсдэлийг үнэлэх чадварыг бууруулдаг. Энэ нь хүний цочмог занг улам өдөөн даамжруулдаг тул зарим хүнийг хүчирхийлэл үйлдэхэд түлхэх магадлалтай.

Архи, согтууруулах ундаа эрт ууж эхэлсэн, тогтмол хэрэглэдэг залуучуудын хүчирхийлэл үйлдэх, түүнд өртөх эрсдэл нэмэгддэг. Орон нутаг, нийгмийн түвшинд хүн олноор цуглардаг, хяналт зохион байгуулалт муутай баар цэнгээний газрууд нь хүчирхийлэл гарах нөхцөл болдог байна.⁶⁹

Өрхийн нийгэм, эдийн засгийн байдал. Ядуу тарчиг амьдрал нь хүчирхийлэл үйлдэх эрсдэлийг нэмэгдүүлдэг нь тогтоогдоод байгаа ба өрхийн болон орон нутгийн түвшний ядуурал нь хүчирхийлэл гарах нөхцөл болдог байна.⁷⁰ Дунд ба өндөр орлоготой өрхийн залуучуудтай харьцуулахад нийгэм, эдийн засгийн боломж муутай өрхийн өсвөр насны хүүхэд, залуусын хүчирхийлэлд оролцох эрсдэл нь хоёр дахин өндөр гарчээ.⁷¹ Эцэг эхийн нэг нь, эсвэл хоёулаа ажилгүй гэр бүлд өсөж байгаа өсвөр насныхны хүчирхийлэлд холбогдох эрсдэл нэмэгддэг ажээ.⁷² Эцэг, эхийн нийгэм, эдийн засгийн боломж нь үе тэнгийнхнээ дарамтлан дээрэлхэх, эсвэл өөрөө дарамтлуулж дээрэлхүүлэх эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болдог байна.⁷³

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой 21 стратеги нь дөрвөн чиглэлд төвлөрч байгаа ба эдгээр нь:

- Эцэг эхийн боловсрол, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих стратегиуд
- Сургуульд түшиглэсэн сурлагын амжилт, нийгмийн харилцааны чадварыг дэмжих стратегиуд
- Хүчирхийлэл үйлдэх өндөр эрсдэлтэй, эсвэл өмнө нь хүчирхийлэлд холбогдож байсан залуучуудад чиглэсэн стратегиуд
- Орон нутаг болон нийгмийн түвшний стратегиуд болно.⁷⁴

⁶⁸ Mercy JA, Butchart A, Farrington D, Cerdá M. In: World report on violence and health 2002. Geneva: World Health Organization; 2002:23–56.

⁶⁹ Homel R, Clark J. The prediction and prevention of violence in pubs and clubs. Crime Prevention Studies. 1994;3:1–46.

⁷⁰ Lynch JP, Pridemore WA. Crime in international perspective. Crime and public policy. 2011;5–52.

⁷¹ Elliott DS, Huizinga D, Menard S. Multiple problem youth: delinquency, drugs and mental health problems. New York, NY: Springer Science & Business Media; 1989.

⁷² Farrington DP. Childhood, adolescent and adult features of violent males. Aggressive Behavior; 994:215–40.

⁷³ Jansen PW, Verlinden M, Dommisse-van Berkel A, Mieloo C, van der Ende J, Veenstra R et al. Prevalence of bullying and victimization among children in early elementary school: Do family and school neighbourhood socioeconomic status matter? BMC. Public Health. 2012;12(1):494

⁷⁴ Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь: нотлох баримтын тойм. Нээлттэй нийгэм форум. -УБ., 2017. 25 дахь тал

Өмнөд болон Зүүн Африкийн бүсийн орнуудын өсвөр насныхны сургууль завсардах, боловсролын түвшин доогуур, насанд хүрсэн хойноо ажил олж чадахгүй байх зэрэг нь хүчирхийлэлд хөтөлдөг эрсдэлт хүчин зүйл болдог бол хичээл таслахгүй байх, боловсролын түвшин ахиулах зэрэг нь хүчирхийллийн эсрэг хамгаалагч хүчин зүйл болдог байна. Иймд хичээл таслахгүй байх нөхцөлтэй урамшуулал нь өсвөр насныханд нөлөөлж чадах хөшүүрэг болж байна.

Сургуульд түшиглэсэн бодлого, хөтөлбөрийн дотроос амьдрах ухааны ба нийгмийн харилцааны ур чадвар эзэмшүүлэх хөтөлбөр, үе тэнгийн дарамт дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр үр нөлөөтэй байх өндөр магадлалтай гэж үнэлэгдсэн бол сурлагын амжилтыг ахиулах хөтөлбөр, хичээл таслахгүй нөхцөлтэйгээр өсвөр насныханд санхүүгийн урамшуулал олгох хөтөлбөр, хичээлийн бус цагийн болон чөлөөт цагийн бусад арга хэмжээ зэргийг үргэлжлүүлэг судалж, үр нөлөөтэй эсэхийг нь тогтоох шаардлагатай байна

Хичээлийн ирцийг нэмэгдүүлэх зорилгоор нөхцөлт мөнгөн дэмжлэг олгох, сургалтын ваучер (эрхийн бичиг) өгөх, буцалтгүй тусламж болон хичээлийн хэрэгсэл үнэгүй олгох, сургуульдаа ирэхдээ нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчих зэрэг арга хэмжээ багтана.⁷⁵

Өсвөр насныхны хичээлийн ирцийг дэмжих санхүүгийн урамшууллын хөтөлбөр

Энэхүү стратегид хичээлийн ирцийг нэмэгдүүлэх зорилгоор нөхцөлт мөнгөн дэмжлэг олгох, сургалтын ваучер (эрхийн бичиг) өгөх, буцалтгүй тусламж болон хичээлийн хэрэгсэл үнэгүй олгох, сургуульдаа ирэхдээ нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчих зэрэг арга хэмжээ багтана.

Сургууль завсардах, боловсролын түвшин доогуур, насанд хүрсэн хойноо ажил олж чадахгүй байх зэрэг нь хүчирхийлэлд хөтөлдөг эрсдэлт хүчин зүйл болдог бол хичээл таслахгүй байх, боловсролын түвшин ахиулах зэрэг нь хүчирхийллийн эсрэг хамгаалагч хүчин зүйл болдог. Сургуульдаа дуртай байх нь хүчирхийлэлтэй урвуу хамааралтай болох нь нотлогдоод байна.⁷⁶ Иймд хичээл таслахгүй байх нөхцөлтэй урамшуулал нь өсвөр насныханд нөлөөлж чадах хөшүүрэг болж байна.

Нотолгоо Хичээл таслахгүй байх нөхцөлтэй мөнгөн тэтгэмж, санхүүгийн бусад урамшуулал нь залуучуудын дундах хүчирхийллийн гаралтад хэрхэн нөлөөлж байгааг авч үзсэн үнэлгээний тайлан олдсонгүй.⁷⁷ Гэхдээ санхүүгийн урамшуулал, боловсролын тэтгэмж, тэтгэлэг нь хүчирхийллээс хамгаалах хүчин зүйл болох сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх нөлөөтэй байна.⁷⁸ Өсвөр насны хүүхэд нь сургуульд явж байх нөхцөлтэйгөөр гэр бүлд тэтгэмж олгодог

Мексикийн “Опортунидадес” хөтөлбөрийн (Oportunidades буюу боломж) үр дүнд дунд сургуулийн хамрагдалт 8 хувиар өсжээ.⁷⁹ Бразилд “Болса Эскола” хөтөлбөр (Bolsa

⁷⁵ Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь: нотлох баримтын тойм. Нээлттэй нийгэм форум. -УБ., 2017. 45 дахь тал

⁷⁶ Catalano RF, Oesterle S, Fleming CB, Hawkins JD. The importance of bonding to school for healthy development: Findings from the Social Development Research Group. *Journal of School Health*. 2004;74(7):252–61.

⁷⁷ Slavin R. Can financial incentives enhance educational outcomes? Evidence from international experiments. *Best Evidence Encyclopeida (BEE)*. 2009

⁷⁸ Behrman JR, Parker SW, Todd PE. Do conditional cash transfers for schooling generate lasting benefits? A five-year followup of PROGRESA/Oportunidades. *Journal of Human Resources*. 2011;46(1):93–122.

⁷⁹ Fernald LC, Gertler PJ, Neufeld LM. 10-year effect of Oportunidades, Mexico's conditional cash transfer programme, on child growth, cognition, language, and behaviour: a longitudinal followup study. *The Lancet*. 2009;374(9706):1997–2005.

Escola буюу сургуулийн тэтгэмж) хэрэгжүүлснээр сургууль завсардалт буурсан дүн гарчээ⁸⁰.

Өсвөр насныхны хичээлийн ирцийг дэмжих мөнгөн тэтгэмж, санхүүгийн бусад урамшуулалт хөтөлбөр хэрэгжүүлэх нь Латин Америкийн орнууд, Турк, АНУ, бусад оронд өсвөр насныхныг дунд сургуулиас завсардуулахгүй байх анхдагч ба хоёрдогч зорилготой мөнгөн тэтгэмжийн томоохон хөтөлбөрүүд хэрэгжсэн.

Эдгээр хөтөлбөр нь нэг гэр бүл юмуу нэг хүүхдэд ногдох хэмжээгээр тооцон бэлэн мөнгө олгодог ба ингэхдээ өсвөр насны хүүхэд нь хичээлийн нэг өдрийн 80-аас доошгүй хувийг хичээлдээ сууж өнгөрөөх нөхцөл тавьдаг.

Мөнгөн тэтгэмж нь сургуулийн төлбөр, хичээлийн хэрэгсэл зэрэг шууд зардлыг санхүүжүүлэх, мөн хүүхдээ сургуульд явуулснаар тухайн гэр бүлд учирч болох боломжит орлогын алдагдлыг нөхөх зориулалттай. Жишээлбэл, Бразилд Болса Эскола хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хүүхдийг хөдөлмөр эрхлэлтээс хамгаалж, сургууль завсардахаас сэргийлэх зорилт тавьжээ. Хүүхэд нь сургуульд баталгаатай явж байгаа тохиолдолд өрх хоёр сар тутамд 15 бразил реал авдаг байна.⁸¹

Мексик: Сургуулиа төгсөх нөхцөлтэй залуучуудын урамшууллын хөтөлбөр

Опортунидадес (Боломж) хөтөлбөр бол Мексикийн ядуурлыг бууруулах үндсэн хөтөлбөр юм. Хөтөлбөр нь өрхийн эрүүл мэнд, боловсрол, хоол тэжээлийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор мөнгөн тэтгэмж олгодог ба үүнд тухайн өрхийн 22 хүртэлх насны хүүхдүүдэд сургуулиа төгсөх нөхцөлтэйгөөр олгох боловсролын тэтгэмж багтдаг.

Хэд хэдэн удаагийн үнэлгээгээр уг хөтөлбөр нь залуучуудын сургуульд хамрагдалт, сургуульд суралцах нийт жил, сургууль завсардалтын хувь хэмжээ, ажил олох магадлал зэрэгт эерэг нөлөө үзүүлсэн дүн гарчээ. Согтууруулах ундаа, тамхины хэрэглээ болон өндөр эрсдэлтэй бэлгийн зан үйл багассан байхад бэлгийн хамтрагчийн хүчирхийлэлд хэрхэн нөлөөлөх нь тодорхойгүй байна. Харин залуучуудыг хүчирхийллээс хамгаалах хөтөлбөр хэрхэн нөлөөлж байгааг үнэлээгүй байна. 1997 онд хөдөөний ядуу орон нутгуудад хэрэгжиж эхэлсэн уг хөтөлбөр яваандаа хот суурин газрыг хамруулан тэлсээр, одоо дөрвөн сая орчим өрхөд хүрч үйлчилж байна.⁸²

Хэрэгжих болон хүлээн зөвшөөрөгдөх боломж. Нөхцөлт мөнгөн тэтгэмж, санхүүгийн урамшууллын хөтөлбөрүүд нь янз бүрийн орчин нөхцөлд өргөнөөр дэмжигддэг. Нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хөтөлбөр нь хүн амын ядуу хэсэгт илүү нөлөөлж, эрүүл аюулгүй зан үйл хэвшүүлэх, нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлдэг. Заримдаа нөхцөлт тэтгэмж, санхүүгийн урамшуулалд хамрагдах болзлыг хангахын тулд эрсдэлт зан үйл улам нэмэгдэх тохиолдол гарч болзошгүй. Мөн бэлэн мөнгө, санхүүгийн урамшуулал нь бэлэнчлэх сэтгэлгээг бий болгож, бусад эх сурвалжаас олсон орлогоо эрүүл бус зан үйлд шилжүүлэн зарцуулах тул үр дүнгүй, мөн авлига өгөх нөхцөл болно гэх зэрэг шүүмжлэл гардаг.⁸³

⁸⁰ Ferro AR, Kassouf AL. Avaliação do impacto dos programas de bolsa escola sobre o trabalho infantil no Brasil. Pesquisa e Planejamento Econômico. 2005;35(3):417–44

⁸¹ Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь: нотлох баримтын тойм. Нээлттэй нийгэм форум. -Уб., 2017. 45 дахь тал

⁸² Fernald LC, Gertler PJ, Neufeld LM. 10-year effect of Oportunidades, Mexico's conditional cash transfer programme, on child growth, cognition, language, and behaviour: a longitudinal followup study. The Lancet. 2009;374(9706):1997–2005

⁸³ Attanasio O, Battistin E, Fitzsimons E, Mesnard A, Vera-Hernandez M. How Effective are Conditional Cash Transfers? Evidence from Colombia. London: Institute for Fiscal Studies, 2005

Зардал. Хөтөлбөрийн зардал нь нөхцөл байдлаас хамаарч янз бүр байдаг. Ерөнхийдөө нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээ нь өсвөр насны хүүхдийн боломжит орлогоос бага байх ёстой ба том болсон хүүхдээ сургуульд явуулахтай холбоотой гэр бүлийн шууд бус зардал өсөх, мөн өсвөр насны хүүхдэд хар тамхины наймаа гэх мэт их орлоготой ч эрсдэлтэй зүйлд оролцох боломж байдаг зэргийг тооцоолох ёстой. Хүүхдийн боловсролтой холбоотой мөнгөн тэтгэмжийн зэрэгцээ нэмэлт хэд хэдэн дэмжлэг багтаасан Бразилийн “Болса Фамилия” хөтөлбөр (Bolsa Familia буюу өрхийн тэтгэмж) нь ойролцоогоор ДНБ-ийн 0.5 хувьтай тэнцэх хэмжээний зардлаар хэрэгждэг байна.⁸⁴

Манай улсын хувьд цагдаагийн хэсгийн байцаагч өөрийн хариуцсан нутаг дэвсгэрт амьдардаг ажилгүй иргэдийг хорооны Засаг дарга болон нийгмийн ажилтнуудтай хамтран дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээр дамжуулан ажилд зуучлах арга хэмжээг зохион байгуулдаг нь энэхүү хөшүүрэг татах аргын нэг хэлбэр гэж үзэж болно.

Гэхдээ хөшүүргийг татах энэхүү аргыг тусгасан эрх зүйн зохицуулалт манай улсын хууль тогтоомжид байхгүй байна. Энэ нь төсөв санхүүгийн эх үүсвэр, зардал шийдвэрлэх боломж нөхцөл манай улсын хувьд хязгаарлагдмал байдагтай салшгүй холбоотой юм.

Дүгнэлт. Гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй, сургууль завсардах магадлалтай, сэтгэл зүйн хувьд тогтворгүй, ар гэрийн хувьд анхаарал халамж муу, хичээл тасалдаг хүүхдүүдэд хөшүүргийг татах аргыг ашиглан сурлагын амжилт, сурах үйл явцад нөлөө үзүүлж чадвал гэмт хэрэг үйлдэх магадлалыг бууруулж, үзүүлэх үр нөлөө өндөр байж магадгүй юм.

Энэхүү сурлагын амжилтыг дэмжих хөтөлбөрийг нэвтрүүлсэнээр бага, дунд орлоготой зарим өрхөд өсч буй гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй хүүхдүүдийн бичиг үсэг, тоо бодох чадвар, сурлагын амжилтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ нийгмийн дасан зохицлыг сайжруулах боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Насанд хүрээгүй хүүхэд гэмт хэрэг, зөрчилд хамгийн их холбогдож, аймаг, нийслэл, сум, дүүргийн алслагдсан баг, хороонд байгаа нэг сургуульд сурлагын амжилтыг дэмжих хөтөлбөрийг нэвтрүүлж туршиж, үр дүнг тооцож үзэх

2. Сурлагын амжилтыг дэмжих хөтөлбөрийг нэвтрүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангаас шийдвэрлэх

3. Мексик улсад нэвтрүүлж тодорхой үр дүнд хүрсэн “Сургуулиа төгсөх нөхцөлтэй залуучуудын урамшууллын хөтөлбөр”-ийг судалж, нэвтрүүлж болох судалгааг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс захиалан ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгээр хийлгүүлэх.

Ашигласан материал

1. Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь: нотлох баримтын тойм. Нээлттэй нийгэм форум. -УБ., 2017
2. Catalano RF, Oesterle S, Fleming CB, Hawkins JD. The importance of bonding to school for healthy development: Findings from the Social Development Research Group. Journal of School Health. 2004;

⁸⁴ Lindert K. Brazil: Bolsa Familia Program – scaling-up cash transfers for the poor. 2006. In: Sourcebook on emerging good practice in managing for development results [Internet]. Washington D.C: World Bank

3. Eaton DK, Kann L, Kinchen S, Shanklin S, Flint KH, Hawkins J, et al. Youth risk behavior surveillance – United States, 2011. Morbidity and mortality weekly report surveillance summaries (Washington, DC: 2002).
4. Kokko K, Tremblay RE, Lacourse E, Nagin DS, Vitaro F. Trajectories of prosocial behavior and physical aggression in middle childhood: Links to adolescent school dropout and physical violence. *Journal of Research on Adolescence*. 2006;
5. Mercy JA, Butchart A, Farrington D, Cerdá M. In: World report on violence and health 2002.
6. Homel R, Clark J. The prediction and prevention of violence in pubs and clubs. *Crime Prevention Studies*. 1994;
7. Lynch JP, Pridemore WA. Crime in international perspective. *Crime and public policy*. 2011;
8. Elliott DS, Huizinga D, Menard S. Multiple problem youth: delinquency, drugs and mental health problems. New York, NY: Springer Science & Business Media; 1989.
9. Farrington DP. Childhood, adolescent and adult features of violent males. *Aggressive Behavior*: Springer; 1994;
10. Jansen PW, Verlinden M, Dommisse-van Berkel A, Mieloo C, van der Ende J, Veenstra R et al. Prevalence of bullying and victimization among children in early elementary school: Do family and school neighbourhood socioeconomic status matter? *BMC. Public Health*. 2012;
11. Catalano RF, Oesterle S, Fleming CB, Hawkins JD. The importance of bonding to school for healthy development: Findings from the Social Development Research Group. *Journal of School Health*. 2004;
12. Slavin R. Can financial incentives enhance educational outcomes? Evidence from international experiments. *Best Evidence Encyclopaedia (BEE)*. 2009
13. Behrman JR, Parker SW, Todd PE. Do conditional cash transfers for schooling generate lasting benefits? A five-year followup of PROGRESA/Oportunidades. *Journal of Human Resources*. 2011;
14. Fernald LC, Gertler PJ, Neufeld LM. 10-year effect of Oportunidades, Mexico's conditional cash transfer programme, on child growth, cognition, language, and behaviour: a longitudinal followup study. *The Lancet*. 2009;
15. Ferro AR, Kassouf AL. Avaliação do impacto dos programas de bolsa escola sobre o trabalho infantil no Brasil. *Pesquisa e Planejamento Econômico*. 2005;
16. Attanasio O, Battistin E, Fitzsimons E, Mesnard A, Vera-Hernandez M. How Effective are Conditional Cash Transfers? Evidence from Colombia. London: Institute for Fiscal Studies, 2005
17. Lindert K. Brazil: Bolsa Familia Program – scaling-up cash transfers for the poor. 2006.

БАЙГУУЛЛАГЫН СОЁЛД ХАМТ ОЛНЫ СЭТГЭЛ ЗҮЙ НӨЛӨӨЛӨХ НЬ

THE INFLUENCE OF COMMUNITY PSYCHOLOGY ON ORGANIZATIONAL CULTURE

Цагдаагийн хурандаа Б.Алтанзул/Ph.D/

Police colonel B.Altanzul

e-mail:altanzul0710@gmail.com

Хураангуй: Аливаа байгууллага нь үйл ажиллагааны төрөл хэлбэр, ажиллаж буй хүрээ хязгаараас үл хамааран нийтлэг соёл, үнэт зүйл бүрэлдэн тогтож, энэ нь тухайн байгууллагын хөгжлийн гол тулгуур болдог. Тиймээс ч агуулгын хувьд өргөн хүрээтэй, нарийн төвөгтэй асуудал бөгөөд удирдлагуудын зүгээс өндөр ур чадвар шаарддаг. Өнөөдөр манай улсад олон байгууллагууд хөл дээрээ зогсож, тогтвортой ажиллаж эхэлсэн боловч цаашид улам бүр хөгжиж, өрсөлдөх чадвараа дээшлүүлэхийн тулд байгууллагын соёлд хамт олны сэтгэл зүйн нөлөөллийн асуудлыг анхаарч үзэх шаардлага урган гарч байна. Байгууллагын соёл байгууллага үүссэн цаг үеээс бий болдог.

Энэхүү өгүүлэлд байгууллагын соёлд хамт олны сэтгэл зүй хэрхэн нөлөөлдөг болох, түүний хэрэгцээ шаардлага, ач холбогдлын талаар товч авч үзсэн болно.

Abstract: Regardless of the type of activity and scope of any organization, a common culture and values are formed, and this is the main pillar of the organization's development. Therefore, it is a broad and complex issue in terms of content and requires high skills from the management. Today, many organizations in our country have started to stand on their feet and work stably, but in order to further develop and improve their competitiveness, there is a need to pay attention to the psychological impact of the community on the organizational culture. Organizational culture is created from the time when the organization was created.

This article briefly discusses how community psychology affects organizational culture, its needs, and its importance.

Түлхүүр үг: Байгууллагын соёл, хандлага, хамт олон, сэтгэл зүй

Keywords: organizational culture, attitude, team, psychology

Үндсэн хэсэг. Байгууллагын соёл хүмүүсийн сэтгэл зүйлд үйлчилдэг хийсвэр ойлголт бөгөөд соёлыг бүрдүүлж, соёлын хэм хэмжээ илэрч байдаг олон хүчин зүйлс байгууллагын үйл ажиллагаанд тусгалаа олж байдаг. Өөрөөр хэлбэл байгууллагын соёл нь байгууллагын бусдаас ялгарах, байгууллагын доторх хамт олны янз бүрийн үзэл бодлыг нэгтгэж байдаг хүчин зүйл юм.

Тиймээс ч байгууллагын үйл ажиллагаанд хамт олны сэтгэл зүй нөлөөлөх шаардлагыг харгалзан онол арга зүйд тулгуурлан байгууллагын дотоод харилцаанд дүн шинжилгээ хийсэн. Байгууллагын соёлд хамт олны сэтгэл зүйг нөлөө нь тухайн байгууллагын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, тогтвортой хөгжлийг хангана.

Байгууллагын соёл нь агуулгын хувьд өөрөө их өргөн хүрээтэй, энэ талаарх судалгаа шинжилгээ нь байгууллагууд дээр янз бүрээр хийгдсэн байдаг. Хүмүүсийн ажиллах сонирхол нь техник төхөөрөмж, материаллаг байдлаас гадна байгууллагын соёл, үнэт зүйлээс ихээхэн шалтгаалдаг талаар Эдгар Шейн, Джоан Мартин зэрэг судлаачдын бүтээлүүд, мөн Ц.Цолмон, П.Увш, Д.Доржжав, Д.Болормаа, Б.Хэрлэн, Б.Батсайхан, М.Дэлгэржав зэрэг эрдэмтэн, судлаачид менежмент, зан үйлийн хүрээнд хамт олны уур

амьсгал, соёлыг судалсан байдаг. Байгууллагын соёлын талаарх онолын гурван гол хандлага байдаг (Г.Цэрэн.Г, Гантуяа.Л, 2008). Үүнд: бэлэг тэмдгийн хандлага, танин мэдэхүйн хандлага, системийн хандлага багтдаг.

- Бэлэг тэмдгийн хандлага:

1. Аливаа өрнөж байгаа үйл явдлын утга санаа, түүнийг хэрхэн тайлбарлаж байгаа нь жинхэнэ үйл яввлаас илүү чухал.
2. Тодорхойгүй, тогтворгүй байдал нь асуудлыг оновчтой шийдэх, шийдвэр гаргахад саад болдог.
3. Тогтворгүй нөхцөл байдалд тодорхойгүй байдлыг багасгах, чиг баримжаагаа олохын тулд бэлэг тэмдгийг хэрэглэдэг. Сүлд, туг, шог хошиг яриа, дурсамж, зуршил, уламжлал зэрэг.

Бэлэг тэмдгийг байгууллагын гишүүд адил утгаар ойлгож байгаа үед үр дүнгээ өгдөг.

- Танин мэдэхүйн хандлага:

Байгууллага нь хамт олон гишүүн нэг бүрийн бодол санаа, хамтын хөдөлмөрийн үр дүнгээс ихээхэн шалтгаалдаг. Тиймээс ч тэдгийг зан үйл, хамтын ухамсар, нийтлэг болсон итгэл үнэмшил, хуримтлагдсан мэдлэгийн үндсэн дээр бүрэлддэг.

- Системийн хандлага:

1. Гишүүдийн зан үйлийн харагдах байдлаар, тэднийяриа, материаллаг эд зүйлстэй харьцах байдал.
2. Гишүүдэд ухамсарлагдсан, тэднийг нэгтгэж байгаа итгэл үнэмшил, үнэлэмж, үзэл санаа зэргийг авч үздэг.

Джоан Мартин “1999 бид ямарваа байгууллагатай харьцах үед хүмүүсийнх нь хувцаслах өвөрмөц маяг, тэнд юу болдог тухай найз нөхдийн яриа, ажлын тогтсон дүрэм журам, бүгдээрээ мөрддөг зан үйлийн хэм хэмжээ, уламжлал, үүрэг даалгавар, цалин хөлсний систем, өвөрмөц үг хэллэг, хошин яриа зэрэгтэй учирдаг. Энэ бүгд бол байгууллагын соёлын бүрэлдэхүүнхэсэг бөгөөд түүний илрэл юм” гэжээ. Джоан Мартинь тодорхойлолтоос байгууллагын соёл бол бусдаас өвөрмөц харагдаж үзэгдэх дүр төрх юм.

Байгууллагын соёлыг бодит байдал ба сэтгэл зүйн орчин гэсэн хоёр талаас авч үзэх нь бий. Бодит байдалд байгууллагын бүтэц, хэмжээ, удирдлагын хэв маяг, байгууллагын зорилго гэх мэтийг хамааруулан авч үздэг.

Сэтгэл зүйн орчинд сэтгэгдэл, ажилчид нь байгууллагынхаа талаар ямар бодол сэтгэгдэлтэй явдаг, түүний төлөвшилзэргийг хамруулан авч үздэг. Байгууллагын соёлын талаар олон тодорхойлолт байдаг. Жишээ нь:Байгууллагын бүх гишүүдийн нийтлэг үзэл баримтлал, үнэт зүйлсийн тогтолцоог соёл гэнэ, Ажиллагсдын сэтгэл зүй, үзэл суртлаар удирдах гол эх үүсвэр нь байгууллагын соёл байдаг гэх мэт тодорхойлолт байдаг. Соёл бол байгууллага үүссэн цагаас бүрэлдэн, үеэс үед дамжин бэхжих туршлага юм хэмээн тодорхойлсон (Эдгар Шейн, 2008).

Байгууллагын соёл гэдэг нь тухайн байгууллагын бусдаас ялгарах онцлог, байгууллага доторх гишүүдийн янз бүрийн үзэл бодлыг нэгтгэж байдаг хүчинз үйл юм. . Байгууллагын соёлыг тухайн байгууллагын удирдагч тодорхойлж гаргах ба хамт олон түүнийг хэрэгжүүлдэг.

Байгууллагын соёлын талаар яригдахад байгууллага дахь хамт олны сэтгэл зүйн төлөвшил, харилцаа хандлагыг зайлшгүй судлах шаардлага гарна .Хамт олны сэтгэл зүй гэдэг нь гишүүдийн хэрэгцээ, ашиг сонирхол, үзэл бодол, итгэл үнэмшил, байр суурь,

сэтгэл хөдлөл, харилцаа зэргийг багтаасан цэгцтэй ойлголтыг хэлнэ. Хамт олны сэтгэл зүйг бүтцийн хувьд: бүлгийн өөрийн ухамсар, сэтгэл зүйн харилцаа, нийгэм сэтгэл зүйн явц гэсэн гурван үндсэн хэсэгт хуваан авч үзнэ.

Бүлгийн ухамсар нь бүлгийн сэтгэл зүйн цөм болох бөгөөд тогтсон хандлага итгэл үнэмшил, уламжлал, үнэлэмж, баримжаалал зэргийг хамааруулна. Сэтгэл зүйн харилцаа гэдэг нь хамт олны харилцан үнэлгээ, танин мэдэхүйн үр дүн юм. Өөрөөр хэлбэл тэдний сэтгэл хөдлөл, мэдрэмжийн харилцан нөлөөллийг хамааруулж авч үздэг. Байгууллагын соёлд хамт олны сэтгэл зүйн нөлөө нь тухайн байгууллага тогтвортой ажиллаж, цаашид улам хөгжиж, өрсөлдөх чадвараа дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой.

Э.Мэйо хамт олон гэдэг бол өөрийн микро ертөнц бөгөөд дараах зүйлүүдийг анхаарах хэрэгтэй гэжээ. Үүнд:

1. Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд хамт олны хоорондын харилцаа хандлага, хамт олон болон удирдлагын хоорондын харилцаа чухал хүчин зүйл болно.
2. Хамт олон нь өөрсдийн гишүүдийн хэрэгцээг хангах, хөдөлмөрийн нормыг дээшлүүлэхээс тэднийг хамгаалах үүргийг гүйцэтгэнэ.

Хамт олны сэтгэл зүйг төлөвшүүлэхэд макро, микро орчны хүчин зүйлийг авч үзэх ёстой. Макро хүчин зүйлд нийгэм, эдийн засгийн хэлбэршил, хамт олны ажиллаж амьдрах зорилгоо хэрэгжүүлэх нөхцөлүүд мөн байгууллагын өөрийн удирдлага, захиргаа, нам холбоод, нийгмийн бусад байгууллагын үйл явцууд хамаарна. Микро орчинд хамт олны гишүүн бие хүний материаллаг ба оюун санааны хүчин зүйлүүд орно. Өөрөөр хэлбэл үйл ажиллагааны эд зүйлсийн хүрээ, техник технологийн бүрэн бүтэн байдал, ариун цэвэр эрүүл ахуйн, зохион байгуулах элементүүд зэрэг ажиллах нөхцөлүүд хамаарна.

Байгуулгын соёлд хамт олны сэтгэл зүйн нөлөөг тодорхойлохдоо ажиглалт, асуулга, ярилцлагын аргачлалыг ашиглалаа. Дээрх гурван аргуудын туслажтайгаар байгууллагын соёл, хамт олны сэтгэл зүйн нөлөөг судлах бегеед арга тус бүрийн давуу болон сул талуудыг харилцан хамааралтай нэг нь нөгөөгийн давуу, сул тал болохоор хослуулан хэрэглээ.

Ерөнхийд нь судалгааны үндсэн аргуудаас байгууллагын соёл, хамт олны сэтгэл зүйн нөлөөг санал асуулга, ярилцлагын аргыг хослуулан хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй гэж үзэж сонголоо. Ингэхдээ “Хеделмерийн хамт олны нийгэм сэтгэл зүйн уур амьсгалыг судлах түргэвчилсэн аргачлал”-ыг ашиглалаа. Энэхүү аргачлал нь хамт олны сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох бегеед сэтгэл зүйг (К), үйл ажиллагандаа (01), харилцаа хандлагадаа (02) хэр сэтгэл хангалуун байна гэсэн 3 үзүүлэлтийг агуулна. Сэтгэл ханамжийн түвшинг гаргаснаар түүгээр дамжуулан хамт олны нийгэм сэтгэл зүйг тодорхойлох боломжтой гэж үзлээ.

Судалгаанд Сүхбаатар дүүргийн цагдаагийн газрын 1, 2-р хэлтсийн цагдаагийн алба хаагч 100 хүн хамрагдсан бөгөөд 20 эмэгтэй, 80 эрэгтэй оролцсон. Насны байдлаар авч үзвэл нийт алба хаагчдын: 50 хувь нь хориос хорин таван насны залуучууд, 42 хувь нь 26-35 насныхан, 5 хувь нь 36-45 насныхан байна.

Судалгааны асуулгаас онцлоод үзвэл: Танай байгууллагын дэвшүүлэн ажиллаж буй зорилт танд ямар санагддаг вэ? гэсэн асуултанд 86 % дэмжиж ажилладаг, 14% нь зарим зүйлийг эргэж харах шаардлагатай санагддаг гэж хариулсан байна. Судалгаанаас харахад ихэнх нь дэмжиж ажилладаг гэсэн ч 14 хувьтай харилцан ярилцаж зорилтоо тайлбарлан таниулан ойлгуулах хэрэгтэй гэдэг нь харагдаж байна.

Байгууллагын бодлого шийдвэрийг хамтран ажиллагсад тань яаж хүлээн авдаг вэ? гэсэн асуултанд 77% нь дэмжиж хүлээн авдаг, 14% нь зарим зүйлд шүүмжлэлтэй ханддаг, 9% нь мэдэхгүй гэж хариулсан байна. Дээрхи хариултаас үзэхэд ихэнх хувь нь шийдвэрийг хүлээн авдаг гэсэн ч 9% нь мэдэхгүй гэж хариулж байгаа нь шинээр томилогдсон алба хаагчдын дунд мэдээлэл гүйцэт хүрдэггүй байгаа, удирдлагын арга, харилцааны хэлбэр дутмаг байгаа нь харагдаж байна.

Танай байгууллагын соёл аль түвшинд байдаг вэ? гэсэн асуулгад 19% нь өндөр, 74% нь дунд, 7 % нь муу гэсэн хариулт өгсөн. Эндээс харахад байгууллагын соёл сул байгаа нь харагдаж байгаа бөгөөд ялангуяа удирдлагын зүгээс байгууллагын соёлыг шинэ залуу алба хаагчдад танилцуулж төлөвшүүлэх, хамт олны сэтгэл зүй, онцлогийг илтгэсэн сургалт, хэлэлцүүлэг хийж, үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг тайлбарлах, хөдөлмөрийн үр дүнг үнэлэхдээ бусдад үлгэр дууриал болох сайн жишиг тогтоож харуулах гэх мэт.

Хамт олныхоо дотоод уур амьсгалд хэр сэтгэл ханамжтай байдаг талаар 63% нь маш их, 21% нь дунд зэрэг, 16% нь огт үгүй гэсэн хариулсан нь ажлын байрны дотоод орчин нөхцөлийг сайжруулах, хамт олны хоорондын холбоог сайжруулах зэрэг олон ажлыг хийх хэрэгтэй нь харагдаж байна.

Байгууллага хамт олны сэтгэл зүйг тодорхойлох түргэвчилсэн аргаар 1-10 гэсэн оноогоор дараах шинжээр тодорхойлсон.

Эерэг шинж	1	2	3	4	5	6	7	8	9	10	Сөрөг шинж
Нөхөрсөг	1	2	3	4	5	6	7	8	9	10	Нөхөрсөг бус
Ажилсаг	1	2	3	4	5	6	7	8	9	10	Ажилсаг бус
Санаачлагатай	1	2	3	4	5	6	7	8	9	10	Санаачлаггүй
Анхааралтай	1	2	3	4	5	6	7	8	9	10	Анхааралгүй
Эвсэг	1	2	3	4	5	6	7	8	9	10	Ганцаардмал
Эрч хүчтэй	1	2	3	4	5	6	7	8	9	10	Сул дорой
Ажиллахыг хүсдэг	1	2	3	4	5	6	7	8	9	10	Ажиллахыг хүсдэггүй
Хөгжилтэй	1	2	3	4	5	6	7	8	9	10	Уйтгартай
Хөдөлгөөнтэй	1	2	3	4	5	6	7	8	9	10	Хөшүүн
Идэвхтэй	1	2	3	4	5	6	7	8	9	10	Идэвхгүй

Боловсруулалт:

Хариулт оноо: 1-3 дээгүүр

4-6 дундуур

7-10 доогуур

Шинжүүд: Сэтгэл зүй- 1, 5, 8

Үйл ажиллагаа- 2, 3, 4, 7

Харилцаа хандлага- 6, 9, 10

Судалгааны үр дүнг тооцоолохдоо шинжүүдэд хамаарч байгааг үзүүлэлтийг нэмээд, дунджаар гаргахад доорх хувь үзүүлэлт гарч байна.

№	К-Сэтгэл зүй			01-Үйл ажиллагаа			02-Харилцаа хандлага		
	1	2	3	1	2	3	1	2	3
1	43.3	52.1	4.6	43.3	45.6	11	66.1	33.3	0.6

Хамт олны сэтгэл зүй 52.1-ээр дунд зэрэг, үйл ажиллагаандаа хандах сэтгэл ханамж 45.6 –р дунд зэрэг, харин харилцаа хандлага 66.1 –р сэтгэл хангалуун гэсэн үзүүлэлтэй байна.

Ажиглалтаар: удирдлагын хоорондын харилцааны суваг урт буюу шууд харилцаа байхгүй, босоо харилцаатай, ажилчид шийдвэр гаргах түвшний удирдлагатай шууд харилцдаггүй, ажилтнуудын санаа бодлыг судлах, зөвлөлдөх байдал дутмаг байлаа.

Судалгааны үзүүлэлтээс дүгнэвэл хамт олны сэтгэл зүй харилцан адилгүй байгаа нь хувь гишүүнийг хүртэж хүлээн зөвшөөрөх, нөгөө талаасаа гишүүнээс хамт олондоо хандах хандлагатай холбоотой ирээдүйд илүү сайжруулах шаардлагатай нь сэтгэл ханамж дундуур үзүүлэлтээс харагдаж байна.

Хамт олны сэтгэл зүйд гишүүдийн үзэл бодлын нэгдэл, харилцаа хандлагын хөгжил, нэгдэл нягтрал, хэрэгцээ сонирхол, сэтгэл зүйн тохироо зэрэг олон асуудлууд хөндөгдөх бөгөөд удирдлагын үйл ажиллагааны арга барил, гишүүдийн тоо тэдгээрийн хоорондын харилцаа, хөдөлмөрийн хуваарилалт, шатлан захирах ёс, зохион байгуулалт зэрэг үйл ажиллагаа нөлөөлдөг.

Хамт олны сэтгэл зүй нь хөдөлмөрийн бүтээмж төдийгүй боловсон хүчний тогтворгүй байдал, тогтвортой байдал, удирдагчийн хэв маягийн бүтээлч чанар, мөн сэтгэцийн эрүүл мэнд, бие хүний нийгмийн идэвхитэй байдал, урам зориг зэрэгт чухал хүчин зүйл болно. Судалгааны явц, үр дүнд дараах дүгнэлтийг хийлээ.

1. Байгууллагын соёл гэдэг нь тухайн байгууллагын бусдаас ялгарах онцлог имидж, байгууллагын доторх гишүүдийн янз бүрийн үзэл бодлыг нэгтгэж, хамт олны сэтгэл зүй, үзэл суртлаар удирдах юм.

Өөрөөр хэлбэл гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөнд байгууллагын соёлоо нийцүүлэн шинэчилж, стратегийн тодорхой алсын харааг томъёолж, юунд хүрэх гэж тэмүүлж байгаагаа хамт олондоо ойлгуулан, хүрэх гэж буй соёлын загвараа боловсруулж, хамт олноо сэдэлжүүлж албан ёсны найрсаг харилцааг бүрдүүлэн ажиллах нь чухал юм.

Удирдлага хамт олны харилцан ойлголцол, хамтын ажиллагаа, асуудлыг олон талаас нь шүүн тунгааж хэлэлцэх, хамтын шийдвэр гаргах соёл ямар ч байгууллагад онцгой үнэ цэнэтэй.

2. Хамт олны сэтгэл зүйг тодорхойлох нэг гол үзүүлэлт нь нэгдэл нягтрал юм. Өөрөөр хэлбэл “бид” гэсэн мэдрэмж ойлголттой байх явдал.

Хамтран ажиллах чадвар, гишүүн нэг бүр чөлөөтэй төлөвших нөхцөл бүрдэх эсэх нь удирдагч тухайн хамт олонтой хэрхэн ажиллаж, хамт олноо хэрхэн бүрдүүлж байгаагаас шалтгаалах юм. Энэ байдал нь хариуцлага, нэгдэл нягтрал, зохион байгуулалт, ил тод тодорхой байдал, мэдээллээр хангагдсан зэрэг нийгэм сэтгэл зүйн ухагдахуунаар тодорхойлогдох юм. Үүний тул хамт олны сэтгэл зүйг зөв төлөвшүүлэх нь чухал юм.

3. Байгууллагын соёл гэдэг нь тухайн байгууллагын бусдаас ялгарах онцлог имидж, байгууллагын доторх гишүүдийн янз бүрийн үзэл бодлыг нэгтгэж, хамт олны сэтгэл зүй, үзэл суртлаар удирдах юм.

Өөрөөр хэлбэл гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөнд байгууллагын соёлоо нийцүүлэн шинэчилж, стратегийн тодорхой алсын харааг томъёолж, юунд хүрэх гэж тэмүүлж байгаагаа хамт олондоо ойлгуулан, хүрэх гэж буй соёлын загвараа боловсруулж, хамт олноо сэдэлжүүлж албан ёсны найрсаг харилцааг бүрдүүлэн ажиллах нь чухал юм.

Удирдлага хамт олны харилцан ойлголцол, хамтын ажиллагаа, асуудлыг олон талаас нь шүүн тунгааж хэлэлцэх, хамтын шийдвэр гаргах соёл ямар ч байгууллагад онцгой үнэ цэнэтэй.

4. Хамт олны сэтгэл зүйг тодорхойлох нэг гол үзүүлэлт нь нэгдэл нягтрал юм. Өөрөөр хэлбэл “бид” гэсэн мэдрэмж ойлголттой байх явдал. Хамтран ажиллах чадвар, гишүүн нэг бүр чөлөөтэй төлөвших нөхцөл бүрдэх эсэх нь удирдагч тухайн хамт олонтой

хэрхэн ажиллаж, хамт олноо хэрхэн бүрдүүлж байгаагаас шалтгаалах юм. Энэ байдал нь хариуцлага, нэгдэл нягтрал, зохион байгуулалт, ил тод тодорхой байдал, мэдээллээр хангагдсан зэрэг нийгэм сэтгэл зүйн ухагдахуунаар тодорхойлогдох юм. Үүний тул хамт олны сэтгэл зүйг зөв төлөвшүүлэх нь чухал юм.

НОМЗҮЙ

1. Доржжав.Д. (2003) Сонгодог жишээн дээр удирдахуйд суралцах нь.
2. Цэрэн.Г, Гантуяа.Л. (2008) Байгууллагын зан төлөв.
3. Болормаа.Д. (1998) Байгууллагын зохион байгуулалт зан төлөв.
4. Бартанбаатар.Д. Байгууллагын соёл.
5. Eric.G. Flamholtz and Yvonne Randle (2011) Corporate Culture
6. Cameron, Kim S. Diagnosing and ... Kim S. Cameron, Robert E. Quinn.—Revised ed. Changing Organizational Culture (Addison-Wesley, 1999),
7. Эдгар Шейн. (2008)Организационная культура и лидерство
8. <https://www.researchgate.net>

**ХОЙШЛУУЛШГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ЦАГДААГИЙН
АЛБАН ХААГЧИД ТУЛГАЧ БУЙ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ,
ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ**
**PROBLEMS FACED BY POLICE OFFICERS IN THE PROCESS
OF WORK WITHOUT DELAY, AND METHODS OF SOLUTION**

Б.Батбаяр

*Дотоод хэргийн их сургуулийн ЭЗНУС-ийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш,
цагдаагийн ахлах дэслэгч*

В. Batbayar

*Teacher of the Public Law Department of the
Law School of the University of the Interior,
Senior Police Lieutenant*

Хураангуй. Хойшлуулшгүй ажиллагаа явуулж буй цагдаагийн албан хаагчид (ахлагч бүрэлдэхүүн)-д тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, хойшлуулшгүй ажиллагааны талаар ойлголт, эрх зүйн үндэслэл, үр дүнг хэрхэн сайжруулах, ойлголт өгөх талаар энэхүү өгүүлэлд авч үзсэн болно.

Abstract: In this article, the purpose of this article is to identify the problems faced by the police officers (supervisors) who are conducting urgent operations, to study how to improve the understanding, legal basis, and results of urgent operations, and to make conclusions and suggestions.

Түлхүүр үг: Хойшлуулшгүй ажиллагаа.

Key word: Immediate action.

ОРШИЛ. Цагдаагийн байгууллагад үүрэг гүйцэтгэж буй албан хаагч, тэр тусам ахлагч бүрэлдэхүүнийг ажлын байрны тодорхойлолтод заагдсан үүрэг гүйцэтгэх явцад хойшлуулшгүй ажиллагаа явуулах шаардлага бий болдог. Иймээс хойшлуулшгүй ажиллагаа хэрхэн явуулах талаар зарим албан хаагч мэдэхгүйн улмаас үйл ажиллагааны доголдол, иргэдэд өрөөсгөл сэтгэгдэл төрүүлэх, хэн нэгэн этгээдийн хуулиар олгогдсон эрх ашиг хөндөгдөх тохиолдол цөөнгүй гарч байдаг. Тиймээс хойшлуулшгүй ажиллагааны талаар ойлголт, эрх зүйн мэдлэг, уг ажиллагааг хэрэгжүүлэх явцад хэрхэн хүндрэл тулгарч байдаг талаар судалгаа авч, асуудлуудыг тодорхойлох, ахлагч бүрэлдэхүүний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, үүрэг гүйцэтгэх үеийн дутагдалтай талуудыг олж тогтооход чиглэгдсэн.

ҮНДСЭН ХЭСЭГ

Цагдаагийн байгууллагын үндсэн үүрэг болсон гэмт хэрэг, зөрчил илрүүлэх, таслан, зогсоох, урьдчилан сэргийлэх, гэм буруутай этгээдийг баривчлах, цагдаагийн байгууллагад хүргэх, хэргийн газрыг хамгаалах зэрэг яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээнд хойшлуулшгүй ажиллагаа чухал ач холбогдолтой.

Гэмт хэргийн тухай мэдээллийг ихэнх тохиолдолд цагдаагийн байгууллагын хариуцлагатай жижүүр, эсхүл дарга хүлээн авдаг. Цагдаагийн бусад албаны ажилтнуудаар дамжиж ирсэн мэдээлэл ч байдаг. Цагдаагийн байгууллагад авагдсан мэдээлэл бүр иж

бүрэн байдаггүй. Тиймээс авагдсан мэдээллийн мөрөөр шууд хойшлуулшгүй арга хэмжээ авч хэрэгжүүлэх бололцоогүйгээс зарим мэдээллийг асууж тодруулах шаардлага гардаг. Энэ шаардлагыг хангах үүднээс юуны өмнө мэдээллийн эх сурвалжийг гаргаж байгаа хүнийхээ овог, нэр, хаяг утасны дугаарыг тэмдэглэн авах зайлшгүй шаардлагатай байдаг. Хойшлуулшгүй гэдэг нь гэмт хэргийн тухай анхны мэдээ аваад цаг алдалгүй маш түргэн шуурхай, зайлшгүй авч хэрэгжүүлэх гэсэн утга санаа илэрхийлдэг шигээ яарч сандарч, ажил хэргийн мэдлэггүй, болгоомжгүй сонор сэрэмжгүй санааныхаа дур зоргоороо ажиллах тохиолдол цөөнгүй байдаг. Хэрэв ингэж ажиллан төрийн хууль ёс зөрчвөл хариуцлагаас мултрах, хөнгөлөх шалтгаан болохгүй гэдгийг анхаарах нь зүйтэй.

Иймд дуудлага мэдээлэлд очих, албан үүргээ гүйцэтгэх үедээ албаны бэлэн байдлаа хангах, энгэрийн камераа асаах, нэг бүрийн тусгай хэрэгслээ бэлэн байдалд байлгах, тухайн дуудлага мэдээллийн талаар урьдчилсан байдлаар дүгнэлт хийсэн байх, хамтрагчтайгаа уялдаа холбоотой ажиллах, гэмт хэргийг таслан зогсоох, цагдаагийн албан хаагч нь хойшлуулшгүй ажиллагааг хуулийн хүрээнд өөрийн итгэл үнэмшилд тулгуурлан хийж гүйцэтгэх мэдлэг, чадвартай, дадалтай байх зүй ёсны шаардлагатай юм. Хойшлуулшгүй ажиллагааны төрөл, ойлголтыг авч үзвэл, “Хойшлуулшгүй” хэмээх үгийг ХХ-р зууны Монгол хэл бичгийн ухааны доктор Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-д⁸⁵ тодорхойлохдоо “Хойшлуулж огт болохгүй, хойш тавьж огт болохгүй, эрхгүй одоо шаардагдаж байгаа, хойшлуулшгүй асуудал” хэмээн тодорхойлсон байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд⁸⁶ “Гэмт хэрэг, зөрчил үйлдэж байгаа болон үйлдсэн тухай үндэслэлтэй сэжиг байгаа тохиолдолд гэмт хэрэг, зөрчлийн шинж тэмдгийг тогтоохын тулд зөвшөөрөл шаардахгүйгээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зааснаар зөвшөөрсөн ажиллагааг ойлгоно” гэж тодорхойлжээ. Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд⁸⁷ хойшлуулшгүй ажиллагааг тодорхойлж зааж өгөөгүй боловч “Хойшлуулшгүй тохиолдол” гэсэн нэр томъёог “хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах, сэжигтэн, яллагдагч оргон зайлах, хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгааг” ойлгохоор тайлбарласан байна.

Хойшлуулшгүй ажиллагааг хуульд тусгасан байдлыг авч үзвэл, хойшлуулшгүй тохиолдолд гэмт хэрэг зөрчлийг шалгах ажиллагааг: Гэмт хэрэг, зөрчлийг шалгах хойшлуулшгүй ажиллагааны эрх зүйн үндэслэлийг Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн⁸⁸ дөрөвдүгээр бүлэгт “Зөрчил шалгах тодорхой ажиллагаа явуулах журам”, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн⁸⁹ 30.7 дахь хэсэгт “Гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг шалгах”, Цагдаагийн албаны тухай хуулийн⁹⁰ дөрөвдүгээр бүлэгт “Цагдаагийн байгууллага, алба хаагчийн тодорхой ажиллагаа явуулах журам” 22-46-р зүйл, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын⁹¹ код 213-224-т тус тус зааж өгсөн байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар эрх бүхий албан тушаалтан болон тэдгээрийн удирдах ажилтны бүрэн эрх, гүйцэтгэх үүргийг тодорхой хуульчилж өгсөн байна. Тухайлбал Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 3 дахь

⁸⁵ Цэвэл, Я. Монгол хэлний товч тайлбар толь. -, 1966.

⁸⁶ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. -УБ., 2018.

⁸⁷ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. №23.

⁸⁸ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. №24.

⁸⁹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. №23.

⁹⁰ Цагдаагийн албаны тухай хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. №8.

⁹¹ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. -УБ., 2018.


хэсэгт “Эрх бүхий албан тушаалтан энэ хуульд⁹² прокурорын зөвшөөрлөөр явуулахаар зааснаас бусад ажиллагааг явуулах шийдвэрийг бие даан гаргана” гэж заасан явдал юм.

Цагдаагийн албан хаагч үүрэг гүйцэтгэх явцад хойшлуулшгүй ажиллагаа явуулах нөхцөл байдал зайлшгүй таардаг. Энэ үед хүндрэл бэршээл тохиолддог. Тухайлбал, эрх зүйн үндэслэлээ мэдэхгүй байх, хэргийн газарт үзлэг хийх (хэрхэн хийх талаар мэдлэг хомс), эд мөрийн баримт чанараа алдаж болзошгүй нөхцөлд хэрхэн ажиллах, түүнд үзлэг хийх, хохирогчийн биеийн байдал хүнд байгаа тохиолдолд түүнээс хэрхэн байцаалт авах, гэмт этгээдийг эрэн сурвалжлах даалгавар өгөх гэх ойлголтыг ойлгохгүй байх, сум, дүүрэг, хороонд үйлдэгдэж буй гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, хойшлуулшгүй ажиллагаа явуулах, зөрчлийн мэдээллийн санд ажиллах ур чадвар тааруу, тусгай хэрэгсэл дутмаг, ул мөрийг үнэлэх (хэргийн газраас ул мөрийг илрүүлээд гэрэл зураг, дүрс бичлэгээр, ийм техник хэрэгсэл байхгүй тохиолдолд гар зураг, зураглалаар бэхжүүлэх) чадвар дутмаг, таамаглал дэвшүүлэх, таамаглал шалгах, харилцааны ёс зүйн соёлд суралцах гэх мэт хүндрэл тулгарч байдаг. Энэхүү тулгамдаж буй асуудал нь албан хаагчдын чадвахжуулах, энэ чиглэлийн ажлын байран дээрх сургалт дутмаг байгаатай холбоотой гэж үзэж байна.

“Хойшлуулшгүй ажиллагаа” сэдвийн хүрээнд нэгэн аймгийн цагдаагийн газрын эргүүлийн цагдаа, хэсгийн цагдаа, цагдаа жолооч нарыг хамруулан нийт 30 алба хаагчаас 9 төрлийн төрлийн асуумж боловсруулан судалгаа авч анализ хийж санал дүгнэлтээ судалгаанд тулгуурлан боловсруулсан.

Судалгаанд хамрагдсан алба хаагчдын судалгаанд анализ хийж график тоон үзүүлэлт тус бүрээр нь харуулсан байдал

График 1. Хойшлуулшгүй ажиллагаа явуулах эрх зүйн үндэслэлийн талаарх мэдлэг



Дээрх графикаас харахад ахлагч бүрэлдэхүүн хойшлуулшгүй ажиллагаа явуулах эрх зүйн үндэслэл, ямар хууль дүрэм журмыг баримтлаж ажилладаг талаар цахим орчинд 30 албан хаагчаас судалгаа авч үзэхэд цагдаагийн албаны тухай хууль гэж хариулсан нь 10 албан хаагч буюу 33.3 хувь, хариулаагүй буюу мэдэхгүй гэж судалгаанд хамрагдсан нь 20 албан хаагч буюу 66.6 хувь байгаа нь анхаарал татаж байна.


⁹² Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. №24.

График 2. Хойшлуулшгүй ажиллагаа явуулах ойлголтын талаар



Нийт санал асуулгад оролцсон албан хаагч нараас хойшлуулшгүй ажиллагааны талаар сайн ойлголттой байгаа 6 албан хаагч буюу 20 хувь, дутмаг ойлголттой байгаа нь 20 албан хаагч буюу 66.6 хувь, ойлголт тааруу мэдэхгүй 4 албан хаагч ба 13.3 хувьтай байгаа нь сургалт явуулж байх нэн шаардлагатай гэж харагдаж байна.

График 3. Хойшлуулшгүй ажиллагаа явуулах явцад тулгамдаж буй асуудалын талаар



Өдөр тутамдаа үүрэг гүйцэтгэх явцад хойшлуулшгүй ажиллагаа явуулах шаардлага гардаг эсэхэд 19 албан хаагчид буюу 63.6 хувь, хойшлуулшгүй ажиллагааны явцад галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэдэг 25 албан хаагч буюу 83.3 хувь, хойшлуулшгүй ажиллагаа явуулах явцад тусгай хэрэгсэл хэвийн ажиллагаатай эсэхэд 26

албан хаагч буюу 86.6 хувь нь тийм гэж хариулсан, уг ажиллагааны явцад гэм хор учруулсан тохиолдолд албаны шалгалт хийгдсэн байдалд 17 хүнд албаны шалгалт хийсэн гэж хариулсан нь 17 албан хаагч буюу 56.6 хувь, гэмтэж бэрдсэн байдлыг авч үзэхэд 18 албан хаагч буюу 60 хувь, анхаарал татсан судалгаан нь хойшлуулшгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулахад дэмжэх эсэхэд 27 албан хаагч буюу 93 хувь, ажил үүргээ гүйцэтгэх (дуудлага мэдээлэлд очих) үед хойшлуулшгүй ажиллагаа явуулж байсан эсэхэд 30 албан хаагчаас 25 хүн буюу 83.3 хувь явуулж байсан гэж судалгаанд тус тус хамрагдсан байна. Дээрх графикт дүгнэлт хийхэд өдөр тутмын үйл ажиллагаандаа ахлагч бүрэлдэхүүн хойшлуулшгүй ажиллагааг байнга хэрэгжүүлдэг тул мэдэж, ойлгож хэрэгжүүлэх чадвартай байх нэн шаардлагатай гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ

Дээрх судалгаанаас дүгнэн үзэхэд цагдаагийн алба хаагч тэр дундаа ахлагч бүрэлдэхүүнд ажил үүргээ гүйцэтгэх явцад хойшлуулшгүй ажиллагааны талаарх ойлголт дутмаг, шаардлагатай техник хэрэгсэл дутуу мөн хуулийн нэр томьёо тодорхойгүй байгаагаас шалтгаалж алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учрах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагаанд эрсдэл учирч байна.

Мөн цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлт дутмаг, ачаалал ихтэй улмаас зарим цагдаагийн ахлагч бүрэлдэхүүн нь (онлайн, танхим)-ийн сургалтад хараахан хамрагдаагүй байдаг тул хойшлуулшгүй ажиллагааны талаар сургалт, мэдлэг дутмаг, энэ талаар давтан сургалтыг танхимаар орж практикт нийцүүлэн мэдлэг олгох шаардлагатай байна.

Цагдаагийн байгууллагад ашиглагдаж байгаа нэг бүрийн тусгай хэрэгслийг цагдаагийн алба хаагчдад хүртээмжтэй биш, ажил үүргээ гүйцэтгэхэд хэрэгцээ шаардлага хангахгүй байгаад үнэлэлт дүгнэлт хийж, шаардлага хангахуйц нэг бүрийн тусгай хэрэгслээр цагдаагийн алба хаагчдыг бүрэн хангах зүйтэй гэж үзэж байна.

САНАЛ

1. Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд “Зөрчил шалгах тодорхой ажиллагаа явуулах журам”, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “Гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг шалгах”, Цагдаагийн албаны тухай хуульд “Цагдаагийн байгууллага, алба хаагчийн тодорхой ажиллагаа явуулах журам”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд “Хойшлуулшгүй ажиллагаа” гэж 4 өөр нэр томьёоллоор зааж өгсөн байна. Иймд дээрх 4 төрлийн томьёоллын талаар ахлагч бүрэлдэхүүнд тодорхой мэдээлэл өгөх.

2. Үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай техник хэрэгсэл дутмаг, хүрэлцээ муутайгаас шалтгаалан алба хаагчид эрсдэл учирч болох магадлал нэмэгдэх, эрсдэлийг таслан зогсооход, мөн алба хаагч өөрийгөө хамгаалахад хүндрэл учирч байна. Иймд алба хаагчдын үүрэг гүйцэтгэх нөхцөл боломжийг хангах, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах. Жишээ нь: Энгэрийн камер ажиллахгүй байх/ цэнэг муу барьдаг гэх мэт.

3. “Хойшлуулшгүй ажиллагаа”-ны талаар сургалт, мэдээ мэдээлэл бага, энэ талаар тусгайлсан сургалт байхгүй байгаа нь дээрх судалгаанаас харагдаж байна. Иймд ахлагч бүрэлдэхүүнд сургалт явуулахдаа “Хойшлуулшгүй ажиллагаа”-аар тусгайлсан сургалт явуулах, мэдээ мэдээллээр хангах тал дээр дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай. (Хойшлуулшгүй ажиллагаа)-ны талаар ахлагч бүрэлдэхүүнд аймаг бүрд танхимаар сургалтыг тогтмол зохион байгуулах.

4. Цагдаагийн алба хаагч нь нэгэн хэвийн (тухайлбал гэр бүлийн хүчирхийлэл) дуудлагад олон удаа очиж ажлын хэвшмэл арга барилд суралцсан байдаг. Үүнийг олон улсад “Ажлын байны ширтэлт” гэж нэрлэдэг. Иймд Цагдаагийн байгууллага мэргэжлийн сэтгэл зүйчтэй хамтран ажлын байрны ширтэлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2 жил тутамд 1 удаа давтан сургалтыг зохион байгуулж байх

АШИГЛАСАН МАТЕРИАЛ.

Монгол Улсын хууль тогтоомж:

1. Цагдаагийн албаны тухай хууль. (2017)
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. (2017)
3. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. (2017)

Ном, сурах бичиг, гарын авлага

4. Цэвэл, Я. Монгол хэлний товч тайлбар толь. -УБ., 1966.

Дүрэм, журам

5. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. -УБ., 2018.
6. www.police.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНД БАРИМТЛАХ
БОДЛОГО БА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ
DOCUMENTATION IN FOREIGN RELATIONS OF MONGOLIA
POLICY AND NATIONAL SECURITY

Цагдаагийн хурандаа А.Баасанцэрэн
Дотоод хэргийн их сургууль
Police colonel A. Baasantseren
University of Internal Affairs
baaskaa0522@Gmail.com

Хураангуй. ОХУ, БНХАУ-ын гадаад бодлого Монгол Улсад сүүлийн 20 гаруй жил хэрхэн нөлөөлж байгаа, Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын өнөөгийн байдал зэргийг энэхүү өгүүлэлд тусгасан болно.

Abstract: How the foreign policies of Russia and China have affected Mongolia in the past 20 years, the current status of Mongolia's foreign policy concepts, and national security concepts are reflected in this article.

Түлхүүр үг: Монгол улсын гадаад бодлого, Үндэсний аюулгүй байдал, ОХУ, БНХАУ-ын гадаад бодлого

Keywords: foreign policy of Mongolia, national security, foreign policy of Russia and China

1. МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ.

Аливаа улсын гадаад бодлого зайлшгүй тухайн ороны үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой ийм ч учираас нэн тэргүүнд Гадаад бодлогоор улс үндэстэний аюулгүй байдал хангагдаж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил нь гадаад оронуудтай олон улсын эрх зүйн хүрээнд улс төр дипломатын аргаар үндэсний аюулгүй байдлаа баталгаажуулж байна.

Нөгөөтэйгүүр, улс орнуудын хөгжлийн хурд, түвшин улам бүр ялгарч, буурай, эмзэг эдийн засагтай улсуудад ажилгүйдэл, ядуурал буурахгүй байна. Зарим улс, бүс нутагт цөмийн зэвсэгтэй болох оролдлого үргэлжилж, хурцадмал байдал намжихгүй байна. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол хийгээд олон улсын терроризм, хүний болон хар тамхины наймаа, гоц халдварт өвчний тархалт зэрэг аюул, сорилт нэмэгдэх болов.

Монгол улс ардчилал шинэчлэл зам шилжин орж 1994 оны 6-р сарын 30-нд батлагдаж байсан бол, МУ-ын Их хурлын 2011 онд шинэчлэн батлагдаж эдүүгээ 30-аад жилийг үзэж байна “Монгол Улс гадаад улс төрийн бодлогоо хэрэгжүүлэхдээ баримтлах чиглэлийн нэгдүгээрт “ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны эн тэргүүний зорилт мөн.” гээд “Монгол Улсын гадаад бодлогын хоёр

дахь чиглэл бол өрнө, дорнын өндөр хөгжилтэй, хүчирхэг гүрнүүдтэй найрсаг харилцаа хөгжүүлэх явдал мөн. Энэ зорилтын хүрээнд АНУ-тай улс төрийн утгаар чухал түншийн хэмжээнд харилцана. Японтой Ази дахь гол түнш байхаар харилцана, Европт Европын холбоо бүхэлдээ, түүний дотор ХБНГУ-тай харилцахад түлхүү анхаарна, Монгол Улс бие даасан гадаад бодлого явуулах үзэл баримтлалын үндэс нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд дурдсанчлан “Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын үзэл бодлын үндэс нь эх оронч үндэсний үзэл байна” гэж тодорхойлсон заалт юм⁹³. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд Эвсэлд үл нэгдэх, Хоёр хөрштэй эн тэнцүү харилцах, Гуравдахь хөршийн харилцаа чухал зарчимуудыг тусгасан байна.

1. Эвсэлд үл нэгдэх зарчим

Эвсэлд үл нэгдэх гэдэг ойлголтыг бид одоо бол нэлээн бүдгэрсэн гэж хэлж болохоор “эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн”-тэй заримдаа хутгаж ухаарах нь бий. Гэтэл уг ойлголт маань тэр хөдөлгөөнөөс арай өөр. Тодорхойхон хэлбэл “цэрэг улс төрийн эвсэлд нэгдэхгүй” гэсэн санаа юм. Сүүлийн үед Шанхай хамтын ажиллагааны байгууллагад элсэх тухай нэлээлд яригдаж байгаа өнөө үед элсэх нь ашигтай ашиггүй гэх мэтээр нэлээд яригдаж байна.

2. Хоёр хөрштөйгөө эн тэнцүү харилцах зарчим

Хоёр хөрштөйгөө эн тэнцүү, эрх тэгш харилцана гэсэн ойлголт одоо бидэнд байгаа. Энэ бол өмнөх үе буюу 1960-аад оноос хойш, 80-аад оны шувтарга хүртэлх үеийн үйл явдал, сургамжтай холбоотой. Бид тэр үед өмнөд хөрштөйгөө лав л 25 жил муудалцаж, толхилцож, үзэл суртлаар бие биеэ муулж, үгийн муухайгаар занаж зүхэж явсан. Нөгөө талд нь хойд ах нарынхаа өвөрт улам бүр л шигдээд байсан, Хоёр хөрштөйгөө харилцаагаа жигнээд, цэгнээд үзэхэд чухамдаа эн тэнцүү байна уу гэхээр бас л янз бүрийн юм яримаар. Улс төрийн хувьд яахав юм шиг. Нөгөө эдийн засгийн харилцаа гэдгээ, тэх тусмаа хөрөнгө оруулалт талаас нь ярих юм бол эн тэнцэх битгий хэл огт өөр, ерөөсөө хоёр шал ондоо тоо, үзүүлэлт харагдахаар шахуу тийм байдалтай байна. Одоогоор хоёр хөршийн худалдаа экспортын тэнцэл БНХАУ-тай 90 хувь, ОХУ-тай 10 хүрэхгүй хувьтай байна.

Монгол улс нь ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзах;⁹⁴ гэж заасан байна.

3. “Гуравдахь хөрш”-ийн зарчим

Онцолж ярих ёстой нэг зүйл бол гуравдахь хөршийн асуудал. Ер нь 1990-ээд оны эхнээс 2000 он гартал шилжилтийн гэгдэх 10-12 жилийн хоорондох үнэнхүү хүнд нөхцөл байдлыг даван туулах үед “гуравдахь хөрш” гэж бөөнд нь нэрлэсэн тэр улсууд, тэр улсуудын идэвхитэй оролцож байдаг олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагууд бидний хувьд гачаал зовлонгоос аврах хүчин зүйл болсон. Тэр үүднээсээ 3 юмыг байтугай, 2 юмыг ч зэрэг, давхарлуулаад биччихэж болдоггүйн адил нэгдүгээрт хоёр хөрш, дараачийн дугаарт гуравдахь хөрш гэж бичихээс өөр аргагүй байсан. Гуравдахь хөршийн бодлого маань шилжилтийн үеийг туулах гадаад бодлогын хувьд хоёр хөрштөйгөө

⁹³ Академич П.Очирбат /Монгол Улсын анхны Ерөнхийлөгч, Монгол Германы Чуулганы тэргүүн/ Монгол улсад гадаад бодлогын үзэл баримтлалын 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд хэлсэн үгнээс.

⁹⁴ Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалын 14.1-д.

харилцах харилцаатай дүйх хэмжээний чиг баримтлал байсан юм⁹⁵. 1990 оноос хойш манай улстай нагт хамтран ажиллаж байгаа оронуудаас Япон хамгийн их зээл тусламж үзүүлсэн байх жишээтэй үүний дараа БНСУ, АНУ, ХБНГУ, Турк, Энэтхэг, гэх мэт оронуудтай нягт хамтын ажиллагаа хөгжүүлж ирсэн байна.

2. МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ.

Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд МУ-ын Их хурлын 2010 оны 07 сарын 15 өдрийн 48-р тогтоолоор шинэчлэн батлагдаж Үндэсний аюулгүй байдлыг 5 бүлэг 29 зүйлд хуваан ангилсан байдаг байна. Гадаадын аюулын хүчин зүйл Монгол улсын оршин тогтнохын аюулгүй байдлаар хязгаарлахгүй, эдийн засаг, нийгэм-төрийн байгуулал, иргэдийн эрх, эрх чөлөө, экологи, мэдээллийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдалд ч нөлөөлж байдаг. Учир нь дээр өгүүлсэн чиглэлийн аюулгүй байдлыг хангахад мөн л гадаадын хүчин зүйл, хамтын ажиллагаа чухал юм. Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах нь гадаад бодлогын тэргүүлэх зорилт мөн⁹⁶.

Тиймээс Гадаад бодлогын үзэл баримтлалд тусгагдаагүй зарим санааг ҮАБҮБ-д тусгасан байна. Тухайлбал, далайд гарцгүй орны тухай, хоёрдмол харъяаллын тухай заалт ГБҮБ-д тусгагдаагүй боловч ҮАБҮБ-д тусгагдсан байдаг. Хоёр хөрштэй харилцах бодлогын хувьд гэвэл ГБҮБ-д тэрхүү харилцааг гадаад бодлогын эн тэргүүний зорилт, тэр хоёр оронтой тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хамтын ажиллагаа хөгжүүлнэ гэж заасан боловч “тэнцвэртэй харилцах” гэж чухам юуг хэлэхийг тодруулаагүй байдаг. Тэгвэл ҮАБҮБ-д тэнцвэртэй харилцана гэж адил зай барих, бүх асуудлаар адил байр суурьтай байхыг бус, харин хоёулантай нь “итгэлцлийг бэхжүүлэх, сайн хөршийн найрсаг харилцааг хөгжүүлэхийг хэлнэ. Эдгээр орнуудтай харилцахдаа хөрш орнуудаас Монгол Улсын үндэсний ашиг сонирхол, нэн ялангуяа үндэсний язгуур ашиг сонирхолын талаар баримталж буй бодлогыг зохих ёсоор харгалзаж байна. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолыг хөндөөгүй хөрш хоёр орны маргаанд эс оролцож, төвийг сахих бодлого баримтална” гэж тодорхой заасан байдаг⁹⁷.

Гуравдагч хөршийн бодлогыг амьдруулахын тулд гуравдагч орнуудтай эдийн засгаар харилцах, тэдний хөрөнгө оруулалтыг бий болгох нь нэн чухал. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нэг орноос оруулах гадаадын хөрөнгө оруулалт нийт гадаадын хөрөнгө оруулалтын гучин хувиас хэтрэхгүй байх бодлого баримтална гэж заасан байдаг. Энэ заалтыг амьдрал дээр хэрэгжүүлэх амар биш. Гэвч үүнийг хэрэгжүүлэх улс төрийн хүчин чармайлт, хүсэл эрмэлзэлтэй байх, тооцоо судалгаатай ажиллах чухал байна. Өнгөн дээрээ эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой мэт боловч гуравдагч хөршийн бодлогыг баталгаажуулах нэг чухал заалт гэж боддог.

ЗХУ, БНХАУ-ын хооронд олон жил үргэлжилсэн газар нутгийн маргааныг нэг тийш шийдвэрлэх тохиролцоо 1980-аад оны эцсээр эхэлсэн билээ. Асуудлыг шийдэж амжаагүй байтал ЗХУ задран маргаантай улс орнууд хүрээгээ тэллээ. Үүнд юун түрүүн Киргизстан, Казахстан, Тажикстаныг нэрлэх хэрэгтэй. Чухам ийм үндсэн дээр хамтарч асуудлаа шийдэхийн тулд 1996 онд “Шанхайн тав” хэмээх байгууллага буй болсон юм. Тэр үед уг байгууллагын гол зорилгыг цэргийн салбар дахь харилцан итгэлцэл, хил орчим

⁹⁵ Ц.Гомбосүрэн /ГЯЯ-ны сайд асан, Соёлын гавьяат зүтгэлтэн, Монгол улсад гадаад бодлогын үзэл баримтлалын 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд хэлсэн үгнээс.

⁹⁶ Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал 2011 оны Монгол улсын их хурлын 10-р тогтоол

⁹⁷ Ж.Энхсайхан /Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд/

дахь цэрэг зэвсгийн тоо хэмжээг харилцан бууруулах гэж томъёолж байв. 2001 онд Шанхайн тавыг зургаан орны гишүүнчлэлтэйгээр Шанхайн хамтын нийгэмлэг (ШХН) болгон өргөжүүлсэн юм. 2004 оноос уг байгууллагыг өөрийн төсөв, ажиллагааны механизмтай болгон албажуулжээ. Уг байгууллагын зорилго нь : хамтын итгэлцэл, найрамдал, сайн хөршийн холбоо, энх тайван аюулгүй байдал, бүс нутгийн тогтвортой байдлын төлөөх хамтын ажиллагаа, терроризм, салан тусгаарлал, хэт давралын эсрэг хамтран тэмцэх, улс төр худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа гэх мэтээр тодорхойлжээ. ШХАБ 2004 оноос ажиглагчийн статус буй болгосонд хамгийн түрүүн Монгол улс нэгдэв. Гишүүнээр элсүүлэх урилгыг юун түрүүн Монгол, Туркменистан хоёр оронд тавьсан боловч түркменчүүд татгалзсан ба одоо болтол ямар ч холбоо тогтоогоогүй явсаар. Харин Монгол улс хоёр хөршийн байнгын урилга заллага, хатуу нэхлийн үр дүнд ажиглагчаар орсон юм. Дараа нь энэ нийгэмлэгт Энэтхэг, Афганистан, Пакистан, Иран улсууд ажиглагчийн статустай болсон ба Турк, Шри Ланка, Беларусь улсууд ажиглагчаар нэгдэх хүсэлтээ гаргачихаад байна.

ШХАБ-ийн анхаарлын төвд байдаг нэг хэрэг бол бүс нутгийн тогтвортой байдалд саад болж болохуйц газар нутгийн маргаантай асуудал юм. Эдгээр гишүүн орнуудын нийтлэг хилийн шугамын алинд нь ч талууд бүрнээ хүлээн зөвшөөрсөн димаркаци байхгүй. Үүнээс болж өнөөдөртөө маргаан шүүмжлэл өрнөөгүй боловч хэдийд ч хэрүүл шуугиан үүсэх магадлалтай. Иймд ШХАБ нь цэрэг улс төрийн байгууллага болохын хувьд Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал эвсэлд үл нэгдэх гэсэн зарчимаар энэ байгууллагад нэгдэн орох шаардлагагүй байна Монгол Улс хоёр хөрштэйгээ газар нутгын хувьд ямар нэгэн маргаан байхгүй байгаа нь одоохондоо Терроризм, Салан тусгаарлал, Хэт давралтын байхгүй боловч Үндэстний цөөнх гэгдэх Монгол улсын Баян-Өлгий аймгийн Казах иргэд Монгол хэл сурахыг хүсэхгүй, Бүх хэвлэл мэдээлэлийн хэрэгсэл нь ихэнхи нь Казахстан улсын телевизийн сувагууд нэвтэрсэн байгаа нь салан тугаарлах, Казахстан улстай нэгдэх бодлого явуулж болзошгүй юм. Одоогийн байдлаар Монгол улсын төрийн бодлого нэгдмэл залгамж чанарыг хадгалж байхгүй бол Төрийн эрх барьж байгаа нам солигдох бүрд бодлого өөрчилөгдөж байгаа нөхцөлд ОХУ нь 2014 онд Кримиыг өөртэй нэгтгэсэн шиг Баян-Өлгий аймгийн Казах иргэдийн дунд Казахстан улсын нөлөөгөөр санал асуулга явуулах хэлбэрээр нэгтгэж авах санаархал байна гэсэн үг, Монгол улсын үндсэн хуулийн 2019 оны 11-р сарын 14-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр *Хорин дөрөвдүгээр зүйл.16-д /ард нийтийн санал асуулга явуулах. Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх аливаа оролдлогыг үл зөвшөөрөх бөгөөд мөнхүү зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахыг хориглоно;*⁹⁸ заалт нь чухал ач холбогдолтой байна.

3. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ГАДААД БОДЛОГО БА МОНГОЛ УЛС

ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин Ерөнхийлөгчийн улс оронд тулгамдаж буй асуудлууд болон ач холбогдол бүхий салбаруудын хөгжлийн чиг хандлага, тэдгээрт баримтлах бодлогын талаар “Орос орон туулах ёстой сорилтууддаа бэлтгэж байна”, “Орос орон: Үндэстний асуудал”, “Хүчирхэг байх нь Орос орны үндэсний аюулгүй байдлын баталгаа мөн”, “Шударга явдлыг тогтоох нь оросын нийгмийн бодлого мөн”, “Ардчилал ба төрийн чанар”, “Бидэнд шинэ эдийн засаг шаардлагатай байна” болон “Орос орон болон өөрчлөгдөж буй дэлхий” зэрэг 7 нийтлэл бичсэн нь түүний баримтлах бодлогын “зураг төсөл” хэмээн ойлгож болох юм. ОХУ-ын гадаад бодлогын талаар баримтлах

⁹⁸ Монгол улсын үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт 2019 он.

бодлого юуны түрүүнд хөрш зэргэлдээ улсууд, нэн ялангуяа тус улсаас тодорхой хэмжээнд хараат Монгол улсын хувьд ихээхэн чухал байна. В.Путины хамгийн сүүлийн буюу 7 дахь өгүүлэл болох “Орос орон болон өөрчлөгдөж буй дэлхий” өгүүлэл нийтлэгдсэн нь тус улсын судлаачдаас гадна бусад улсуудын анхаарлыг ихэд татав⁹⁹. Өгүүлэлд В.Путин улс орны халдашгүй дархан байдлыг дэмжихээ илэрхийлж улс орны дотоод хэрэгт бусад улсууд оролцох нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн ноцтой үйлдэл хэмээн зарлажээ. Тэрээр НҮБ-ын ямар нэгэн дэмжлэггүйгээр аливаа улсын дотоод хэрэгт оролцох эсвэл улс төрийн нөлөөлөл үзүүлэх нь байж боломгүй зүйл хэмээн үзэж буйгаа дурдаж Арабын орнуудад өрнөж буй бослого хөдөлгөөний талаар Өрнөдийн улсуудын баримталж буй бодлогод ихээхэн шүүмжлэлтэй ханджээ. Түүнчлэн НАТО-гийн Ливи улсад явуулсан цэргийн ажиллагааг хүмүүнлэгийн бус харин “илэрхий хуурмаг үйл ажиллагаа” хэмээн томъёолов. Энэхүү байр суурийнхаа илэрхийлэл болгож тус улс Сирийн асуудлаар НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн тогтоолын төсөлд хориг тавиад байгаа билээ. Цаашилбал, Өрнөдийн орнууд, түүний дотор АНУ нь ОХУ-ын баримталж буй НАТО-гийн тэлэлтийн эсрэг байр суурийг үл хэрэгсэж Европ тивд пуужингийн довтолгооноос хамгаалах систем байршуулж буйг ихэд шүүмжлэв. Энэхүү өгүүллийнхээ төгсгөлд АНУ “дийлдэшгүй” болохын тулд бусад улсыг эмзэг болгож буйд сэтгэл зовниж буйгаа илэрхийлжээ. Уг илтгэлээс ОХУ-ын гадаад бодлогын ойрын зорилтуудыг дараах байдлаар тодорхойлж болохоор байна. Үүнд:

- Арабын улсуудад гарсан бослого хөдөлгөөний улмаас зогсонги байдалд ороод байсан Ойрхи Дорнодын бүс нутгийн улсууд болон ОХУ-ын эдийн засгийн хамтын ажиллагааг сэргээж Израйль-Палестины энхийг яриа хэлэлцээг дэмжих;
- 2012 оны 09 дүгээр сард Владивосток хотноо зохион байгуулагдах Ази-Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны дээд хэмжээний уулзалтыг Сибирийн бүс нутгийг хөгжүүлэх болон БНХАУ-тай харилцаагаа ойртуулахад ашиглах;
- Ази Номхон-Далайн бүс нутгийн улсуудтай харилцаагаа өргөжүүлэх, түүний дотор БНХАУ-тай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх;
- Зэвсэгт хүчний бүх анги нэгтгэлийг сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий зэвсэглэлээр хангах. Энэхүү бодлогын хүрээнд ойрын 10 жилийн хугацаанд зэвсэглэлд шинээр 400 тив алгасагч пуужин, 50 байлдааны хөлөг онгоц, 2300 танк, 100 цэргийн зориулалттай сансрын төхөөрөмж, болон 10 Искандер загварын пуужингийн цогцолборын иж бүрдэл нэмж авах аж;
- Тэнгисийн цэргийн хээрийн сургуулилт болон харуул хамгаалалтаар дамжуулан өөрийн сүр хүчийг гадаадад нэн ялангуяа хойд туйлын бүсэд харуулах зэрэг асуудлууд багтжээ.
- Эдийн засгийн гадаад бодлогыг эрчимжүүлэх, гадаад зах зээлд гарах шинэ шинэ гарц хэрэгтэй гэжээ.

2015 оны сүүлчээр ОХУ-ын ерөнхийлөгч Владимир Путин “ОХУ-ын Үндэсний Аюулгүй байдлын Стратегийн тухай” хэмээх баримт бичигт гарын үсэг зуржээ. Ингэснээрээ 2009 онд тухайн үеийн ерөнхийлөгч Дмитрий Медведевийн баталсан баримт бичгийг шинэчилж байгаа юм. Барууны хэвлэлүүдийн бичиж байгаагаар 2009 оны хувилбарт АНУ болон НАТО-г огт дурдаагүй байсан бол энэ удаа тэднийг үндэсний аюулгүй байдалд заналхийлэгч гэж тодорхойлжээ. Энэ нь сүүлийн хэдэн жилд

⁹⁹ Московские новости сонин 2012 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн нийтлэлээс

Барууныхан болон Оросын хоорондох сөргөлдөөн хэр өндөр түвшинд хүрснийг харуулж байна.

Орчин цагийн дэлхий дэх Орос орон Уг баримт бичигт Орос орон хүчирхэгжиж, дэлхийн хэмжээнд бие даасан гадаад болон дотоод бодлого явуулж байгаад АНУ, түүний холбоотнууд хариу арга хэмжээг авахад хүргэж байна. Энэ нь тэдний дэлхийд ноёлж буй одоогийн байдлаа хэвээр хадгалах зорилготой холбоотой гэдэг нь тодорхой юм. Иймээс эдгээр улс орнуудын зүгээс орос улсад улс төрийн, эдийн засгийн, цэргийн болон мэдээллийн дарамт үзүүлэх замаар оросыг аргагүй байдалд оруулах зорилгоор явуулж буй бодлогоо цаашид үргэлжлүүлэх төлөвтэй байна.

Тийм учраас Оросын үндэсний эн тэргүүний зорилт бол дэлхийн тэргүүлэх гүрний нэг гэдэг байр сууриа бэхжүүлэх явдал мөн. Баримт бичигт заасан тус улсын урт хугацааны үндэсний ашиг сонирхол гэдэг хэсэгт “ОХУ-ыг дэлхийн тэргүүлэгч гүрний нэг гэдэг статусыг бэхжүүлэх, мөн тэргүүлэгч гүрнүүд олон туйлт дэлхийн дэх стратегийн тогтвортой байдал болон харилцан бие биедээ ашигтай байдлаар түншлэх асуудлыг баталгаажуулахад үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлэх ёстойг” дурджээ.

“Оросын үндэсний эн тэргүүний зорилт” гэдэгт улс орныг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлэх, үндсэн хуульт системийг хамгаалах, тусгаар тогтнол нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хадгалах, үндэсний нэгдмэл байдлыг бэхжүүлэх, иргэдийн аж амьдралыг дээшлүүлэх, соёл урлагийг хэвээр хадгалж хөгжүүлэх, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх болон үндэсний аюулгүй байдлын бусад зарчмуудыг онцлон тэмдэглэсэн байна. Стратегийн зорилтуудад хүнсний аюулгүй байдалтай холбоотой “Оросын хүнсний бие даасан байдал”-ыг хадгалах гэсэн заалт нэмж оруулжээ. Үүнд оросын хөдөө аж ахуйн хөгжлийг хурдасгах, энэ салбарт ажиллаж буй хүмүүсийн бизнест засгийн газрын байгууллагууд бодит дэмжлэг үзүүлэх, тус улсад “генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүн”-ий хяналтгүй урсгал орж ирэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, газар тариалангийн салбарын өндөр мэргэжилтэй боловсон хүчнийг системтэй сургаж бэлтгэх асуудлууд багтсан байна. Генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүн (GMO-Genetically modified organism) гэдэг нь генийн инженерчлэлийн аргаар генийн бүтцийг нь өөрчилсөн организмуудын нэгдлийг хэлнэ.

Дэлхийн шинэ олон төвт дэглэм тогтоох

“Дэлхийн шинэ олон төвт дэглэм” тогтоохын төлөөх үйл явц нь дэлхий даяар болон бүс нутагт тогтворгүй байдлыг араасаа дагуулах болно. Стратегийн бичиг баримтад дурдсанаар “дэлхийн тэгш бус хөгжил, зарим улс орнуудын иргэдийн аж амьдралын тэнгэр газар шиг ялгаа, байгалийн нөөц баялаг болон худалдааны замд хяналтаа тогтоох гэсэн эрмэлзэл, зах зээл олж авах гэсэн өрсөлдөөнөөс болж одоо гарч буй мөргөлдөөн нь улам гаарах төлөвтэй байна. Улс орнуудын хооронд гарч буй сөргөлдөөн нь хэтэрч энд тухайн улс орнуудын нийгмийн үнэт зүйлс болон хөгжлийн модель, хүний, технологийн, шинжлэх ухааны чадавх нь хүртэл татагдан орж, тооцогдох болжээ. Олон улсын тавцанд өөрийн нөлөөллийг тогтоох зорилгоор явуулж буй тэмцэлдээ улс төр, эдийн засаг, санхүүгийн болон мэдээллийн хэрэгслүүдийг ашиглаж байна. Ялангуяа нууц албадыг хүртэл энэ зорилгоор идэвхтэй ашиглаж байгааг энэ бичиг баримтад дурдаж өгчээ. Стратегийн баримт бичгийн гол агуулгыг дурдвал:

▪ **Оросын аюул заналын тоонд “Өнгөт хувьсгал” болон авлигыг оруулсан:** Үндэсний хэмжээний аюул заналд “өнгөт хувьсгал”, түүний хор уршиг, уламжлалт үнэт зүйлсийг нураах оролдлого болон авлигыг оруулсан байна. Баримт бичигт зааснаар Оросын газар нутгийн бүрэн бүтэн байдлыг нураах, улс төрийн үйл явцыг тогтворгүйжүүлэх зорилготой “үндсэрхэг үзэл, шашны экстремист үзэл санаан дээр суурилсан радикал бүлэглэлүүд, гадаадын болон олон улсын Засгийн газрын бус байгууллагууд, хувь хүмүүс” үүнд багтана гэжээ. Үүнээс гадна гадаадын тагнуулын байгууллагууд, террорист, экстремист байгууллагууд, гэмт хэргийн бүлэглэлүүдийг оруулсан байна.

▪ **АНУ-ын биологийн зэвсгийн аюул занал:** Баримт бичигт цөмийн зэвсэг эзэмших улс орнуудын тоо нэмэгдэж байгааг үндэсний аюул заналд тооцсон байна. Мөн химийн болон биологийн зэвсэг түгэн дэлгэрч байгааг ч үүнд оруулжээ. Үүнд ОХУ-ын хөрш улсуудад АНУ биологийн зэвсгийн лабораториудаа байгуулж байгааг онцгойлон дурдсан байна.

▪ **НАТО-гийн тэлэлт:** Умард Атлантын эвслийн гишүүнчлэл Оросын хил рүү тэлж байгааг үндэсний аюул занал гэж тооцжээ. Цэрэг зэвсгийн тоо хэмжээг нэмэгдүүлэх үйл явц Оросын хөрш орнуудад дэлгэрч, “эрх тэгш, бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх” зарчим Евро-Атлант, Еврази, Ази-Номхон далайн бүс нутгуудад алдагдаж байгааг эрсдэл гэж дурдсан байна. Гэхдээ баримт бичигт ОХУ нь НАТО, АНУ, Европын Холбоотой найрсаг харилцаатай байх, эрх тэгш яриа хэлэлцээр хийх сонирхолтой хэвээр байгаа ч Умарт атлантын эвсэл Норвеги, Швед, Финланд улсуудаар НАТО тэлж улмаар Украин, Гүрж улсууд эллэхэд бэлэн байна.

▪ **Украины нөхцөл байдал:** Украин ОХУ-ын дайны нөхцөл байдалд дариу 9 сар үргэлжилж байна Украин талд дэлхийн 160 гаруй орон дэмжиж байхад ОХУ дэмжиж байгаа 5 улс байна, түдгэлзсэн байр суурьтай 35 улсын дотор Монгол улс байгаа нь гадаад бодлогын үзэл баримттай нийцэж байгаа юм.

▪ **Цөмийн зэвсгийн асуудал:** ОХУ цөмийн зэвсгийн тоо хэмжээг хязгаарлах талаар зөвхөн харилцан зөвшилцсон, олон талын яриа хэлэлцээр хийхэд бэлэн гэдгийг баримт бичигт заажээ. Энэ талаар “олон улсын аюулгүй байдал, стратегийн тогтвортой байдлыг хөндөхгүй байх нөхцлийг бүрдүүлсэн тохиолдолд” ОХУ цөмийн зэвсгээ хязгаарлах талаар ярилцахад бэлэн гэсэн байна. Үүнээс гадна ОХУ цэргийн ажиллагаанд цөмийн зэвсэг хэрэглэхээс зайлсхийх, зөвхөн дайны бус бүх арга хэрэгсэл бүтэлгүйтсэн тохиолдолд ашиглахаар заажээ.

▪ **Мэдээллийн дайн:** Нууц байгууллагууд олон улсын харилцаанд нөлөөгөө нэмэгдүүлэхийн тулд янз бүрийн боломжийг ашиглах болсныг баримт бичигт дурджээ. Ингэхдээ “улс төр, санхүү, эдийн засаг, хэвлэл мэдээллийн хэрэгслийг” өөрийн эрх ашгийн тулд өргөнөөр ашиглаж байгааг онцлон үндэсний аюул заналын жагсаалтанд оруулсан байна.

▪ **Цэргийн хүчийг ашиглах тухай:** Стратегийн баримт бичигт “үндэсний ашиг сонирхлыг хамгаалах” бусад арга хэмжээнүүд үр дүнгүй болсон тохиолдолд цэргийн хүч ашиглаж болохыг заажээ.

▪ **Мөнгө, санхүүгийн асуудал:** Оросын эдийн засгийн тогтвортой байдалд учруулж байгаа аюул занал нь голдуу өөрийн өрсөлдөх чадвар муу, байгалийн баялгаас хамааралтай эдийн засагтай байгаагаас болж байгааг дурдсан байна. Үүнээс гадна “орчин үеийн технологийн хөгжил сул, санхүүгийн системийн эмзэг байдал, төсвийн системийн тэнцвэргүй байдал, оффшор эдийн засаг, түүхий эдийн хомсдол, сүүдрийн эдийн засгийн

хүч чадал, авлига, гэмт хэргийн өсөлт, бүс нутгуудын тэгш бус хөгжил” зэргийг аюул заналд тооцжээ.

▪ **Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах:** Стратегийн баримт бичигт эдийн засгийн хүндрэлтэй тэмцэх Оросын засгийн газрын төлөвлөгөөг тусгажээ. Үүнд төсвөө тэнцвэржүүлэх, хөрөнгийн гадагшаа урсгалыг зогсоох, инфляцийг бууруулах тухай дурдсан байна. Мөн Хятад, Энэтхэг, Латин Америк, Африкийн орнуудтай харилцаагаа хөгжүүлэхийг өндөр ач холбогдолтойд тооцжээ.

Монголын талаас тус уулзалтад Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга А.Гансүх оролцож байгаа бөгөөд уулзалтын хүрээнд ОХУ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга Н.П.Патрушевтай уулзаж аюулгүй байдлын чиглэлээр хоёр улсын хамтын ажиллагааны талаар харилцан санал солилцжээ. Мөн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон ОХУ-ын Аюулгүй байдлын зөвлөл хоорондын хамтын ажиллагааны протоколд гарын үсэг зурлаа.

Монгол ОХУ-ын харилцаа сүүлийн жилүүдэд улам өргөн харилцаатай болж байна тухайлбал 2019 оны 9-р сард ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин Монгол улсад айлчилж Монгол улс ОХУ хоорондын Иж бүрэн стратегийн түншлэлд гэрээнд гарын үсэг зурж, Халх голын ялалтын 85 жилийн ойн баярт оролцсон 2019 оны 12-р сард Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалаар Сибирын хүч-2 байгалийн хийн хоолойн төслийн хүрээнд Монгол улсаар дайруулан тавих талаар тавьсан саналыг ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин Газпромын захиралд үүрэг өгч судлуулж Судалгааны үр дүнд Монгол ороны нутаг дэвсгэр дээгүүр дайруулан хийн хоолой тавих боломжтой гэж дүгнэсэн нь сүүлийн 20 гаруй жил яригдсан асуудал нааштайгаар шийдвэрлэгдэж байна.

4. БНХАУ-ын Гадаад бодлого ба Монгол Улс

Өнөөгийн дэлхийн эдийн засгаар 2-рт явж буй БНХАУ-ын байр суурь өсөхийн хэрээр гадаад бодлогынхоо шийдвэр гаргах механизмыг боловсронгуй болгох асуудал Хятадын шинэ үеийн удирдагчдын гол анхаарах сэдэв болсон. Ялангуяа “Нэг бүс, Нэг зам” санаачлагыг төлөвлөн хэрэгжүүлэхэд гадаад бодлогын шийдвэр гаргах механизм нь нөхцөл байдал, цаг үетэйгээ зохицсон байхыг Хятадын удирдлагаас шаардаж байна.

Ши Зиньпин Хятадын удирдлагад гарч ирсэнээр гадаад бодлогын хувьд хэрэгжүүлэхийг зорьж буй нэг томоохон зорилго нь БНХАУ-ыг олон улсын харилцааны системд тэргүүлэх статус бүхий их гүрэн болгоход чиглэгдэж байгаа нь тодорхой. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд тэрээр гадаад бодлогын шийдвэр гаргах уламжлалт механизмыг шинэчлэх тал дээр дорвитой өөрчлөлтүүдийг хийгээд эхэлсэн. Түүний энэхүү шинэчлэл нь өмнөх үеийн удирдагчдын үед тогтсон системийг засаж сайжруулахаас эхлээд, гадаад бодлогын шийдвэрийн нэгдмэл байдлыг хангахын тулд АНУ-ын гадаад бодлого, аюулгүй байдлын шийдвэр гаргах механизмыг загвар болгож байгаа ажээ. Нэг талаас тэрээр шийдвэр гаргах эрх мэдлийг өөртөө төвлөрүүлж байгаа ч нөгөө талаас шийдвэр гаргах үйл явцад оролцдог бусад тоглогчдын үйл ажиллагааг ч дэмжин ажиллахад анхаарч байгаа нь судалгааны явцад нотлогдож байна. Ялангуяа шийдвэр гаргах үйл явцад бодлогын судалгааны хүрээлэн, гадаад бодлого, аюулгүй байдлын чиглэлээр судалгаа хийдэг их дээд сургуулиудын үйл ажиллагааг дэмжих тал дээр тодорхой санаачлагуудыг гаргасан байна. Ши Зиньпиний хийж буй хамгийн гол шинэчлэлийн ажил нь шийдвэр гаргах үйл явцад оролцдог институтуудын үйл ажиллагааг уялдуулан нэгтгэхэд оршиж багаа бөгөөд гадаад бодлого, аюулгүй байдлын бодлогын нэгдмэл байдлыг хангахын тулд 2013 онд түүний санаачлагаар байгуулагдсан Үндэсний Аюулгүй Байдлын Хороо чухал үүрэг гүйцэтгэх

ажээ. Энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго нь Хятадын шинэ үеийн удирдлага БНХАУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргах механизмыг хэрхэн өөрчилж шинэчилж байгааг тодруулахад оршиж байна.

Хятад улс гадаад бодлогын шийдвэр гаргах механизмаа шинэчлэхийн тулд нэгдүгээрт сул дорой улс оронд давуу байдал олгох дипломат харилцаанаас татгалзах хөрш зэргэлдээ улс орнуудтайгаа улс төрийн өргөн цар хэрээг хамарсан, урт хугацааны тогтвортой харилцаа тогтоох гэж заасан байна.

БНХАУ-ын дарга Ши Жиньпин 2012 онд эрх барьснаас хойш хятадын гадаад бодлого эрс идэвхэжсэн билээ. Ши Жиньпиний бүрэн эрхийн эхний хугацаанд 2014 онд Хятадын Коммунист Намын төв хорооны (НТХ) Гадаад ажлын анхны хурлыг хөрш орнуудын бодлогоор явуулсан. Энэ нь ямагт их гүрнүүдтэй харилцах харилцааг чухалчлан анхаарч ирсэн өмнөх үеэс өөр, үүгээрээ ч сонирхолтой байсан. Ши Жиньпиний бүрэн эрхийн хоёр дахь хугацаа эхлэхэд 2018 онд НТХ-ны Гадаад ажлын эхний хурлыг 6 дугаар сарын 22, 23-ны өдөр зохион байгууллаа. Тус ажлын хурал дээр БНХАУ-ын дарга Ши Жиньпин илтгэл тавьж, гадаад бодлогын шинэ чиг хандлагыг илэрхийллээ. Энэ сарын тоймд Шинэ эрин үеийн Хятадын гадаад харилцааны үзэл санаа, бодлого, чиг хандлагыг тоймлон хүргэж байна

Хятадын гадаад бодлогын үзэл санааны 10 зүйл

Хятадын Коммунист намын төв хорооны Гадаад ажлын хурал дээр Ши Жиньпин тавьсан илтгэлдээ “Шинэ эрин үеийн Хятадын онцлогтой социализмын гадаад харилцааны үзэл санаа”-г дараах 10 зүйлд багцлан тодорхойллоо. Үүнд:

1. Намын төв хороогоор удирдуулсан нам гадаад ажлыг нэгтгэн зангидаж чиглүүлнэ,
2. Хятад үндэстний сэргэн мандлыг эрхэм үүрэг болгож, Хятадын онцлогтой их гүрний гадаад харилцааг урагшлуулна,
3. Дэлхийн энх тайван, хамтын хөгжлийг эрхэм зорилго болгон хүн төрөлхтний нийтлэг хувь заяаг бататгана,
4. Хятадын онцлогтой социализмыг үндэс болгон стратегийн итгэлээ бэхжүүлнэ,
5. Хамтын зөвшилцөл, хамтын бүтээн байгуулалт, хамтын үр ашиг гэсэн зарчмаар “Бүс, Зам”-ыг бүтээн байгуулна,
6. Харилцан хүндэтгэж, хамтдаа хожсон энх тайванч хөгжлийн замаар замнана,
7. Гадаад харилцааны ажлын царааг харгалзан дэлхий даяар түншлэл байгуулна,
8. Эрх тэгш, шударга ёсыг эрхэмлэн даян дэлхийн засаглалын системийн өөрчлөлтийг түүчээлнэ,
9. Үндэсний язгуур ашиг сонирхлыг дээдлэн улсын бүрэн эрх, аюулгүй байдал, хөгжлийн ашиг сонирхлыг хамгаална,
10. Дипломат ажлын шилдэг уламжлал хийгээд цаг үеийн онцлогийг хамтад нь чиглэл болгон Хятадын гадаад харилцааны онцлог загварыг бий болгоно,

2012 оноос хойш хятадын гадаад бодлогод гарсан шинэчлэлтийг энэ 10 зүйлээс харж болохын сацуу цаашид баримтлах чиг шугамыг мөн баримжаалж болно.

Тодорхой хүчин зүйлс ба түүний нөлөө: Монгол, Хятад хоёр улсын хамтын ажиллагаанд тулгардаг бэрхшээл юунаас үүсдэг вэ? Үүнийг тодруулахын тулд харилцаанд нөлөөлдөг тодорхой ба тодорхой бус хүчин зүйлсийг авч үзлээ. Эхлээд тодорхой хүчин зүйлс буюу Монгол, Хятад хоёр орны суурь өгөгдөл ямар вэ, тэр нь харилцаа хамтын ажиллагаанд хэрхэн нөлөөлдөг вэ, цаашид яаж нөлөөлөх вэ гэдгийг харья.

Цар хэмжээний зөрүү: Монгол, Хятад хоёр улсын хэмжээ, цар хүрээ эрс ялгаатай, Хятад улс хэт том, Монгол Улс хэт жижиг, үүнээс болж нэг нь хэт давамгайлах, нөгөөх нь

хэт хамааралтай болох эрсдэл үүсдэг. Хятадын эдийн засаг дэлхийд 2-т, Монголын эдийн засаг дэлхийд 133-т, батлан хамгаалах хүчээр Хятад улс дэлхийд 3-т ордог, нийт хоёр сая цэрэгтэй. Монгол 3 сая хүн амтай, Хятад 1.36 тэрбум хүнтэй гэх мэтээр үргэлжилнэ. Цар хэмжээгээрээ эрс тэс ялгаатайн дээр Монголын газарзүйн хашигдмал нөхцөл манай гадаад хамаарлыг улам хүндрүүлдэг. Харамсалтай нь энэ өгөгдлийг өөрчлөх боломжгүй, өөрөөр хэлбэл хашигдмал жижиг улс хэмээх нөхцөл маань тодорхой хугацаандаа тогтмол юм.

Тэнцвэргүй байдлаас үүсдэг хэт хамаарал, эмзэг байдлыг саармагжуулах зарим боломж бий. Монголын тал энэ боломжийг эрэлхийлж ажилладаг. Хэт хамаарал, эмзэг байдал манай аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн гээд дийлэнх салбарт илэрч гардаг юм. Өнөөгийн байдлаар худалдаа эдийн засгийн салбарт хамгийн тод илрээд байгаа. Хятадын хэт том зах зээл Монголын хэт жижиг зах зээлтэй харилцахад гарсан гол үр дагавар нь Монголын экспортын бараг 90 хувь зөвхөн Хятад руу гардаг болсон буюу хэдийн том жижиг зах зээлийн тэнцвэргүй харилцаа бий болж ужгирсан явдал юм. Тиймээс Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг улам сайжруулангаа хамааралтай эмзэг байдлаа яаж саармагжуулж явах вэ гэдэг нь тулгамдсан асуудал болоод буй.

Аюулгүй байдлын салбарт: цар хүрээний хэт зөрүүтэй байдал нь аяндаа жижиг улсад аюулгүй байдлын зовнил үүсгэдэг. Монгол Улс хоёр том хөрш орноос хэт хамаарал үүсгэхгүй байх зорилгоор олон талт гадаад бодлого хэрэгжүүлдэг билээ. Монгол Улс Хятадтай иж бүрэн стратегийн түншлэлийг тогтоосны зэрэгцээ “гуравдагч хөрш”-ийн бодлогыг идэвхтэй явуулахыг хичээдэг нь цөөн хөрштэй жижиг орны бодит байдлаас урган гарсан, хэт хамаарлаа бууруулах зорилготой зүй ёсны үйлдэл юм. Монголын “гуравдагч хөрш”-ийн бодлого нь хэт хамаарлаа бууруулж, аюулгүй байдлаа бататгах гэсэн жижиг орны зовнилоос үүдэлтэй болохоос бус Хятадад сорилт учруулж хожоо гаргах гэсэн “тоглоом” биш билээ.

Үндэсний ашиг сонирхлын зөрүү: Монгол, Хятад хоёр улс тусгаар тогтнолоо харилцан зөвшөөрсөн, газар нутгийн маргаангүй. Гэвч Монгол, Хятадын харилцаанд үе үе Далай ламын асуудал үүсдэг нь үндэсний ашиг сонирхлын зөрүүтэй байдлаас урган гардаг. Монголын зонхилох шашин бол буддын шашин, Монгол Улс Х Богдоо тодруулахад шашны түүхэн уламжлалт институцын дагуу Далай ламын оролцоо зайлшгүй хэрэг болдог. Энэ шалтгаанаар Далай ламыг Монголд айлчлуулсан. Үүний зэрэгцээ буддын шашин шүтдэг сүсэгтнүүд Далай ламын номын айлдварыг сонордох хэрэгцээ шаардлага бий. Энэ мэт шалтгаанаар XIV Далай лам Монголд нийт 9 удаа айлчилсан. Харин Хятадын хувьд Далай лам салан тусгаарлах үзэлтэн, хагалан бутаргагч, Далай ламыг айлчлуулах нь Хятадын бүрэн бүтэн байдалтай холбоотой язгуур ашиг сонирхлыг шууд хөндсөн хэрэг гэж Хятад улс үздэг.

ОХУ нь аль тогтворгүй байгаа газруудад нөлөөгөө тогтоох Ойрх-дорнод, Алс дорнод, Африк, Өмнөд ази, Латин Америк, Солонгосын хойг багтаж байгаа ба шинээр иймэрхүү газруудад нөлөөлөө тогтоох явдал юм.

Монгол улсын хувьд ОХУ-ын гадаад бодлогод сүүлийн жилүүдэд нэлээд ахиц гарч байгаа нь эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалт, цэргийн зэвсэг техникийн тусламж үзүүлэхэд чиглэж байна. Монгол улсын Ерөнхий сайдын ОХУ-д хийсэн айлчлалаар БНХАУ-руу тавих байгалийн хийн хоолой “Сибирийн хүч-2 төсөлд Байгалийн хийн хоолойг Монголоор дайруулан тавих асуудлууд нэлээд түлхүү яригдсаны үр дүнд ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин Газпром компани удирдлагад үүрэг чиглэл судалгаа хийлгэсэн нь Монгол улсын нутаг дэвсгэр дээгүүр байгалийн

хийн хоолой дамжин өнгөрүүлж тавих боломжтой гэсэн дүгнэлтэнд хүрсэн нь сүүлийн 30 гаруй жил яригдсан хийн хоолой тавигдах асуудал шийдвэрлэгдэх боломжтой болж байна.

ОХУ-ын гадаад бодлогод Монгол улсын үндэсний аюулгүй байдалд харшлах зүйл одоохондоо алга байна гэж үзэж байна, Яагаад гэвэл ОХУ өргөн уудам нутаг дэвсгэртэй нийт хүн ам тоо 145 сая хүнтэй нийт хүн амын 30 хувь нь Уралын нуруунаас Алс дорнодын бүсэд амьдарч байна, 70 хувь нь европын хэсэг буюу Уралын нуруунаас баруун тийш амьдарч байна. Ийм учираас газар нутагаа тэлэх бодлоггүй харин хүн ам цөөрч байгаа Сибирийг хөгжүүлэх нь ОХУ-ын нэг чухал асуудал юм. Гэвч Монгол улс байнга болгоомжтой байхад илүүдэхгүй 2014 онд ОХУ Крымыг өөртэй нэгтгэсэн явдал, 2022 оны 2-р сараас эхэлсэн Орос Украины дайн нь хэзээ ч ийм зүйл болохгүй гэсэн баталгаа алга үүнд Монгол улс төрийн хар хайрцагны бодлого чангатгаж хэзээч хаанаас ч аюул ирж болох үүднээс төрийн тогтвортой байдал, залгамж чанарыг хадгалж байх нь зүйтэй байна.

Өнөөдөр Монгол улс БНХАУ-аас эдийн засгийн хувьд хараат байдалд орсон байна, худалдааны эргэлтийн 90 хувь, Монгол Улсад БНХАУ-аас 4.4 тэрбум орчим ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн. Монгол Улсад бүртгэлтэй БНХАУ-ын нийт 10.000 гаруй аж ахуйн нэгж байна. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал Хоёр хөрштөйгөө эн тэнцүү харилцах зарчим Хоёр хөрштөйгөө харилцаагаа жигнээд, цэгнээд үзэхэд чухамдаа эн тэнцүү байна уу гэдэг асуудал гарч ирнэ, Энэ нь эдийн засгийн хувьд хараат байдалд орж цаашлаад улс төрийн хувьд хараат байдалд орж болзошгүй байна. Жишээ нь Тажикстан улс БНХАУ-д их хэмжээний өртөй мөн бусад оронуудад өртэй байсан 2014 онд БНХАУ Тажикстан улсын өрийг барагдуулаад газар нутгаас нь авч улмаар онцгой бүс болгож Хятадын цэрэг оруулсан байна, Манай ийм явдал болохгүй гэх баталгаа алга, нэг улсаас эдийн засгийн хувьд хараат байх явдал нь үндэсний аюулгүй байдал алдагдахад хүрч мэднэ.

Хятадын үе уламжилсан төрийн бодлогод Монгол улсын өөртэй нэгтгэх бодлого юм, энийгээ хэрэгжүүлэхийн тулд хэдэн арав зуун жилээрч тэвчээртэй таатай нөхцлийг хүлээж байдаг байна.

Шанхайн хамтын ажиллагааны байгууллага нь 2004 оноос уг байгууллагыг өөрийн төсөв, ажиллагааны механизмтай болгон албажуулжээ. Байгууллагын зорилгыг: хамтын итгэлцэл, найрамдал, сайн хөршийн холбоо, энх тайван аюулгүй байдал, бүс нутгийн тогтвортой байдлын төлөөх хамтын ажиллагаа, терроризм, салан тусгаарлал, хэт давралын эсрэг хамтран тэмцэх, улс төр худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа гэх мэтээр тодорхойлсон байна.

ШХАБ нь цэрэг улс төрийн байгууллагын тул сүүлийн үед Монгол улсыг гишүүнээр элсэх тухай нэлээд яригдсан энэ нь Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалтай зөрчилдөж байгаа нь “Эвсэлд үл нэгдэх” гэдэг ойлголтыг тодорхойхон хэлбэл “цэрэг улс төрийн эвсэлд нэгдэхгүй” гэсэн санаа юм. Хэрэвээ Монгол улс ШХАБ-д гишүүнээр элсэн тохиолдолд МУ-ын гадаад бодлогын үзэл баримтлалтай зөрчилдөж болзошгүй байна. Иймд Монгол улс ажиглагчийн статустайгаар оролцож байх нь зүйтэй байна.

БНХАУ, Монгол улс ОХУ-ын төрийн тэргүүн нарын гурван талт уулзалт Монгол улсад одоогийн нөхцөл байдалд ашиг багатай хоёр талт харилцаа нь илүү чухал байсан байх, Монгол улстай холбоотой асуудал шийдвэрлэх болгонд ОХУ, БНХАУ заавал нэг

нэгнээс нь асуух шаардлага урган гарна, харин хоёр талт хамтын ажиллагаан хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэх боломжтой нь давуу талтай байна.

Монгол улс тусгаар тогтнолын баталгаа болсон Оюуны тусгаар тогтнол, Цусны тусгаар тогтнол, Орон зайн тусгаар тогтнол, засаглалын тусгаар тогтнол, Ахуйн тусгаар тогтнол, дөрвөн баталгааг БНХАУ-д алдах байдалд хүрээд байгаа ба одоогийн байдлаар Орон зайн тусгаар тогтнол буюу хил хязгаарын бүрэн бүтэн байдал хэвээр хадгалагдаж байна.

БНХАУ өнөөгийн байдлаар 1 миллиард 360 гаруй сая хүн амтай Хятадын бодлого бол аль болох хүн амаа цөөлөх бодлого барьж байгаа ийм ч учираас хүн амын өргөн хэрэглэгддэг хүнсээр нь дамжүүлж насжилтыг богиносгох, генийн өөрчлөлттэй хүнсний бүтээгдэхүүн маш хямд үнэтэй хүнсний ногоо ихээр тариалаж хүнсний хэрэгцээг хангаж байна. Монгол улс импортын хүнсний түүхий эд. бүтээгдэхүүний хувьд 2017 оны байдлаар 20 бүлгийн 178 төрлийн нийт 331.5 сая ам. долларын хүнсний түүхий эд. бүтээгдэхүүнийг импортолсон байна¹⁰⁰ эдгээрийн нэлээд хувийг жимс жимсгэнэ, хүнсний ногоо эзэллэж байгаа юм, Иймд аль болох гаднаас авахгүй дотооддоо үйлдвэрлэж хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах шаардлагатай байна.

5. ДҮГНЭЛТ:

Монгол Хятадын өнөөгийн харилцаа бол Монгол улсад зээл тусламж их хэмжээгээр авч байгаа нь яваандаа эдийн засгийн хувьд нэг ороноос /БНХАУ/-аас хараат байх явдал үүсэх, улмаар улс төрийн хувьд хараат байдал үүсч болзошгүй тул хэт нэг БНХАУ-аас авч байгаа зээл тусламжаа тодорхой түвшинд барьж хязгаарлах, гуравдагч оронтой худалдаа, эдийн засаг хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

БНХАУ-ын хэрэгжүүлж байгаа “Бүс ба Зам” нь Хятадын бараа бүтээгдэхүүний дундад азиар дамжуулж Европын оронуудад хүргэх худалдааны төсөлд юм, үүнд Монгол улс оролцох нь эдийн засгийн хувьд ашигтай юу ашиггүй юу гэсэн хувилбарууд яригдаж байгаа энэ үед Монгол улс энэ төсөлд нэгдсэнээр эдийн засгийн хувьд ямар үр өгөөжтэй тодорхойлох хэрэгтэй, энэ төсөл оролцсоноор Монголын экспортын бараа бүтээгдэхүүнийг гуравдагч зах зээлд борлуулах боломжтой эсэх судлах шаардлагатай байна.

ОХУ-ын нэг онцлог нь өргөн уудам нутаг дэвсгэр хүн ам сийрэг нийт хүн амын 70 хувь нь Европын хэсэг буюу Уралын нуруунаас цааш, 30 хувь нь Сибирь, Алс дорнодод амьдарч байна, ОХУ-ын хувьд одоохондоо Украин, Крымын асуудлаас болж Олон улсын хоригоос болж эдийн засгийн хувьд суларсан боловч байгалийн баялагын асар их нөөцтэй ороны хувьд сүүлийн жилүүдэд Алс дорнодыг хөгжүүлэх, сибир гэж жил ирэх тусам хүн амын сийрэгжиж байгаа тул энэ бүс нутгийн эдийн засгийн хөгжүүлэх Монгол улс дагаж хөгжихөд таатай боломж байна гэж болно, Бүс нутгийн аялал жуулчлал, хил орчимын худалдаа, эдийн засгийн чөлөөт бүсийг хөгжүүлэх боломжтой байна.

Шанхай хамтын ажиллагааны байгууллагад Монгол улс гишүүнээр элсэх талаар сүүлийн жилүүдэд нэлээд яригдсан Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалтай зөрчилдөж байгаа нь “Эвсэлд үл нэгдэх” гэдэг ойлголтыг тодорхойхон хэлбэл “цэрэг улс төрийн эвсэлд нэгдэхгүй” гэсэн санаа юм. Хэрэвээ Монгол улс ШХАБ-д гишүүнээр элсэн тохиолдолд МУ-ын гадаад бодлогын үзэл баримтлалтай зөрчилдөж болзошгүй байна. Иймд Монгол улс ажиглагчийн статустайгаар оролцож байх нь зүйтэй байна.

¹⁰⁰ Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны албан ёсны сайтаас статистик мэдээлэл.

Эцэс нь хэлэхэд Монгол улс гуравдагч хөршийн бодлогодоо ахиц гаргах шаардлагатай, Орос Хятад хоёр хөршийн төрийн хар хайрцагны бодлого бол Монгол улсыг хөгжүүлэх дургуй энэ хэмжээнд нь байлгаж байх сонирхолтой хоёр хөршөөс хараат байх бодлого бол аль ч үед байсан одоо ч байгаа гэж хэлж болно.

САНАЛ:

1. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал хоёр хөрштэйгээ эн тэнцүү харилцах гэсэн зарчимаа хадгалах, нэг талыг хит барихгүй байх тэнцвэртэй харилцааг хөгжүүлэх, эдийн засгийн хувьд гуравдагч хөршийн бодлого ахиц гаргах харилцан ашигтай худалдаа, хөрөнгө оруулалтыг түлхүү оруулах
2. Аливаа үндэсний аюулгүй байдал нөлөөлсөн эвсэлд нэгдэхгүй байх зарчимаа хадгалж Монгол Улс ШХАБ-д гишүүнээр элсэн орох шаардлагагүй байна.
3. Монгол, ОХУ, БНХАУ-ын дээд хэмжээний 3 талт уулзалтаар Монголын талд одоогоор үр ашиг багатай тул 2 талд хамтын ажиллагаа нь Монголд хоёр хөрштэйгээ тус тус нь асуудлаа шийдээд явах нь үр дүнтэй гэж харагдаж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол улсын үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт 2019 он.
2. Монгол улсын Гадаад бодлогын үзэл баримтлал 1994, 2011 он.
3. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2011 он.
4. Монгол улсад Гадаад бодлогын үзэл баримтлал батлагдсаны 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын материалууд.
5. Московские новости сонин 2012 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн нийтлэлээс.
6. ОХУ үндэсний аюулгүй байдлын стратеги шинэчилэл 2015 он.
7. ОХУ-ын Уфа хотноо "Аюулгүй байдлын асуудал эрхэлсэн өндөр, дээд албан тушаалтнуудын 10 дахь удаагийн уулзалт" 2019 оны уулзалтын материалаас.
8. “Монгол Хятадын Харилцаа Ба Нөлөөлөгч Хүчин Зүйлс” Аюулгүй байдал судлалын хүрээлэнгээс гаргасан нийтлэл 2019 он.
9. Б.Батцэцэг: “Монгол, Хятадын харилцаа түүхэн дэх хамгийн таатай үедээ байна” нийтлэлээс 2019 он.
10. Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны албан ёсны сайтаас статистик мэдээлэл.

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН
ГАЗАРТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ**
SPECIAL STATE PROTECTION FROM THE POLICE
SOME ISSUES TO CONSIDER WHEN WORKING WITH THE GROUND

Г.Төртүлга

*Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн
багш, цагдаагийн хошууч*

Turtulga Gantumur

*Lecturer of police Law department,
Police school of University
Of Internal Affairs, Police major*

Хураангуй: Төрийн тусгай хамгаалалтын газар нь Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээнд заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Монгол Улсад айлчилж байгаа гадаад орны төр, засгийн газрын тэргүүн, дээд, өндөр хэмжээний зочид, төрийн яамд болон хамгаалуулагчийн байрлаж байгаа барилга, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй террорист халдлагаас урьдчилан сэргийлэх, халдлагыг таслан зогсоох чиг үүргийг хэрэгжүүлдэг Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага юм.

Энэхүү өгүүлэлд цагдаагийн байгууллага, Төрийн тусгай хамгаалалтын газартай хамтран ажиллахад цаашид анхаарвал зохих зүйлс, тулгамдаж буй зарим асуудлыг товч авч үзэхийг зорилоо.

Abstract: In accordance with the laws of Mongolia and the international treaties to which Mongolia is a party, the State Special Protection Office is responsible for the President of Mongolia, the Speaker of the State Parliament, the Prime Minister, the heads of foreign governments, heads of governments, high-ranking guests, and government ministries visiting Mongolia. It is an organization with a special function to ensure the national security of Mongolia, which implements the functions of ensuring the safety of buildings and vehicles where the security guard is located, preventing potential terrorist attacks, and stopping attacks.

In this article, we aim to briefly discuss some of the issues and issues that should be paid attention to in cooperation with the police and the State Special Security Agency.

Түлхүүр үг: Хамгаалуулагч, шадар хамгаалалт, гадуур хамгаалалт, далд хамгаалалт, цувааны хамгаалалт.

Key words: Guard, Musketeer, Outer Guard, Covert Guard, Convoy Guard.

Монгол Улсад 1995 онд Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийг баталж Төрийн тусгай хамгаалалтад байвал зохих субъект, объектыг тодорхой зааж өгснөөр тэдний аюулгүй байдлыг хангах үндэс болж өгсөн юм. Тухайлбал Монгол Улсын ерөнхийдөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, гадаад улсаас Монгол улсад айлчлан ирж буй өндөр, дээд хэмжээний зочин төлөөлөгчдийг Төрийн тусгай хамгаалалтын газраас Цагдаагийн байгууллага болон бусад тусгайлсан чиг үүргийн байгууллагатай хамтарч дээрх

иргэд, албан тушаалтан /хамгаалуулагч/-ы аюулгүй байдлыг хангаж, хамгаалалтыг хариуцан зохион байгуулж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын аюулгүй байдал алдагдах нь өөрөө Монгол Улсын үндэсний аюулгүй байдал алдагдаж буйтай ижил ойлголт учир дээрх албан тушаалтнуудын амьдарч буй орон сууц, унаж буй автомашин, ажлын байр, нэвтэрч, үйлчүүлж буй аж ахуй нэгж, байгууллага, объект нь түүнийг дагаад Төрийн тусгай хамгаалалттай бүсэд тооцогддог.

Хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангахад Төрийн тусгай хамгаалалтын газар дангаар үүрэг гүйцэтгэх нь учир дутагдалтай байдаг тул төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудтай харилцан хамтарч ажиллах, тэднийг үйл ажиллагаандаа татан оролцуулах шаардлага тулгарч, хуулиндаа бусад тусгай чиг үүргийн байгууллагыг ямар эрх, үүрэгтэй оролцох талаар тусган оруулж, түүнээс улбаалан байгууллагын дарга нар хамтран ажиллах журмыг боловсруулан батлаж, хэрэгжүүлдэг.

Засгийн газар 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдөр “Агентлаг байгуулах тухай” 218 дугаар тогтоол гаргаж, Төрийн тусгай хамгаалалтын газрыг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээн дэх Засгийн газрын тохируулагч агентлаг болгон өөрчлөн зохион байгуулсан. Иймд Төрийн тусгай хамгаалалтын газар нь бие даан хамгаалалт төлөвлөж, зохион байгуулах шаардлага гарсан тул эрх зүйн орчиноо бүрдүүлэх хэрэгтэй болсон юм.

Тагнуулын ерөнхий газрын дэргэдэх Төрийн тусгай хамгаалалтын газрыг Засгийн газрын тохируулагч агентлаг болгон өөрчлөн зохион байгуулсан нь цаашид тагнуулын байгууллагаас хараат бусаар, бие дааж үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэс бүрдсэн.

Төрийн тусгай хамгаалалттай холбоотой эрх зүйн эх сурвалжийг тодруулж үзвэл Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн тавдугаар бүлэгт “Төрийн тусгай хамгаалалтын талаар тагнуул, цагдаа болон бусад байгууллага, албан тушаалтан, иргэний хүлээх үүрэг” - ийг зааж өгсөн бөгөөд “Цагдаагийн байгууллага нь энэ хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,5-д заасан, шаардлагатай тохиолдолд бусад хамгаалуулагчийг баяр ёслол, олон нийтийн болон бусад арга хэмжээнд оролцох, автотээврийн хэрэгслээр зорчих, орон нутагт байх үед хөтөч машин ажиллуулж, хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган, хэв журмын хамгаалалт зохионо”, “Төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлийн орчинд гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эргүүл ажиллуулна”¹⁰¹ гэж цагдаагийн байгууллагын үүргийг тус тус зааж өгсөн бол Олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд Цагдаагийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлд “Төрийн тусгай хамгаалалтын хууль тогтоомжид заасан үүрэг гүйцэтгэх”¹⁰² гэж заажээ.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 3 дугаар зүйлд “Төрийн тусгай хамгаалалт гэдэг нь аюулгүй байдлыг нь хангах зорилгоор хуулиар төрийн тусгай хамгаалалтад авахаар тогтоосон төрийн байгууллага, тэдгээрийн зарим үйл ажиллагаа, албан тушаалтан, иргэний амь бие, ордон, өргөө, зориулалтын орон сууц, тээврийн хэрэгсэл, бусад зүйлийг хамгаалахад чиглэсэн мэргэжлийн болон бусад байгууллага, албан тушаалтны харилцан уялдаатай цогцолбор үйл ажиллагаа мөн” гэж тодорхойлсон.

Төрийн тусгай хамгаалалт үндсэндээ шадар хамгаалалт, гадуур хамгаалалт, далд хамгаалалт, цувааны хамгаалалт гэж дөрвөн төрөлд хуваагдаж, өөр өөрийн гэсэн хамгаалалтын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тухайлбал шадар хамгаалалт нь хамгаалуулагчийг биечлэн хамгаалах, гадуур хамгаалалт нь тодорхой объектод ирэх, буцах үеийн дотор, гадна

¹⁰¹ Төрийн мэдээлэл. 1995. №7. Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль

¹⁰² Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

талд хамгаалах, далд хамгаалалт нь ойр орчин, явах зам, чиглэлийг далб байдлаар хамгаалах, цувааны хамгаалалт нь автотээврийн хэрэгслээр зорчих үед нь хамгаалах зохион байгуулалтын арга хэмжээг авдаг байна.

Мөн төрийн тусгай хамгаалалт нь хамрах хүрээ, хүч хэрэгсэл, нөхцөл байдлаас шалтгаалан нэг, хоёр, гурав, дөрөвдүгээр зэрэглэлийн хамгаалалтыг зохион байгуулдаг бөгөөд цагдаагийн байгууллагаас нэг, хоёрдугаар зэрэглэлийн үеийн хамгаалалтыг Төрийн тусгай хамгаалалтын газартай хамтран зохион байгуулж байна. Тухайлбал:

“Нэгдүгээр зэрэглэл”-д Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Монгол Улсад айлчилж байгаа гадаад орны төр, засгийн газрын тэргүүн, өөрийн хамгаалалттай ирсэн дээд хэмжээний зочид ордог бол “Хоёрдугаар зэрэглэл”-д Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгэгч, Ерөнхий сайдын үүргийг орлон гүйцэтгэгч, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч, Монгол Улсад айлчилж байгаа гадаад орны өндөр хэмжээний зочид тус тус багтдаг.

Мөн Монгол Улсын ерөнхийлөгчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 “Түүний бие, нэр төр, ордон, өргөө, унаа халдашгүй дархан байна”, 16.5 “Түүний амь бие, ордон, өргөө, холбоо, уналгын хэрэгсэл улсын хамгаалалтад байх бөгөөд эхнэр /нөхөр/, насанд хүрээгүй хүүхдийг нь шаардлагатай үед улсын хамгаалалтад авна”¹⁰³, Засгийн газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.1 “Түүний бие, нэр төр, уналга, зориулалтын орон сууц халдашгүй дархан байна”, 25.2.7 “Түүний амь бие, орон сууц, уналга, холбооны хэрэгсэл улсын хамгаалалтад байх бөгөөд эхнэр /нөхөр/, насанд хүрээгүй хүүхдийг нь шаардлагатай үед улсын хамгаалалтад авна”¹⁰⁴ гэж тус тус зааж өгчээ.

Төрийн тусгай хамгаалалтын газар нь Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээн дэх Засгийн газрын тохируулагч агентлаг болон өөрчлөгдсөнтэй холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын дарга, Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын хамтарсан 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн МН/17, А/МН/23 дугаарын тушаалаар баталсан “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай цагдаагийн байгууллага харилцан ажиллах журам”-аар зохицуулан ажиллаж байна. Энэхүү журам нь нууцыг зэрэгтэйгээр хэрэгждэг байна.

Дээрх хууль, журмын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Эргүүл, хамгаалалтын газрын Төрийн хамгаалалтын хэлтэс нь гадаад улсын төрийн дээд хэмжээний зочин төлөөлөгчийн айлчлалын үеийн хамгаалалт, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайдын тодорхой объектод ирж, буцах үеийн хамгаалалтыг өдөр тутам зохион байгуулан Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангадаг.

Тус хэлтэс нь 2020 онд 343, 2021 онд 251, 2022 онд 405, 2023 онд 248 удаа хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах объектын хамгаалалтыг тус тус зохион байгуулж ажилласан дүн мэдээ гарчээ. Үүнээс авч үзвэл нийслэл болон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын алба хаагчдаас илүү Төрийн тусгай хамгаалалтын газрын алба хаагчтай өдөр тутам хамтран ажиллаж нягт холбоотой болсон байна.

Харин нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын алба хаагчид Төрийн тусгай хамгаалалтын газартай тэр бүр хамтран ажилладаггүй тул тухайн байгууллагын алба хаагч нартай хамтран хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах хамгаалалт зохион байгуулахад зарим тохиолдолд үл ойлголцох асуудлууд үүсдэг. Тухайлбал:

¹⁰³ Төрийн мэдээлэл. 1993. №3. Ерөнхийлөгийн тухай хууль

¹⁰⁴ Төрийн мэдээлэл. 1993. №3 Засгийн газрын тухай хууль

Тохиолдол 1: Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Соёлын төв өргөөнд хамгаалуулагч нэгдсэн уулзалтад оролцож, төлөвлөгөөт цагаасаа өмнө объектоос гарах үед гадна объектын хамгаалалтад ажиллаж буй цагдаагийн алба хаагч дотор хамгаалалтад ажиллаж буй Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчаас мэдээлэл авч чадалгүй хамгаалалтын байрлалдаа хоцорч очиход хамгаалуулагч явж өнгөрсөн.

Тохиолдол 2: Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр байрлах төсөл хэрэгжүүлэгч барилгын алслагдсан талбайтайтай хамгаалуулагч танилцах үед тухайн дүүргийн цагдаагийн газрын алба хаагчид зам дагуу болон бүхий л орц гарцан дээр гэрэлтүүлэгч хантаазтай цагдаагийн алба хаагчдыг байрлуулсан байна. Төрийн тусгай хамгаалалтаас иргэдийн анхаарлыг таталгүй бага хүн хүчээр хамгаалалтаа авах хүсэлт гаргасан боловч “Та нар үүрэг чиглэл өгөх албан тушаалтан биш, яаж хамгаалалтаа авахаа бид өөрөө мэднэ” гэж үл тоосон байна. Үүний улмаас сошиалд хэдэн зуун цагдааг дайчилж, зам хаалаа, ингэж сүр бадруулах хэрэг байна уу гэх мэтчилэн сөрөг сэтгэгдлүүд ихээр тархаж, олны анхааралд өртжээ.

Дээрх тохиоддлуудаас авч үзвэл “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай цагдаагийн байгууллага харилцан ажиллах журам” нь нууцын зэрэгтэй байдаг тул нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын алба хаагчид төдийлөн бүрэн танилцаагүйтэй холбоотой гэж үзэж болох юм.

Өнөөдрийн байдлаар хоёр байгууллага хамтран ажиллахад тулгарч буй асуудал нь хоёр байгууллагын алба хаагчдаас нэг тал нь давуу эрхтэйгээр хамгаалалтыг удирдаж чиглүүлэх, нөгөө тал нь тухайн шаардлагыг хүлээж авалгүй өөрийн арга барилаар хамгаалалтыг зохион байгуулах гэсэн хандлага ажиглагддаг. Үүнээс болж хамгаалуулагчийн аюулгүй байдал алдагдах эрсдэл учирч байна. Угтаа хоёр байгууллагын алба хаагчид мэдээ мэдээлэлдээ үндэслэж, нөхцөл байдалдаа тохируулан санал, хүсэлт солилцож, хамгаалалтын арга тактикийг боловсруулан ижил эрх мэдэлтэйгээр хамтран үүрэг гүйцэтгэх шаардлагатай юм.

Мөн хоёр байгууллагын алба хаагчид хамтран ажиллахдаа нэгэндээ заавал биечлэн очиж хамгаалуулагчийн нөхцөл байдлыг танилцуулж байгаа нь хугацаа алдах, хамгаалалтын түргэн шуурхай байдал алдагдах асуудал үүсч байгааг дурдах нь зүйтэй юм. Түүнчлэн объектод хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангаж ажиллахад олон цагдаагийн алба хаагчаар хамгаалалт зохион байгуулахад иргэдийн анхаарлыг ихээр татаж, тэднийг бухимдуулах, улмаар хамгаалуулагчид халдах сэдэлийг төрүүлдэг тул нөхцөл байдлыг үнэлж хамгаалалтыг зохион байгуулвал үр дүнтэй юм.

Дүгнэлт. Төрийн дээд хэмжээний болон бусад хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах хамгаалалтыг хоёр байгууллага хамтран зохион байгуулахад нутаг дэвсгэр хариуцсан цагдаагий байгууллагын алба хаагчид Төрийн тусгай хамгаалалтын газрын алба хаагч нартай хэрхэн хамтарч ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэлгүй, харин Эргүүл, хамгаалалтын газрын Төрийн хамгаалалтын хэлтсийн алба хаагчид өдөр тутам хамтарч ажилладаг тул нягт харилцан холбоотой ажилладаг байна.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын хамтарсан 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн МН/17, А/МН/23 дугаарын тушаалаар баталсан “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай цагдаагийн байгууллага харилцан ажиллах журам” нь нууцын зэрэгтэй байдаг тул нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн алба хаагчид бүрэн танилцаагүй нь хоёр байгууллага хамтарч ажиллах үед илэрдэг байна.

Мөн дээрх журамтай бүрэн танилцаагүйн улмаас нэг нэгнийхээ хууль ёсны шаардлага, хүсэлтийг үүрэг, даалгавар мэт тусган авч, төвөгшөөх, үл тоох, өөрийн байр суурийг хамгаалах зэрэг хувийн үзэл бодол нь хамгаалалтад сөрөг нөлөө үзүүлдэг.

Мэдээ, мэдээллийн эрэн зуунд амьдарч байгаа энэ үед хоёр байгууллага нэгдсэн торонд холбогдож, мэдээ, мэдээллийг цаг алдалгүй өгөх нь чухал байтал техник хэрэгслээр бус биеэр очиж мэдээллээ өгч байгаа нь хугацаа алдаж байна гэж дүгнэлээ.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн ерөнхий газрын дарга, Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын хамтарсан 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн МН/17, А/МН/23 дугаарын тушаалаар баталсан “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай цагдаагийн байгууллага харилцан ажиллах журам”-ыг нууцын зэрэглэлээс гаргаж нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын алба хаагч нэг бүрт нууцын баталгаа гаргуулан танилцуулж, сургалт орох.

2. Цагдаагийн байгууллага Төрийн тусгай хамгаалалтын газартай объектын хамгаалалт зохион байгуулах талаар хамтарсан дадлага, сургалтыг зохион байгуулж хэвших.

3. Хамгаалуулагчийг үзвэр, үйлчилгээ, олон нийтийн болон бусад томоохон арга хэмжээнд оролцох үеэс бусад тохиолдолд нөхцөл байдлыг үнэлэн хамтрагч байгууллагатайгаа харилцан тохиролцож зарим цагдаагийн алба хаагчдыг энгийн хувцастай далд хэлбэрээр үүрэг гүйцэтгүүлэх.

4. Хамгаалалтыг удирдан зохион байгуулж буй алба хаагч бусад орны тэргүүн туршлагыг судлаж нэгэн хэвийн хуучин арга барилаас татгалзах.

5. Хоёр байгууллагын хамгаалалт удирдах албан тушаалтнууд станцны нэгдсэн сувагт орох боломжийг нээж, мэдээ мэдээллээ хугацаа алдалгүй солилцох нөхцлийг бүрдүүдэх.

Ашигласан материал:

- 1.Цагдаагийн албаны тухай хууль
- 2.Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль
- 3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль
- 4.Монгол Улсын Засгийн газрын тухай хууль

**ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД НУТГИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО, ХАМТЫН
АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ НЬ
IMPROVING LOCAL STATE PARTICIPATION AND COOPERATION
IN AUTO ACCIDENT PREVENTION**

*Д.Энх-Амар
Дотоод хэргийн их сургуулийн ЭЗНУС-ийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн ахмад
D.Enkh-Amar
Teacher of the Public Law Department of the Law
School of the University of the Interior, Police Captain*

Хураангуй. Өнөө цагт техник, технологи асар хурдацтай хөгжиж, түүний хэрээр хүн төрөлхтөн технологийн хараат болж, өдөр тутмын амьдрал үйл ажиллагаагаа техник хэрэгслийн тусламжтайгаар зохицуулж байгаа билээ. Үүнтэй зэрэгцээд айл өрх бүр авто тээврийн хэрэгсэл эзэмшиж, ашиглаж, амьдрал ахуйгаа залгуулж байна. Жилээс жилд Монгол Улсын хилээр импортлогдон орж ирж буй авто машины тоо нэмэгдэж, авто замын ачаалал ихсэж байгаа нь бидний өдөр тутмын амьдралд мэдрэгдэж байгаа билээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдал манай улсад төдийлөн сайнгүй байгаа нь холбогдох статистик үзүүлэлтээс тодорхой харагддаг. Үндэсний статистик мэдээнээс харахад улсын хэмжээнд сүүлийн жилүүдэд зам тээврийн ослын тоо буурсан үзүүлэлттэй (2018 онд 29,474, 2022 онд 24,121)¹⁰⁵ байгаа хэдий ч энэ нь бусад улс, оронтой харьцуулахад хангалттай биш юм.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах, зам тээврийн ослын тоог бууруулахад нийгмийн түвшинд оролцогч талууд, тэр дундаа нутгийн захиргааны байгууллагын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

Иймд, энэхүү сэдвээр судалгаа хийж асуудлыг олон талаас задлан шинжилж, шинэлэг санал санаачилга гаргахаар зорив. Тус зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно. Үүнд:

1. Өнгөрсөн хугацаанд зам тээврийн ослыг багасгах чиглэлээр төрөөс авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээ болон өнөөгийн нөхцөл байдлын талаар баримт материал судлах;
2. Судалгаа шинжилгээний дүнд дүгнэлт хийх, бусад орны туршлагатай харьцуулах;
3. Дүн шинжилгээнд үндэслэн санал, санаачилга дэвшүүлэх зэрэг болно.

Abstract. Today, technology is developing at a rapid pace, and as a result, human beings are becoming dependent on technology and managing their daily life with the help of technical tools. At the same time, every family owns and uses a vehicle to make a living. Year by year, the number of cars imported and coming through the border of Mongolia is increasing, and the road traffic is increasing, which is felt in our daily life.

It is clear from the relevant statistics that road traffic safety is not very good in our country. According to national statistics, the number of road traffic accidents has decreased in recent years (29,474 in 2018 and 24,121 in 2022), but this is not enough compared to other countries.

In order to improve road traffic safety and reduce the number of road traffic accidents, it is necessary to improve the cooperation and coordination of stakeholders at the social level, including local administrative organizations. Therefore, by conducting research on the topic, we analyzed the problem from different angles and tried to come up with innovative ideas. To achieve this goal, the following objectives have been proposed.

¹⁰⁵ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn, Цагдаагийн ерөнхий газрын тээврийн цагдаагийн алба

1. Studying documents and materials about the policies and measures implemented by the government in the past to reduce traffic accidents and the current situation;
2. Make a conclusion on the results of research and analysis and compare with the experience of other countries
3. Come up with proposals and initiatives based on the analysis.

Түлхүүр үг. Нутгийн захиргааны байгууллага, Зам тээврийн осол, замын хөдөлгөөний аюулгүй байдал.

Key words. Local administrative bodies, Road traffic accidents and traffic safety.

Үндсэн хэсэг. Зам тээврийн ослыг багасгах чиглэлээр төрөөс авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээ ба өнөөгийн нөхцөл байдал / Government policies and actions in reducing road accidents and the current situation

Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр дэлхий нийтийн өмнөө тавьсан зорилт, зарим улсын¹⁰⁶ туршлагаас үзвэл урьдчилан сэргийлэх ажлын үр дүн нь ослын гаралтын өсөлт, бууралтаас илүү ослын шалтгаанаар нас барсан, гэмтсэн хүний тоог бууруулсан эсэх нь хамгийн гол үзүүлэлт болж байна. Түүнчлэн зам тээврийн ослыг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах явдал нь зөвхөн цагдаагийн байгууллагын үүрэг биш бөгөөд авто тээвэр, эрүүл мэнд, хот төлөвлөлт, орон нутгийн захиргаа, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн өргөн оролцоог хангасан хамтын үйл ажиллагааны үр дүн болохыг Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейн 2010 оны 64/255 дугаар тогтоолоор баталсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөр”-т онцолсон байдаг.

Зам тээврийн ослыг зохицуулах хууль дүрмийн хувьд “Замын Хөдөлгөөний Аюулгүй байдлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга 2015 онд батлагдсан байдаг. Тус хуулиар зам тээврийн осол гэж юу болох хийгээд төрийн дээд байгууллагаас эхлээд шат, шатны төрийн байгууллагууд болон иргэд, аж ахуй нэгжүүдийн эрх үүргийг тодорхойлсон. Хуулийн 3.1.6-д зааснаар “Зам тээврийн осол” гэж зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг хэлнэ гэж тодорхойлсон.

Харин зам тээврийн осолтой холбоотойгоор төрөөс авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээний хувьд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийг 1993-2008 онуудад 3 удаа батлан, үйл ажиллагааны төлөвлөгөөг 95-98 хувьтай хэрэгжүүлсэн, 2012 онд “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах стратеги”-ийг батлан хэрэгжүүлсэн нь 2017 онд төлөвлөгөөний биелэлт 72 хувьтай гэж дүгнэгдсэн¹⁰⁷ байна. Харин 2017 оноос хойш “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах стратеги”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах” Техникийн туслалцаа /ТТ/-ний төслийг Азийн Хөгжлийн Банкны техник туслалцаагаар бусад өндөр хөгжилтэй орнуудад ашигладаг ослын шалтгаан нөхцөлийг иж бүрэн тодорхойлох программ хангамж нэвтрүүлэх, сургалт зохион байгуулах, замын хөдөлгөөнд хяналт тавих пост байгуулах, тоног төхөөрөмж хүлээлгэн өгөх зэрэг ажлууд хийгджээ.

Сүүлийн таван жилийн статистик мэдээнээс¹⁰⁸ харахад зам тээврийн ослын тоо улсын хэмжээнд буурч байгаа нь дээрх төсөл хөтөлбөр, бодлого арга хэмжээний үр дүн гэж дүгнэгдэж байна.

Хүснэгт 1: Зам тээврийн осол, улсын дүн 2017-2022

¹⁰⁶ Швед Улсын “Алсын хараа-Тэг” стратегийн хөтөлбөр

¹⁰⁷ Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ТА-9137 МОН төслийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл Зам, тээврийн хөгжлийн яам <https://mrtd.gov.mn/p/77>

¹⁰⁸ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn

Он	2017	2018	2019	2020	2021	2022
Тоо	36,591	29,474	25,302	21,768	22,482	24,121

Харин сүүлийн жилүүдэд төрөөс хэрэгжүүлсэн бодлого, зохицуулалтын хувьд Замын хөдөлгөөний үндэсний зөвлөл 2019 оны 01 дүгээр тогтоолоор Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр /2019-2023/-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Төлөвлөгөөнд аймаг, нийслэлийн Засаг дарга нарын шууд хариуцах болон хамтран хэрэгжүүлэх 25 арга хэмжээг дараах байдлаар тусгасан байна. Эдгээрээс 5 арга хэмжээг шууд хариуцахаар бусад 20 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 2: Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Арга хэмжээ	Хариуцах нэгж	Хамтран хэрэгжүүлэх
1	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо зааврыг хэрэглэх хэрэгцээ шаардлага MNS ISO 39001:2014 стандартыг хэрэгжүүлнэ.	ЗТХЯ	Аймаг нийслэлийн Засаг дарга нар
2	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөн зохион байгуулах сургалтыг байгууллагын удирдлага, мэргэжилтэн, судлаач, хэрэглэгч нарын төвшинд жилд 3-аас доошгүй удаа сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.	ЗТХЯ ХЗДХЯ ЭМЯ	Аймаг нийслэлийн Засаг дарга нар
3	Тээврийн цагдаа, автотээврийн улсын байцаагч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч нарт эрх зүйн мэдлэг олгохоос гадна ёс зүйн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.	МХЕГ ЦЕГ АТҮТ	Аймаг нийслэлийн Засаг дарга нар
4	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах баруун, төвийн, хангайн, зүүн бүс, орон нутгийн хэмжээнд аймаг тус бүр үндсэн хөтөлбөр, судалгаа шинжилгээнд суурилсан дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлнэ.	Үндэсний зөвлөл	ЗТХЯ ХЗДХЯ ЭМЯ Аймаг нийслэлийн Засаг дарга нар
5	Гудамж замын хөдөлгөөний сүлжээг төлөвлөх, шинэчлэхдээ “Аюултай нь бага, аюулгүй нь их” гэсэн олон улсын зарчмыг баримталж, явган зорчигч замын хөдөлгөөнд оролцох таатай нөхцөлийг бүрдүүлнэ. Сургууль, цэцэрлэгийн орчинг хөдөлгөөний эрчим ихтэй авто замаас тусгаарлах, хөдөлгөөнд оролцогчийн аюулгүй оролцох шилдэг модель, тэргүүний арга хэрэгслийг ашиглах	ЗТХЯ БХБЯ	ХЗДХЯ ЭМЯ Аймаг Нийслэлийн Засаг дарга нар
6	Суурин газрын автозамын дагуу явган зорчигч, унадаг дугуйн хөдөлгөөнийг автомашины хөдөлгөөнөөс тусгаарласан зохион байгуулалтын шийдлийг бий болгоно.	ЗТХЯ	ЗТХТ Аймаг Нийслэлийн Засаг дарга нар
7	Зам, явган хүний гарцыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тоноглоно.	ЗТХЯ	ЗТХТ Аймаг Нийслэлийн Засаг дарга нар
8	Бусад тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөнөөс тусгаарласан унадаг дугуйн замын уртыг нэмэгдүүлнэ.	Аймаг Нийслэлийн Засаг дарга нар	БХБЯ
9	Явган хүний гарам, гарцыг тооцоо, судалгааны үндсэн дээр цогц байдлаар шийдвэрлэх, явган хүний гарцыг шилдэг техник технологи, инновацын арга хэрэглэн тоноглох, шөнийн харанхуй үед замын бусад хэсгээс илт ялгарах техникийн шийдлийг бий болгох, холбогдох стандартыг шинэчлэн хэрэгжүүлнэ.	БХБЯ ЗТХЯ	Аймаг Нийслэлийн Засаг дарга нар
10	Хүүхдүүдийн дунд уламжлал болгон зохион байгуулдаг “Ногоон гэрэл, цагаан шугам”, “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээнээс гадна хүүхдийн аюулгүй байдлыг хангахтай холбогдох төрөл бүрийн уралдаан тэмцээнийг зохион байгуулна.	БСПУСЯ Аймаг Нийслэлийн Засаг дарга нар	ЗТХЯ ХЗДХЯ
11	Ерөнхий боловсролын сургуулийн сурагч бага наснаасаа Замын хөдөлгөөний дүрэм үзэж, жолоодлогын дадлага хийж,	Аймаг Нийслэлийн	ЗТХЯ ХЗДХЯ

	18 нас хүрэхдээ жолоочийн шалгалт өгдөг байх нөхцөл бүрдүүлэх	Засаг дарга нар	БСШУСЯ
12	Сургуулийн бүс. Техникийн шаардлага MNS 6444:2014 стандартыг улсын хэмжээний нийт сургуульд хэрэгжүүлэх арга хэмжээ авна.	БСШУСЯ МХЕГ	ЗТХЯ Аймаг Нийслэлийн Засаг дарга нар
13	Олон улс, улс хооронд, орон нутгийн авто замын дагуу түр зогсох талбайг 50 км тутамд, амрах талбай, үйлчилгээний цогцолборыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, эрэлт хэрэгцээнд тулгуурлан барьж байгуулна.	ЗТХЯ	ХХААХҮЯ БОАЖЯ Аймгийн Засаг дарга нар
14	Зам тээврийн ослын үед эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, байрлал тогтоох техникийн шийдэл, журам боловсруулан хэрэгжүүлэх, ингэхдээ орчин үеийн интернет, үүрийн телефон, Сансарын холбооны сүлжээ ашиглахаас гадна олон улсын чанартай авто замын сүлжээний дагуу яаралтай тусламжийн утсан сүлжээ бий болгоно.	ЗТХЯ	ЭМЯ Аймгийн Засаг дарга нар
15	Зам тээврийн ослын үед эмнэлгийн яаралтай тусламжийг автомашинаар саадгүй үзүүлэх тогтолцоог бүрдүүлэхээс гадна ноцтой, хүнд гэмтлийн үед нисдэг тэрэг, бага оврын агаарын хөлөг ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.	ЗТХЯ	ЭМЯ Аймгийн Засаг дарга нар
16	Автотээврийн тухай хууль болон татварын холбогдох хууль тогтоомж, хөдөлгөөн зохицуулах менежментийг хэрэгжүүлэх замаар 6-аас дээш жил ашигласан болон баруун талдаа жолооны хүрдтэй автомашины хөдөлгөөнийг үе шаттай хязгаарлана.	СЯ ЗТХЯ ХЗДХЯ	Нийслэл, аймгийн Засаг дарга нар
17	Шинээр хорооллыг төлөвлөхдөө сургууль, цэцэрлэгийг төвд нь байхаар, хөдөлгөөний эрчим ихтэй замаас тусгаарлах, хөдөлгөөнд оролцогчийн аюулгүй оролцох шилдэг модель, удирдлага, мэдрэгч тэргүүний арга хэрэгслийг ашиглана.	БХБЯ	Нийслэл, аймгийн Засаг дарга нар
18	Тээврийн ухаалаг системд суурилсан эрэлтийн удирдлагын системийг бий болгоно.	ЗТХЯ	Нийслэл, аймгийн Засаг дарга нар
19	Тээврийн ухаалаг системд суурилсан замын хөдөлгөөний удирдлагын төвийг Нийслэл, орон нутагт шинээр байгуулна.	ХЗДХЯ Нийслэл, аймгийн Засаг дарга нар	ЗТХЯ ЭМЯ
20	Тээврийн хэрэгслийн даац хэтрэлтийг хянаж, зохицуулах систем нэвтрүүлнэ.	ЗТХЯ	ХЗДХЯ Нийслэл, аймгийн Засаг дарга нар МХЕГ
21	Тээврийн хэрэгслийн зогсолт, зогсоолыг хянаж, зохицуулах систем нэвтрүүлнэ.	ЗТХЯ	ХЗДХЯ Нийслэл, аймгийн Засаг дарга нар МХЕГ
22	Улсын чанартай замд тээврийн хэрэгслийн хурдыг хянах хяналтын камер систем ашиглана.	ЗТХЯ	ХЗДХЯ Нийслэл, аймгийн Засаг дарга нар
23	Иргэдийн оролцоотой замын хөдөлгөөний хяналтыг хэрэгжүүлнэ.	ЗТХЯ	ЦЕГ Нийслэл, аймгийн Засаг дарга нар
24	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөний удирдлагын систем, ашиглах камер, тоног төхөөрөмжийн стандартыг бий болгож ашиглана.	ЗТХЯ ХЗДХЯ	Нийслэл, аймгийн Засаг дарга нар
25	Гудамж замын хөдөлгөөний сүлжээг төлөвлөх, шинэчлэхдээ олон улсын жишиг аргачлал ашиглан, судалгаа тооцоо хийж, гэр хорооллын дундах замыг явган хүн зорчих аюулгүй байдлыг хангахаас гадна, гэмт халдлагаас хамгаалах, ая тухтай нөхцөлийг бүрдүүлнэ.	БХБЯ Нийслэл, аймгийн Засаг дарга нар	ЗТХЯ ХЗДХЯ

Хөтөлбөрийн 7.1-д зааснаар аймаг, нийслэлийн Засаг дарга төлөвлөгөөнд шууд хариуцахаар заасан дараах 5 арга хэмжээний хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ гэж тусгажээ.

Хүснэгт 3: Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Арга хэмжээ	Хариуцах нэгж	Хамтран хэрэгжүүлэх
1	Бусад тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөнөөс тусгаарласан унадаг дугуйн замын уртыг нэмэгдүүлнэ.	Аймаг нийслэлийн Засаг дарга нар	БХБЯ
2	Хүүхдүүдийн дунд уламжлал болгон зохион байгуулдаг “Ногоон гэрэл, цагаан шугам”, “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээнээс гадна хүүхдийн аюулгүй байдлыг хангахтай холбогдох төрөл бүрийн уралдаан тэмцээнийг зохион байгуулна.	БСШУСЯ Аймаг нийслэлийн Засаг дарга нар	ЗТХЯ ХЗДХЯ
3	Ерөнхий боловсролын сургуулийн сурагч бага наснаасаа Замын хөдөлгөөний дүрэм үзэж, жолоодлогын дадлага хийж, 18 нас хүрэхдээ жолоочийн шалгалт өгдөг байх нөхцөл бүрдүүлэх	Аймаг нийслэлийн Засаг дарга нар	ЗТХЯ ХЗДХЯ БСШУСЯ
4	Тээврийн ухаалаг системд суурилсан замын хөдөлгөөний удирдлагын төвийг нийслэл, орон нутагт шинээр байгуулна.	ХЗДХЯ Нийслэл, аймгийн Засаг дарга нар	ЗТХЯ ЭМЯ
5	Гудамж замын хөдөлгөөний сүлжээг төлөвлөх, шинэчлэхдээ олон улсын жишиг аргачлал ашиглан, судалгаа тооцоо хийж, гэр хорооллын дундах замыг явган хүн зорчих аюулгүй байдлыг хангахаас гадна, гэмт халдлагаас хамгаалах, ая тухтай нөхцөлийг бүрдүүлнэ.	БХБЯ Нийслэл, аймгийн Засаг дарга нар	ЗТХЯ ХЗДХЯ

Аймаг, нийслэлийн Засаг дарга буюу нутгийн захиргааны байгууллагын үүрэг, оролцоог дурдсан таван арга хэмжээгээр хязгаарлахгүй бөгөөд холбогдох хуулиудаар тодорхойлсон эрх, үүргээс гадна бусад хөтөлбөр, бодлогын бичиг баримтуудаар үүрэг чиглэл болгосон үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлэх нь чухал юм.

Түүнчлэн өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд олон тооны бодлого, стратеги боловсруулж арга хэмжээ, аян, үндэсний хөтөлбөр зэргийг хэрэгжүүлж тодорхой үр дүн гаргасан хэдий ч өнөөгийн нөхцөл байдал төдийлөн сайжраагүйг бид бодит байдлаас өдөр тутам харж болохоор байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр зэрэгт нутгийн захиргааны байгууллагын үүрэг оролцоог тодорхой тусгасан боловч бодит байдалд хамгийн наад захын асуудал болох иргэдэд аюулгүй, явган болон дугуйтай зорчих боломж нөхцөлийг хангасан дэд бүтэц дутагдаж байна. Замын хөдөлгөөн гэдэг нь автомашинд түлхүү анхаарах бус нийт хөдөлгөөнийг /mobility/ хамарсан цогц ойлголт гэдгийг нутгийн захиргааны байгууллага үйл ажиллагаандаа тусгах зүйн шаардлага байна. Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнууд иргэд аюулгүй замаар зорчих боломжийг өргөн утгаар нь ойлгож, ажил хэрэг болгодог талаар дараагийн хэсэгт авч үзэх болно.


Дэлхийн бусад улс орнуудын туршлага

Үндэстэн дамнасан байгууллагуудын хийсэн судалгаанаас харахад дэлхийн хэмжээнд зам тээврийн ослоор тэргүүлж буй орнууд ихэвчлэн ядуу буурай орнууд байна¹⁰⁹. Нийт 183 улсаас Монгол улс эрсдэл өндөртэй орнуудын дунд буюу 68-т орсон бол өндөр хөгжилтэй орнууд хамгийн эрсдэл багатайд тооцогдсон байна. Мөн Европын Холбооны орнуудын дунд хийсэн нэгэн судалгаагаар 2010-2020 онуудад зам тээврийн ослоос болж нас барсан хүний тоо тогтмол буурсан үзүүлэлттэй гарсан байна¹¹⁰.

¹⁰⁹ <https://www.worldlifeexpectancy.com/cause-of-death/road-traffic-accidents/by-country/>

¹¹⁰ https://ec.europa.eu/eurostat/statistics-explained/index.php?title=Road_accident_fatalities_-_statistics_by_type_of_vehicle

График 1. 2010-2020 онд зам тээврийн ослоос нас барсан хүний тоо, Европын Холбооны Орнууд



Европын Холбооны орнуудын автозамууд дэлхийн хамгийн аюулгүй замууд гэж тооцогддог бөгөөд 1 сая хүнд ногдох зам тээврийн ослоор амиа алдсан тохиолдлын тоо Европын Холбооны гишүүн орнуудад 50, харин дэлхийн дундаж үзүүлэлт 174 байдаг байна.

Бусад улс орны туршлагыг Монгол улстай харьцуулан үзэхэд нэн тэргүүнд дэд бүтэц, иргэд олон нийтийн ухамсартай байдал, хууль дүрмийн хэрэгжилт зэрэг голлох үзүүлэлтүүдээс гадна нутгийн захиргааны байгууллагын үүрэг оролцооны ялгаатай байдал харагдаж байна. Тодруулбал, Монгол улсад Зам тээврийн хөгжлийн яам, Зам тээврийн хөгжлийн төв, Нийслэлийн замын хөгжлийн газар гэх мэт төрийн дээд шатны байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, хэрэгжүүлэгч агентлаг зэрэг нутгийн захиргааны байгууллагууд байна. Харин Европын орнуудад зам тээврийг дангаар нь бус нийт “хөдөлгөөн” гэдгээр нь авч үздэг байна. Замын хөдөлгөөн гэдэгт зөвхөн авто зам голлох байр суурь эзлэх бус явган болон дугуйн замууд адил чухал байр суурь эзэлдэг байна.



Зураг 4.5. Дугуйн зам, Европын Орнууд



Өөрөөр хэлбэл зам тээврийн хөгжил хийгээд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхэд Монгол улсад дутагдаж байгаа гол хүчин зүйлүүдийн нэг нь явган болон дугуйт зорчигчдын хөдөлгөөнийг чухалчлан авч үзэх явдал буюу хөдөлгөөнийг цогцоор нь авч үзэх шаардлагатай байна. Дээр дурдсан төрийн байгууллагууд нэршлээсээ эхлээд үйл ажиллагааны чиг үүрэг нь гол төлөв зам тээвэрт чиглэсэн байгаа нь явган зорчигчдыг тодорхой хэмжээгээр орхигдуулсныг илтгэж байна. Үүний нэг тод жишээ нь 2020 онд нийслэл Улаанбаатар хотод шинээр баригдаж ашиглалтад орсон “Замын цагдаагийн гүүр” юм. Тус гүүр нь хотын төв хэсэгт, хамгийн ачаалал ихтэй бүсүүдийн нэгт байрладаг. Гэвч гүүрний хажуугаар дугуйт зорчигч бүү хэл явган зорчигч явах зам байдаггүй. Олон улсын жишгээр хотын төвийн ачаалалтай замуудад дугуйт болон явган зорчигчийн замыг зайлшгүй багтаадаг. Энэ жишгээр нийслэлийн иргэд явган замгүй гүүрээр эрүүл мэнд, амь насаа эрсдэлд оруулан зорчсоор байсан тул 2022 онд тус гүүрний дагуу налуу явган хүний зам барих ажил эхэлсэн.

Энэ мэт явган болон дугуйтай зорчигчдыг чөлөөтэй, аюулгүй зорчих орчин, замаар хангаагүй нөхцөл байдлаас болж жил бүр олон зуун хүн хохирсоор байна. Зам тээврийн осол хамгийн их болдог нийслэл хотод явган зорчигчдын аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Дүгнэлт. Хэдийгээр зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, тохиолдлыг багасгах хууль эрх зүйн орчин бүрэлдэж, холбогдох арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийг сүүлийн 20 жилийн хугацаанд хэрэгжүүлж ирсэн хэдий ч эл асуудал өдгөө ч ноцтой хэвээр байна. Асуудлыг шийдэхэд олон талуудын үүрэг оролцоо, идэвх чармайлт чухал байдаг. Дэлхийн бусад улс оронд ч мөн адил олон талт хамтын ажиллагаагаар зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, ослын тоог багасгадаг туршлагатай.

Монгол улсын хувьд нутгийн захиргааны байгууллагуудын үүрэг оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах боломжуудын нэг нь явган зорчигчдын аюулгүй байдлыг хангах чиг үүргийг удирдлага болгон хэрэгжүүлэх явдал байж болох юм. Өөрөө хэлбэл яам, агентлагаас эхлээд төрийн өмчит үйлдвэрийн газар, Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал гээд бүхий л нутгийн захиргааны байгууллагууд авто замын асуудлыг хариуцахдаа явган зорчигчдын асуудлыг хамтад нь анхаарч ажиллах хэрэгтэй гэсэн үг юм. Түүнчлэн, нутгийн захиргааны эрх бүхий байгууллагууд хувийн аж ахуй нэгжтэй хамтран ажиллаж, төрийн зарим чиг үүргийг хувьд шилжүүлэх ажлууд хийж болох юм. Ингэснээр нутгийн захиргааны байгууллагын ачаалал багасаж, илүү үр дүнтэй ажиллана. Жишээлбэл,

Багануур дүүргийн иргэд техникийн үзлэгт орохын тулд өмнө нь заавал Улаанбаатар хотыг зорих шаардлагатай байсан бөгөөд зарим тохиолдолд иргэд тээврийн хэрэгслээ үзлэгт оруулахаас цааргалж, техникийн шаардлага хангаагүй тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд орох тохиолдол гардаг байв. Харин сүүлийн жилүүдэд явуулын үзлэг оношилгоо тодорхой заасан хугацаагаар хийх байдлаар зохион байгуулж байна. Гэвч дээрх шийдлүүд аль аль нь иргэдэд болон төрийн байгууллагад хүндрэлтэй байсан тул 2022 оноос эхлэн тус дүүрэгт хувийн аж ахуй нэгж төрийн байгууллагаас зөвшөөрөл авч, техникийн үзлэгийг тогтмол хийхээр болсон юм. Энэ мэтчилэн асуудлыг шийдэхэд төр гол үүрэг хүлээх бус хувийн хэвшилтэй хамтран ажиллах нь илүү үр дүнтэй байдаг.

Ашигласан материалын жагсаалт

Хууль, тогтоомж:

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, 2015 он
- Авто замын тухай хууль, 2017 он
- Зөрчлийн тухай хууль, 2017 он

Цахим эх сурвалж:

- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан
- Зам тээврийн хөгжлийн яамны цахим хуудас
- Цагдаагийн ерөнхий газрын тээврийн цагдаагийн алба цахим хуудас

**ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГЫГ НЭВТРҮҮЛЭХ НЬ
PREVENTION OF TRAFFIC ACCIDENTS AND VIOLATIONS
BROADCASTING THE EXPERIENCES OF SOME FOREIGN COUNTRIES**

ДХИС-ийн магистрант,
цагдаагийн дэслэгч С.Эрдэнэбаяр
Graduate student of the
University of Internal Affairs,
police lieutenant S. Erdenebayar

Хураангуй. Дэлхийн олон улс оронд зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд маш олон төрлийн ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа боловч хүссэн үр дүнд төдийлөн хүрэхгүй байгаа нь байнга анхаарал татдаг билээ.

Энэхүү өгүүлэлд зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд гадаадын зарим орны туршлагыг авч үзэхийн өмнө Монгол Улс дахь замын хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал, гадаадын зарим орны нэвтрүүлж болох туршлагын талаар авч үзсэн болно.

Abstract. In many countries of the world, many types of work and measures are being implemented to prevent traffic accidents and violations, but the fact that they do not achieve the desired results is often attracting attention.

In this article, before considering the experience of some foreign countries in preventing traffic accidents and violations, the current situation of road safety in Mongolia and the experiences that can be introduced by some foreign countries are discussed.

Түлхүүр үг. Зам тээврийн осол, замын хөдөлгөөний аюулгүй байдал, урьдчилан сэргийлэлт

Key word. Traffic accidents, traffic road safety, preventive work

Үндсэн хэсэг. Замын хөдөлгөөний аюулгүй байдал нь энэ зууны дэлхий нийтийн тулгамдсан асуудал болоод байгаа учир энэхүү тулгамдсан асуудлын нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн өргөн хүрээний сөрөг үр дагаварыг багасгах арга хэмжээ аваагүй тохиолдолд улс орнуудын тогтвортой хөгжил, Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлөх эрсдэл бий болж байна.

Монгол Улс дахь замын хөдөлгөөний аюулгүй байдлын нөхцөл байдал. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудал дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө тулгамдсан асуудлын нэг болсон. Замын нөхцөл байдлыг аль болох замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар зохион байгуулсан гадаадын сайн туршлагаас судлан нутагшуулах шаардлагатай байна.

Монгол Улс дахь замын хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал. Монгол Улсад 1929 онд 20 автомашин замын хөдөлгөөнд оролцож байсан бол 93 жилийн дараа буюу 2022 онд 11278131 автомашин болон өсчээ. Монгол Улсад 2022 онд 1264542¹¹¹ тээврийн хэрэгсэл бүртгэгдсэний 1127813 буюу 89.0%-г автомашин эзэлж байна. Монгол улсын 1264542 тээврийн хэрэгслийн 711835 буюу 56.3% нь Улаанбаатар хотод бүртгэлтэй байна.

Монгол Улсад 2022 онд шинээр 34332 автомашин бүртгэгдсэн нь өнгөрсөн онд шинээр бүртгэгдсэн автомашинаас 4,8 %-иар буурчээ.

¹¹¹ Авто тээврийн үндэсний төвөөс 2022,12,31-ны байдлаар гаргасан үзүүлэлтээс авав.

Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн ашиглалтын /насжилт/ хугацааг 2022 оны байдлаар авч үзвэл: 0-3 жил ашиглагдаж буй автомашин 58465 буюу 4,6%, 4-6 жил болсон автомашин 44051 буюу 3.5%, 7-9 жил 117225 буюу 9,3%, 10 ба түүнээс дээш жил ашиглагдаж буй автомашины тоо 1044811 буюу 82.6 %-ийг тус тус эзэлж байна.

Тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаа /насжилт/-г өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулан авч үзвэл: ашиглалтын хугацаа багатай автомашин 0,8%, ашиглалтын хугацаа ихтэй 10 ба түүнээс дээш жил ашиглаж буй автомашин 1,4%-р тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Монгол Улсад бүртгэлтэй 1127813 автомашины 451107 буюу 40,0% нь зүүн талдаа, 676706 буюу 60,0% нь баруун талдаа жолооны хүрдний байрлалтай автомашин байна.

Улаанбаатарт буруу буюу баруун талдаа жолооны хүрдтэй 433305 автомашин замын хөдөлгөөнд оролцож байгаа нь нийслэлд бүртгэлтэй автомашины 66,3%-г эзэлж байна.¹¹²

Улсын хэмжээнд 2022 онд зам тээврийн ослын шинжтэй 101233 дуудлага хүлээн авч 24121 зам тээврийн осол бүртгэн шалгасан байна. Тухайн онд тээврийн хэрэгсэл, автомашины өсөлт 2,4%-иар өсч зам тээврийн ослын шинжтэй дуудлага 21973(27,7 %), бүртгэгдсэн зам тээврийн осол 1639 (7,3 %)-аар тус тус өсөв.

“Зам тээврийн осол” - зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг¹¹³; -ыг хэлнэ.

Улсын хэмжээнд 2022 оны байдлаар 101233 дуудлага хүлээн авчээ. Хүлээн авсан дуудлага, мэдээллийн 95409 буюу 94,2%-ийг Улаанбаатарт, 5824 буюу 5,8%-г орон нутагт шийдвэрлэсэн байна.

Монгол улсын хэмжээнд 2022 онд 24121 зам тээврийн осол бүртгэгдсэний 20322 буюу 84,3 хувь нь Улаанбаатарт, 3799 буюу 15,7% нь орон нутагт бүртгэгджээ.

Улаанбаатарт бүртгэгдсэн зам тээврийн ослын 27,7% нь Баянзүрх дүүрэг, 19,2 % нь Сонгинохайрхан дүүрэг 16,7% нь Хан-Уул дүүрэг, 14,6% нь Баянгол дүүрэг, 14,3% нь Сүхбаатар дүүрэг, 6,2% нь Чингэлтэй дүүрэг, 1,2% нь алслагдсан 3 дүүргийн нутаг дэвсгэрт бүртгэгджээ.

Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 846(80.3%) эрэгтэй жолооч, 208(19,7%) эмэгтэй жолооч эзэлж байна. Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон хүний 385 буюу 36,5% нь тодорхой ажил эрхэлдэггүй буюу ажилгүй хүн байв. Өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулан үзвэл: Төрийн алба хаагч холбогдсон гэмт хэрэг 1,1%, хувиараар хөдөлмөр эрхлэгч 6,1%, хувийн хэвшлийн байгууллагад ажил эрхэлдэг хүн 1,2%-иар тус тус өсчээ.

Монгол Улсад 2022 онд зам тээврийн 24121 осолд 3418 өртөж хүн амь нас, эрүүл мэндээрээ хохирчээ. Зам тээврийн осолд өртөж, хохирсон 3418 хүний 539 буюу 15,8% нь амь насаа алдаж, 2879 буюу 84,2% нь гэмтэл, бэртэл авч эрүүл мэндээрээ хохирсон байна.

Амь нас, эрүүл мэндээрээ хохирсон 3418 хүний 1896 буюу 55,6% нь Улаанбаатарт, 1522 буюу 44,5% нь орон нутгийн замд бүртгэгдсэн осол байна. Зам тээврийн осолд өртөж хохирсон хүн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 19,6%-иар өсчээ. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 1220 гэмт хэргийн улмаас 1321 хүн хохирсоны 280(21,2%) нь амь насаа алдаж, 1041(78,8%) нь хүнд, хүндэвтэр гэмтэл авсан.

Монгол улсын хэмжээнд бүх төрлийн 35340 гэмт хэргийн улмаас 766 хүн нас барсан /амь насаа алдсан/ нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 12.2%-р өссөн. Гэмт хэргийн улмаас нас

¹¹² Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл. УБ. 2022. 12 дахь тал

¹¹³ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3.1.6 заалт. ЗХДүрмийн 1.2.17.

барсан 766 хүний 280 (36.6%) нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас амь насаа алджээ.

Монгол Улсад зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүн, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас амь насаа алдсан хүн гэсэн 2 тоон үзүүлэлт гарч үйл ажиллагаанд ашиглагдаж байна. Амь насаа алдсан хүний тоон үзүүлэлтийг: - Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүн - Гэмт хэргийн улмаас амь насаа алдсан хүн гэж ангилан авч үздэг.

Монгол Улсын хэмжээнд 2022 онд зам тээврийн 481 ослын улмаас 539 хүний амь нас хохирчээ. Амь насаа алдсан 539 хүний 453(84.0%) нь орон нутгийн замд, 86(16.0%) нь нийслэлд бүртгэгдсэн зам тээврийн осол байна.

Улсын хэмжээнд хүний амь нас хохирсон гэмт хэргийн 481 тохиолдол бүртгэгдэж 539 хүний амь нас хохирсон байна. Хүний амь нас хохирсон 136 гэмт хэргийг ЭХХШТХ-ийн холбогдох зүйл заалтаар хэргийг хэрэгсэхгүй болгосон мөн эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж зөрчлийн хэргээр шалгасан байх тул статистик /ЦЕГ-ын/ мэдээнд нас барсан хүн 280 гэсэн тоон үзүүлэлтээр тусгагдсан.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн бүх төрлийн гэмт хэргийн улмаас улсын хэмжээнд 10310 хүн гэмтсэний дотор 1041(10.1%) нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн статистик үзүүлэлт гарчээ.

Монгол улсад зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүн, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн гэсэн 2 тоон үзүүлэлт гарч үйл ажиллагаанд ашиглагддаг.

Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүн – зам тээврийн осолд өртөж их бага, тодорхой хэмжээгээр гэмтэл, бэртэл авсан /зөөлөн эдийн гэмтэл, шарх авсан, шалбарсан, зулгарсан гэх мэт/ хүнийг багтаасан тоон үзүүлэлт юм.

Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн – зам тээврийн ослын улмаас биед авсан гэмтлийн зэрэг нь шүүх эмнэлгийн магадлагаагаар хүндэвтэр, хүнд зэрэг тогтоогдон эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан хэргийн улмаас гэмтсэн хүний тоон үзүүлэлт юм.

Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас 2879 хүн гэмтсэн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 16,3%, хүнд, хүндэвтэр гэмтсэн хүн 17,6%-р тус тус өссөн.¹¹⁴

Өнөөдөр дэлхийн 100 гаруй улс оронд 2100 орчим загварын төрөл бүрийн суудлын автомашиныг жилдээ 40 гаруй сая ширхэгийг үйлдвэрлэн гаргаж хүмүүсийн хэрэгцээнд нийлүүлж байна.¹¹⁵

Энэ тоо нь зөвхөн суудлын автомашины үйлдвэрлэлтэй холбоотой бөгөөд автобус, ачааны машин, мотоцикл, механизмын тоо ороогүй юм.

Гадаадын зарим орны туршлага. Дэлхий нийтээр жил бүр 1.3 сая хүн зам тээврийн ослын улмаас нас барж байгаа буюу зам тээврийн ослын нас баралт 100.000 хүн амд 18 ногдож байна.¹¹⁶ Ийнхүү зам тээврийн ослын тоо улам бүр нэмэгдэж, ослоос үүдэлтэй хүний амь нас, эрүүл мэнд хохирох, эд материалын хохирол учрах явдал ихсэх хандлагатай байна.

ОХУ-н эрдэмтэн А.П.Матросов зам тээврийн ослын шалтгаан нөхцлийг нарийвчлан тогтоох зорилгоор 1971 онд хийсэн судалгаагаар замын нөхцөл нь гарсан ослын 70 хувьд нь ямар нэг байдлаар сөрөг нөлөө үзүүлсэн байжээ. Гэтэл тухайн үед албан ёсны тоо баримтаар энэ үзүүлэлт дөнгөж 4.7 хувьтай байв. Одоо энэ тоон үзүүлэлт 35 хувьд хүрсэн бөгөөд Замын цагдаагийн албаны алба хаагчдыг авто зам, замын байгууламж, тэмдэг,

¹¹⁴ Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл. Уб. 2022. 15-17 дахь тал

¹¹⁵ -http://www.who.int/roadsafety/ministerial_conference/declaration_en.pdf

¹¹⁶ Global Status Report on Safety 2013.Supporting a decade of action.Who, 2013

тэмдэглэгээнийн стандарт, норм, дүрмийн мэдлэгийг дээшлүүлэх үе шаттай сургалтад хамруулснаар зам тээврийн ослын шалтгаан нөхцлийг тал бүрээс нь шалгаж бодитой тогтоох чадвар эзэмшүүлж дээрх үр дүнд хүрчээ.

АНУ, Канад улсуудад автозамын аюулгүй байдлын үзүүлэлт жилд 2 удаа AASHTO /American Association of State Highway and Transportation Officials/ байгууллага аудит хийж байна. Энэхүү үйл ажиллагааны талаарх тайланг тээврийн яаманд хүлээлгэж өгдөг бөгөөд замын аюулгүй байдлын үзүүлэлт, зам засварлах, техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлын гүйцэтгэлээр нь холбогдох төсөв санхүүг олгодог тогтолцоотой байна.

Мөн авто замыг төлөвлөх, төсөллөх, барих, ашиглах, засвар үйлчилгээ хийх бүхий л шатанд хүний нөөц, техник тоног төхөөрөмж, тухайн замд орох материал, үйл ажиллагааны менежментийн аудит хийгдэж байна.

Аудит хийгдэхэд 2100 гаруй стандарт, удирдлагын гарын авлага ашиглаж байна. Зөвхөн автозамын материалд хяналт, аудит хийхэд нэг бүр нь 1000-2000 хуудас бүхий 214 боть гарын авлага хэрэглэж байна.¹¹⁷ Замын цагдаагийн алба замын хөдөлгөөнийг сахиулах товчоо, төмөр замын хөдөлгөөнийг сахиулах товчоо, ердийн хөсгийн хөдөлгөөнийг сахиулах товчоо, замын хөдөлгөөний ослыг хянан тогтоох товчоо, бодлого боловсруулах товчоо гэсэн бүтэцтэй үйл ажиллагаа явуулдаг байна.

Том хотууд ба хороо суурингуудад 16 товчоо ажилладаг. Эдгээр нь орон нутгийн замын хөдөлгөөний асуудлыг эрхэлдэг. Замын хөдөлгөөнийг зохицуулах 10 жилийн хугацаатай ерөнхий төлөвлөгөө гаргаж түүнийхээ хэрэгжилтийг ерөнхий сайд хариуцан ажилладаг байна.

Вьетнам Улс. Тус улсад гарч байгаа зам тээврийн ослыг өндөр хөгжилтэй улс орнуудынхтай харьцуулахад үхэлд хүргэж байгаа осол харьцангуй бага хэмжээтэй байна. Ослыг үхэлд хүргэсэн ба гэмтээж бэртээсэн гэж ангилах бөгөөд үүнийгээ тухайн орны тээврийн хэрэгсэлд ноогдох тоотой харьцуулан авч үздэг байна.

Замын цагдаагийн алба нь Тээврийн газартай хамтран хөдөлгөөний аюулгүй байдлыг судлах, хөдөлгөөнийг шинж чанараар нь ангилах, өдрийн цагаар хүнд даацын болон овор ихтэй ачааны автомашины хөдөлгөөнийг хязгаарлах зэргээр зохицуулалт хийж байгаагаа зөв ажиллагаа гэж үздэг. Улсын хэмжээний 3 их замын 50 км тутамд замын цагдаагийн эргүүлийн 1 машин 24 цагийн туршид эргүүл хийж ажилладаг байна. Харин эргүүлийн цагдаа нь манай улсынхтай адил зөрчил илрүүлэн арга хэмжээ авах үүрэг хүлээдэг.

Хурд хэтрүүлэх, дураараа авирлах мэтийн зөрчил гаргагчдын хөдөлгөөнд оролцох эрхийг 15-30 хоног хасч, мөн торгууль оногдуулдаг байна. Энэхүү арга хэмжээг 2003 оноос хэрэгжүүлж эхлээд 8 сар болоход замын хөдөлгөөний дүрэм зөрчих явдал эрс багасч шийдвэр гаргахад хялбар болсон юм. Зам тээврийн ослыг хөнгөн, хүнд, үхэлд хүргэсэн гэсэн 3 төрлөөр судлан авч үздэг байна.

Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх явцад хотын замыг өргөтгөн зохион байгуулж, хувийн тээврийн хэрэгслээр хүн тээвэрлэх асуудлыг хязгаарласан нь хөдөлгөөний эмх цэгц, аюулгүй байдлыг хангахад ихээхэн үр дүнтэй болсон гэж үздэг юм байна.

Зам төлөвлөх, төсөллөх, барих, ашиглах, засвар үйлчилгээний шатанд Европын ISO стандарт, үйл ажилагаанд АНУ-ын AASTO стандарт хэрэглэж байна.

Япон улс. Тус улсын 4 хүний нэг нь автомашин жолооддог гэсэн тооцоо байдаг бөгөөд ослын тоо хэмжээг багасгах, замын нөхцөл байдлыг хурдан хугацаанд хэвийн байдалд оруулахын тулд цагдаагийн байгууллага үзлэг, шалгалтдаа хамгийн үр дүнтэй арга барил нэвтрүүлэхийг зорьдог.¹¹⁸ Зарим ялимгүй ослын үзлэгийг газар дээр нь хийдэг ажээ. Ослын үзлэг хийх, ашиглах тоног төхөөрөмж, үзлэг хийх дараалал, гэмт хэргийн ул мөр

¹¹⁷ American Association of State Highway and Transportation Officials 2007

¹¹⁸ [3https://ru.wikipedia.org/wiki/japan](https://ru.wikipedia.org/wiki/japan)

бэхжүүлэх зэрэг асуудлыг стандартаар тогтоохоос гадна алба хаагч өөрийн мэдлэг, ур чадвараа нэмэгдэл байдлаар ашиглахыг зөвшөөрдөг байна.

Замын цагдаа гэрлэн дохионы телеметр болон диаграмм зурах төхөөрөмжөөс бүрдсэн хагас автоматчилагдсан үзлэгийн төхөөрөмжийг хэрэглэж, ослыг шинжлэх ухааны үүднээс үр дүнтэй шалгахын тулд автоматаар илрүүлэн бичиж авдаг видео камерыг замын уулзваруудад байрлуулсан байдаг. ЗТО-ыг автоматаар санах төхөөрөмж нь хүлээн авах хэсэг /видео камер микрофонтой/, үндсэн хэсэг, дуу чимээ илрүүлэгч, дүрсний санах байгууламж, YTR г.м-ээс бүрдэнэ. Уулзвар дээр осол гарсан тохиолдолд ТААМ-5 нь мөргөлдөөний юмуу, шарвах дууг илрүүлэн ослыг автоматаар бичиж авдаг байна.

Ингэснээр YTR-т бичигдсэн бичлэгийг үндэслэн цагдаагийн ажилтан ослын байдлыг хурдан хугацаанд тодорхойлох боломж олгодог юм.

Замын хөдөлгөөний хууль, дүрэм зөрчиж хууль бус газар автомашин байрлуулсан үед голдуу хэрэглэдэг арга хэмжээ нь автомашиныг чирэгчээр чирэх, зогсоох төхөөрөмж /дугуй цоожлох гутал/ хэрэглэдэг байна. Хэрэв ажил олгогч ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй бол тээврийн хэрэгсэл ашиглах эрхийг хязгаарлахаас гадна, тээврийн асуудал эрхэлсэн ажилтан, жолооч хоёрт захиргааны арга хэмжээ ногдуулдаг.

Замын хөдөлгөөнийг хянах дэвшилтэт систем, боловсронгуй дохиолол, орчин үеийн техник технологийн ололт зэрэгт тулгуурлан аюулгүй, жигд, саадгүй замын хөдөлгөөний орчныг бүрдүүлнэ гэж үздэг байна.

АНУ. Тус улсын Үндэсний Замын хөдөлгөөний аюулгүй байдлын алба (NHTSA)-наас замын хөдөлгөөнд оролцож байгаа явган зорчигч нарт зориулан аюулгүй байдлын 8 зөвлөмжийг гаргасан байна. Алхах аюулгүй байдлын 8 зөвлөмж:

1. Замын хөдөлгөөний дүрмийг дагаж, тэмдэг, дохиог дагаж мөрдөөрэй.
2. Боломжтой үед явган хүний замаар яв.
3. Явган хүний замгүй бол замын хөдөлгөөнд харан, замын хөдөлгөөнөөс аль болох хол яв.
4. Явган хүний гарц эсвэл уулзвар дээр гудамжаар хөндлөн гарах. Зүүн эсвэл баруун тийш эргэх зэрэг бүх чиглэлд машин хайх.
5. Явган хүний гарц, уулзвар байхгүй бол гэрэлтүүлэг сайтай, замын хөдөлгөөнийг хамгийн сайн харах боломжтой газар байрлуул. /Аюулгүй хөндлөн гарахад хангалттай хугацаа өгөх замын хөдөлгөөний цоорхойг хүлээх; хөндлөн гарахдаа замын хөдөлгөөнийг үргэлжлүүлэн ажиглаарай/
6. Автомашины зам руу орох, гарах эсвэл зогсоол дээр нөөцөлж байгаа машинуудыг ажиглаарай.
7. Явган явахдаа архи, мансууруулах бодис хэрэглэхээс зайлсхийх; тэд таны чадвар, шүүлтийг муутгадаг.
8. Явган явахыг эрүүл тээврийн хэрэгсэл болгон хүлээн зөвшөөр - бос, гарч, хөдөл зэрэг зөвлөмжүүдийг гаргасан байна.

АНУ-ын Үндэсний Замын хөдөлгөөний аюулгүй байдлын алба нь явган зорчигч нарт зориулсан гарын авлага, самбар гаргаж, явган хүний гарц, түүний ойролцоо газруудад байршуулсан нь зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэхэд ихээхэн тус дөхөм үзүүлсэн байна.

Бага сургуулийн хүүхдүүд маш идэвхтэй, хөдөлгөөнтэй байдаг. Хэдийгээр тэд сурч, өсч байгаа ч 10 ба түүнээс доош насны сургуулийн насны хүүхдүүдэд замын хөдөлгөөний ойролцоо тоглож, алхаж байхдаа заавар, хяналт шаардлагатай хэвээр байдаг байна.

Тиймээс Үндэсний Замын хөдөлгөөний аюулгүй байдлын албанаас хүүхдүүдээ сургууль руугаа буцах замдаа аюулгүй байлгах таван зөвлөмж боловсруулж гаргажээ. Энэхүү зөвлөмжийн агуулга нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх мэдлэгээ

бататгах, хүүхдэдээ явган зорчигчийн аюулгүй байдлын дадлыг зааж, бататгах зорилготой гаргасан зөвлөмж юм байна.

Тээврийн болон хөдөлгөөнт байдлын хүртээмжийг үнэлэх хяналтын хуудас¹¹⁹

Транзит замын хүртээмж, түүний дотор аяллын замыг (Улаан өндөгний баярын тамганаас) үнэлэхийн тулд хяналтын хуудсыг ашиглах танилцуулга ба заавар.

Easter Seals Project ACTION (ESPA) нь АНУ-ын Тээврийн яам, Холбооны Транзит Захиргаатай хамтран ажиллах гэрээгээр санхүүждэг бөгөөд Easter Seals, Inc.-ээс удирддаг. Энэхүү мэдээллийг ESPA мэдээлэл солилцох зорилгоор түгээдэг. Улаан өндөгний баярын тамга болон АНУ-ын DOT, FTA аль аль нь түүний агуулга, ашиглалтын төлөө хариуцлага хүлээдэггүй.

Хүүхдийн явган зорчигчийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр

Цэцэрлэгийн 5-р ангиас эхлэн хүүхдүүдэд явган зорчигчийн аюулгүй байдлыг сургах, дэмжих зорилгоор хичээлийн төлөвлөгөө, үнэлгээний гарын авлага, сурагчдын хариу арга хэмжээний талаар тусгасан байна.

Хүүхдийн явган зорчигчийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр нь цэцэрлэгийн 5-р ангийн сурагчдад явган зорчигчийн аюулгүй байдлыг сургаж, сургадаг. Хөдөлгөөний ойролцоо алхах, гудамжаар гарах, уулзвар гарцаар гарах, зогсоолын аюулгүй байдал, сургуулийн автобусны аюулгүй байдал гэсэн таван хичээлээр зохион байгуулдаг. Хичээл бүр өмнөх олж авсан ур чадвар дээр тулгуурладаг.¹²⁰

Дүгнэлт. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам, Замын цагдаагийн газар, бусад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс зохион байгуулж, явуулж буй ажил, арга хэмжээнүүд бидний хүссэн үр дүнд төдийлөн хүрэхгүй байгаа нь статистик тоо мэдээнээс харагдлаа. Тиймээс бид гадаадын зарим оронд нэвтрүүлж тодорхой үр дүнд хүрсэн аргуудыг өөрийн орны хөрсөнд буулгах замаар нэвтрүүлж, үр дүнг тооцох ажлыг нэн даруй эхлүүлэх шаардлагатай байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. АНУ-д нэвтрүүлсэн “Алхах аюулгүй байдлын 8 зөвлөмж”-ийг манай нийтийн тээврийн автобусны буудлын самбар, автобусны дотор хананд, ерөнхий боловсролын сургуулийн гадна самбар, дэлгүүрийн гадна хэсэг гэх мэт хүн олноор цуглардаг газруудын ил харагдах хэсгүүдэд иргэдийн сэтгэлд хоногшуултал нь байрлуулах;

2. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт “Хүүхдийн явган зорчигчийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр”-ийг оруулж тусгуулах;

3. Вьетнам улсын хэмжээнд их замын 50 км тутамд замын цагдаагийн эргүүлийн 1 машин 24 цагийн туршид эргүүл хийж ажиллуулдаг туршлагыг судалж үзэх;

4. Вьетнам улсын хууль тогтоомжид хурд хэтрүүлэх, дураараа авирлах мэтийн зөрчил гаргагчдын хөдөлгөөнд оролцох эрхийг 15-30 хоног хасч, мөн торгууль оногдуулдаг эрх зүйн туршлагыг нэвтрүүлэх зэрэг болно.

Ашигласан материал

¹¹⁹

https://nationalcenterformobilitymanagement.org/wpcontent/uploads/2013/11/Checklist_Assessing_Accessibility.pdf

¹²⁰ <https://www.nhtsa.gov/pedestrian-safety/child-pedestrian-safety-curriculum>

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
2. Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл. Уб. 2022.
3. Global Status Report on Safety 2013.Supporting a decade of action.Who, 2013
4. American Association of State Highway and Transportation Officials 2007
5. <https://ru.wikipedia.org>
6. <http://www.who.int>.
7. <https://nationalcenterformobilitymanagement.org>
8. <https://www.nhtsa.gov>

**ЖАГСААЛ, ЦУГЛААНЫ ҮЕИЙН ЗАМЫН ЦАГДААГИЙН АЛБАНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ
OFFICE OF TRAFFIC POLICE DURING DEMONSTRATION
AND MEETINGS LEGAL REGULATION OF ACTIVITIES**

*Цагдаа судлалын магистрант,
цагдаагийн ахлах дэслэгч
Б.Чинтамир
Postgraduate of Police study
Police first lieutenant
B.Chintamir*

Хураангуй. Жагсаал, цуглаан зохион байгуулахад цагдаагийн байгууллагын үүрэг оролцоо нэн чухал юм. Цагдаагийн байгууллага нь төрийн эрх мэдлийн хамгийн тод илэрхийлэл болдог учраас төрийн хууль дээдлэх, хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэг амлалтыг харуулж байдаг.

Энэхүү өгүүлэлд жагсаал, цуглааны үеийн хэв журам сахиулахад замын цагдаагийн албанаас явуулах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг түүвэрлэн авч судлаачийн үүднээс өөрийн санаа бодлоо товч илэрхийлсэн бодомжоо бичсэн болно.

Abstract. The role of the police in organizing demonstrations and gatherings is very important. Because the police organization is the clearest expression of the state's power, it shows the state's commitment to the rule of law and the protection of basic human rights and freedoms.

In this article, I have briefly expressed my thoughts from the researcher's point of view by selecting the legal regulations of the traffic police to maintain order during demonstrations and gatherings.

Түлхүүр үг. Жагсаал, цуглаан, замын цагдаа, тээврийн хэрэгсэл, замын хөдөлгөөний аюулгүй байдал

Key word. Demonstrations, gatherings, traffic police, vehicles and traffic safety

Үндсэн хэсэг. Цагдаагийн байгууллага нь өөрөө аяндаа болон өөр хоорондоо хамааралгүй ч нэгэн зэрэг зохион байгуулагдах цуглаан, эсэргүүцлийн жагсаал зэрэг бүх тайван жагсаал, цуглаанд хэв журам сахиулан, цуглаанд оролцогчдыг хамгаалж, тэдэнд зорилтот бүлэгтээ харагдаж, сонсогдох зайнд өөрсдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгох ёстой. Ер нь жагсаал, цуглааны дийлэнх нь тайван замаар явагддаг бөгөөд олон нийтийн дэг журамд ямар нэгэн саад бэрхшээл учруулаад байдаггүй.¹²¹ Гэхдээ жагсаал, цуглаантай холбоотой аливаа зөрчил мөргөлдөөн гарахаас урьдчилан сэргийлэх, хурцадмал байдлыг намжаахын тулд цагдаагийн байгууллага сайтар бэлтгэгдсэн байх шаардлагатай.

Жагсаал, цуглааны нэлээдгүй нь өдөр тутмын үйл ажиллагаанд тодорхой хэмжээний саад учруулдаг; зам, гудамж талбайг эзлэх, эсвэл замын хөдөлгөөн, явган зорчигч, бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй.

¹²¹ <https://www.osce.org>. //Татаж үзсэн: 21.01.2024. Жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахад баримтлах хүний эрхийн гарын авлага

Тайван замаар жагсаал, цуглаан хийх эрх нь доромжилсон үг хэллэгийг агуулж болох ч бусдыг айлган сүрдүүлэх, дарамтлах, заналхийлэхэд чиглэсэн жагсаал, цуглаан, үйл хөдлөлд төрөөс хууль ёсны дагуу шаардлагатай, тохирсон хязгаарлалт, хоригийг тавьж болно. Жагсаал, цуглаан зохион байгуулагч, эсвэл оролцогч хувь хүмүүс нь жагсаал, цуглаанд тавигдах хууль ёсны шаардлагыг дагаж мөрдөөгүй байж болох ч энэ нь дангаараа цагдаагийн байгууллагын тайван амгалан үргэлжилж байгаа жагсаал, цуглааныг хамгаалах, зохицуулах үүргээс нь чөлөөлөхгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Жагсаал, цуглаанд тавигдах хуулийн шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан хувь хүмүүст тохирох арга хэмжээ, шийтгэлийг ногдуулах замаар шийдвэрлэж болно. Эрх баригчид болон цагдаагийн байгууллага жагсаал, цуглаан хийх эрх нь хувь хүний эрх бөгөөд хэн нэгэн хувь хүн, цөөн тооны хүмүүсийн хэл амаар болон бие махбодиор үзүүлж буй түрэмгийлэл, хүчирхийлэл нь тайван замаар жагсаж, цуглаж байгаа бусад хүмүүсийн эрхийг тасалдуулах ёсгүй гэдгийг санах хэрэгтэй.

Тайван жагсаал, цуглааны үйл ажиллагаа нь бусдын эрх, эрх чөлөөнд нөлөөлж байгаа тохиолдолд эрх баригчид холбогдох бүх эрх, эрх чөлөөг тэнцвэртэй хангах байдлаар асуудлыг шийдвэрлэх ёстой. Зарим орнуудад ийм эрх мэдэл нь цагдаад байдаг бол, зарим улсад эдгээр асуудлыг тэнцвэртэй хангах үүрэг нь орон нутгийн эрх бүхий байгууллага, эсвэл шүүхэд байдаг.¹²²

Жагсаал, цуглааны үеэр хувь хүмүүс, эсвэл цөөн тооны бүлэг хүмүүс хүчирхийлэл үйлдэж байгаа бол цагдаагийн байгууллагын авч буй хариу арга хэмжээ нь уг үйлдэлд нь тохирсон байх ёстой гэдгийг заавал баталгаажуулах ёстой бөгөөд жагсаал, цуглаанд оролцогчдод ерөнхий анхаарал хандуулахаас илүүтэй хүчирхийлэл үйлдэж буй хүмүүст анхаарлаа хандуулах ёстой. Ялангуяа цагдаагийн алба хаагчид, хувь хүмүүс, өмч хөрөнгө, жагсаал цуглаанд оролцогчид болон сөрөг хүчин гэж тооцогдож буй хүмүүсийн эсрэг хүчирхийлэл үйлдэж байгаа тохиолдолд илүү хүчинтэй.

Жагсаал, цуглаанд оролцогчдын эсрэг хүч хэрэглэсэн аливаа үйлдэл нь оролцогчдын зүгээс уурлаж бухимдах, хариу түрэмгий үйлдэл үзүүлэхэд хүргэх бөгөөд энэ нь зөвхөн нөхцөл байдлыг улам хурцатгана гэдгийг цагдаа үргэлж санаж байх ёстой. Иймд цагдаагийн байгууллага авах гэж байгаа арга хэмжээнийхээ зорилго, төлөвлөгөөг ил тод, нээлттэй мэдээлэх хэрэгтэй.

Хүч хэрэглэхийн өмнө аль болох урьдчилан сануулж, сэрэмжлүүлэх шаардлагатай. Оролцож буй бүх хүнд тайван жагсаал, цуглаан хийх эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангуулахын тулд жагсаал, цуглаанд оролцож буй тодорхой бүлэгт хамаарах хүмүүсийн хүйс, нас, хөгжлийн бэрхшээл, гарал үүсэл, шашин шүтлэг, үндэс угсаа, бэлгийн чиг баримжаа зэргээс нь шалтгаалан тэдний эсрэг дайралт гарч болзошгүй гэдэгт цагдаагийн байгууллага үргэлж сонор сэрэмжтэй хандах ёстой.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 21-р зүйл (ICCPR)-д жагсаал, цуглааныг хязгаарлах үндэслэлийг дараах байдлаар заасан байдаг. Үүнд:

“Энэ эрхийг хэрэгжүүлэхэд үндэсний аюулгүй байдал, нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам (ordre public), нийтийн эрүүл мэнд, ёс суртахуун, эсхүл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах зэргээр хуульд нийцүүлэн заасан, мөн нийтийн эрх ашгийг хамгаалах

¹²² <https://www.osce.org>. //Татаж үзсэн: 21.01.2024. Жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахад баримтлах хүний эрхийн гарын авлага

ашиг сонирхолд нийцүүлэн аливаа ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай хязгаарлалтаас өөр хязгаарлалт тавьж болохгүй.”¹²³

Аливаа жагсаал, цуглаан нь хүчирхийллийн шинжтэй эсрэг жагсаалтай тулгарах, эсхүл эсрэг байр суурьтай хүмүүсийн шууд халдлагад өртөх магадлалтай байсан ч зарчмын хувьд тухайн тайван жагсаал, цуглааныг хориглоход хүргэх ёсгүй. Энэ тохиолдолд цагдаагийн байгууллага нь тухайн тайван жагсаал, цуглаан эсэргүүцэгчдийн халдлага, хүчирхийллээс хамгаалах үүрэгтэй.

Бүх жагсаал, цуглааныг тодорхой газар, эсвэл тодорхой хугацаанд хориглох нь тайван жагсаал, цуглаан хийх эрхийг зохимжгүй хязгаарласан гэж үзэхэд хүргэх магадлалтай. Хэрэв жагсаал, цуглаан хийхийг хориглосон, хязгаарласан бол тухайн шийдвэрийг давж заалдах, эсэргүүцэх эрх байх ёстой.

Монгол Улсад зохион байгуулагдаж буй жагсаал, цуглааны үеийн замын хөдөлгөөний аюулгүй байдал хангах арга хэмжээг замын цагдаагийн албанаас авахдаа дараах хууль тогтоомжийг үйл ажиллагааны эрх зүйн үндсээ болгоно. Үүнд:

- **Монгол Улсын Үндсэн хууль:**

- 16 дугаар зүйлийн 16-д “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно”¹²⁴

- **Цагдаагийн албаны тухай хууль:**

- 10 дугаар зүйл /Гэмт хэрэгтэй тэмцэх/-ийн 10.1.1.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгуулах;
- 11 дүгээр зүйл /Нийтийн хэв журам хамгаалах/-ийн 11.1.3 “замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах”¹²⁵
- 11.1.2.гудамж, талбай болон нийтийн эзэмшлийн бусад газарт эргүүл хийх, байнгын болон түр ажиллагаатай хянаж-нэвтрүүлэх цэг ажиллуулах дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, бусад арга, техник хэрэгсэл ашиглан хяналт тавих;
- 11.1.7.хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад илэрсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, тэдгээрийг гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн, хуулийн этгээдэд шаардлага, сэрэмжлүүлэг өгөх, биелэлтийг нь хангуулах;
- 13 дугаар зүйл /Захиргааны хяналт тавих/-ийн 13.1.3.зам тээврийн осол, түүнээс учирсан хохирол, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн жолооч болон зөрчлийн тоо бүртгэл хөтлөх;
- 22.2.Цагдаагийн алба хаагч нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл албадлагын арга хэмжээ авсан тохиолдолд арга хэмжээ авах болсон үндэслэл, шалтгааныг тухайн этгээдэд мэдэгдэж, авсан арга хэмжээтэй холбогдон хүн, хуулийн этгээдэд үүсэх эрх, үүрэг, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, өөрийнхөө эсрэг тайлбар, мэдүүлэг өгөхгүй байх эрхийг тайлбарлаж өгөх үүрэгтэй.
- 22.7.Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрэмт хувцас,

¹²³ <https://www.osce.org>. //Татаж үзсэн: 21.01.2024. Жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахад баримтлах хүний эрхийн гарын авлага. –Уб., 2022. 21 дэх тал

¹²⁴ Төрийн мэдээлэл. 1992. №1 //Монгол Улсын Үндсэн хууль

¹²⁵ Төрийн мэдээлэл. 2017. №8 // Цагдаагийн албаны тухай хууль

албаны өрөө, тээврийн хэрэгсэлд дуу-дүрсний бичлэг хийх техник, хэрэгслийг суурилуулан ашиглаж болно.

- 23 дугаар зүйл. Шаардлага тавих;
- 25 дугаар зүйл. Хүний бичиг баримт шалгах;
- 26 дугаар зүйл. Түр саатуулах;
- 30 дугаар зүйл. Эд зүйл, баримт бичиг түр хураан авах;
- 31 дүгээр зүйл. Тээврийн хэрэгслийг зогсоож шалгах;
- 32 дугаар зүйл. Согтуурсан, мансуурсан байдлыг шалгах;
- 33 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, түр саатуулах;
- 34 дүгээр зүйл. Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх;
- 35 дугаар зүйл. Зорчих хөдөлгөөнийг хязгаарлах;
- 36 дугаар зүйл. Зам чөлөөлөх, хөдөлгөөний чиглэлийг түр өөрчлөх, хаах.
- 52 дугаар зүйл /Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх/-ийн 52.1.7.албаны болон бусдын орон байрыг эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх¹²⁶

• **Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль:**¹²⁷

- 11 дүгээр зүйл /Жагсаал, цуглааныг зохион байгуулагч түүний үүрэг/-ийн 11.6/ жагсаал, цуглааны үеэр гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаах, аливаа байгууллагын хэвийн ажиллагааг алдагдуулах, дотоод хэрэгт нь оролцоход чиглэсэн үйл ажиллагаа явуулахгүй байхыг оролцогчдод урьдчилан анхааруулж, энэхүү шаардлагыг чандлан сахиулах;
- 13 дугаар зүйл /Жагсаал, цуглаан, түүнд оролцогчдыг хамгаалах/-ийн 13.4.Жагсаал, цуглаанд оролцож байгаа авто хөсгийн хөдөлгөөнийг тусгайлан зохицуулна.

• **Зөрчлийн тухай хууль:**

- 5.1 дүгээр зүйл.Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах;
- 5.2 дугаар зүйл.Танхайрах;
- 5.3 дугаар зүйл.Хүний биед халдах;
- 5.8 дугаар зүйл.Жагсаал, цуглаан зохион байгуулах журам зөрчих;
- 5.9 дүгээр зүйл.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчих;
- 14.7 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих;
- 15.18 дугаар зүйл.Цагдаагийн албаны тухай хууль зөрчих¹²⁸

• **Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль:**

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг явуулах явцад Зөрчлийн тухай хуулийн 6.8-д заасан дор дурдсан зүйл, хэсэгт заасан зөрчлүүдийг шалган шийдвэрлэнэ. Үүнд:

Хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 5.2, 5.3 дугаар зүйл, 5.8 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5 дахь хэсэг, 14.7, 15.18 дугаар зүйл, хэсэгт заасан зөрчил,¹²⁹

• **Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль**¹³⁰

- 8 дугаар зүйл /Цагдаагийн байгууллагын эрх, үүрэг/-ийн 8.1.1.замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт тавих; 8.1.2.замын хөдөлгөөнд оролцогчийн хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг хангах зорилгоор замын хөдөлгөөнийг зохицуулах.

¹²⁶ Төрийн мэдээлэл. 2017. №8 //Цагдаагийн албаны тухай хууль

¹²⁷ Төрийн мэдээлэл. 1994. №9. //Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль

¹²⁸ Төрийн мэдээлэл. 2017. №24 //Зөрчлийн тухай хууль

¹²⁹ Төрийн мэдээлэл. 2017. №24 //Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль

¹³⁰ Төрийн мэдээлэл. 2015. №28 //Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль

- 8.2.1.замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх үйлдэл, нөхцөлийг таслан зогсоох үндэслэлээр тээврийн хэрэгслийг албадан зогсоох, дайчлах, түр саатуулах, зөөж шилжүүлэх; 8.2.2.замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор замын хөдөлгөөнийг зохион байгуулах, урсгал, чиглэлийг түр өөрчлөх, хязгаарлах, хаах; 8.2.3.жолооч согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зориулалтын техник, хэрэгсэл ашиглан шалгаж тогтоох;
- Замын хөдөлгөөний дүрэм¹³¹
- 1.3. Замын хөдөлгөөнд оролцогч нь аюул, хохирол учруулахгүй, хөдөлгөөнд осолтой байдал бий болгохгүйгээр зорчино.1.4. Замын тэмдэг, гэрлэн дохио болон хөдөлгөөн зохион байгуулах бусад техник хэрэгслийг эвдэж гэмтээх, халхлах, дур мэдэн байрлуулах, өөрчлөх, авч хаях, мөн замын хөдөлгөөнд саад болох, халтиргаа, шарвалт үүсгэх, тээврийн хэрэгслийн дугуйн доороос шидэгдэх, дугуйг хагалж болзошгүй элдэв зүйлсийг зам дээр хаях, асгах, орхих, замын хучилтыг бохирдуулах, эвдэх, гудамж замд хог хаяхыг хориглоно. Тухайн аюул, саадыг бий болгосон хүн, хуулийн этгээд нь түүнийг нэн даруй арилгах, хэрэв боломжгүй бол бусад хөдөлгөөнд оролцогчдод анхааруулах талаар шаардлагатай арга хэмжээ авч, цагдаагийн алба, эсхүл замын хяналт (ашиглалт, арчилгаа, хяналт шалгалт) хариуцсан байгууллагад яаралтай мэдэгдэх үүрэг хүлээнэ.
- 5.3. Жагсаалаар яваа хүмүүс зорчих хэсгээр явах тохиолдолд дөрвөөс илүүгүйгээр зэрэгцэж хөдөлгөөний чигийн дагуу баруун гар талаар явна. Жагсаалын зүүн гар талын захын урд болон ард, өдрийн цагт улаан дарцаг, харанхуй үед болон үзэгдэлт хангалтгүй нөхцөлд урд нь цагаан, ард нь улаан гэрэл (эсхүл гэрэл ойлгуур) барьсан хүн харгалзаж явна.
- 8.15. Зохицуулагч нь жолооч, явган зорчигчдод хөдөлгөөний чиг өөрчлөх, байр эзлэх, хурд хасах буюу нэмэх, тойрон гарах, зогсох зэрэг үйлдэл хийхийг заасан ойлгогдохуйц дохио өгч болно.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам

- **Замын хөдөлгөөний урсгал, чиглэлийг түр өөрчлөх, хаах журам /код 224/**
- 224.4.Замын хөдөлгөөнийг зохион байгуулах, урсгал, чиглэлийг түр өөрчлөх, хязгаарлах, хаах
- 224.4.3.Шуурхай удирдлагын штаб нь цагдаагийн байгууллага, алба хаагчаас ирүүлсэн албан ёсны мэдээллийг хүлээн авсан даруйд тухайн замын хөдөлгөөний урсгал чиглэлийг өөрчлөх, хязгаарлах, хаах шаардлага бий болсон эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгнө. Хэрвээ өөрчлөх зайлшгүй шаардлага бий болсон нөхцөл байдал тогтоогдвол нэн даруй замын хөдөлгөөнийг зохион байгуулах шийдвэрийг баталж, цагдаагийн төв байгууллагын удирдлагад мэдээлнэ. 224.4.4.Энэ арга хэмжээнд замын цагдаагийн албаны хүч, хэрэгсэл хүрэлцэхгүй тохиолдолд Цагдаагийн төв байгууллагын даргад нэн даруй танилцуулан, бусад албадын хүчийг техник хэрэгслийн хамтаар татан оролцуулж болно.
- **Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх журам /код 227**
- 227.7 /Алба, нэгжийн дарга, алба хаагчдын гүйцэтгэх үүрэг/-ийн 227.7.2 е/Тээврийн цагдаагийн алба, Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан нэгж: 5/замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлэх, зам тээврийн

¹³¹ <https://legalinfo.mn>. //Татаж үзсэн: 21.01.2024. Замын хөдөлгөөний дүрэм

ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бусад байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх; 7/зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр иргэд, байгууллагын санал, санаачилгыг дэмжиж, хамтран ажиллах;

- **Тээврийн хэрэгслийг эрэн сурвалжлах журам /код 231/**
- **Тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглэх журам /код 233/**
- 233.3.4.Хойшлуулшгүй албан үүрэг гүйцэтгэхээс бусад үед алба хаагч замын хөдөлгөөний холбогдох журмыг мөрдөж, тусгай дуут болон гэрэл дохиог ажиллуулахгүй. Тусгай дуут болон гэрэл дохио ажиллуулаагүй яваа алба хаагч замын хөдөлгөөний дүрмийн дагуу хөдөлгөөнд оролцох ёстой.¹³²
- **Саатуулсан тээврийн хэрэгсэл хадгалах журам /код 405/**
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн жолоочийн тээврийн хэрэгслийг цагдаагийн байгууллагын эзэмшил, өмчлөлд байдаг тээврийн хэрэгсэл түр саатуулах хашаа /байр/-нд хүлээн авч тодорхой хугацаанд хадгалах, хүлээлгэн өгөхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.¹³³
 - **Замын хөдөлгөөнийг зохицуулах, хянаж шалгах журам /код 406/**
 - **Тээврийн хэрэгслийг зөөвөрлөн шилжүүлэх журам /код 407/**
 - **Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам /код 500/**
- 500.11 /Замын цагдаагийн албаны үүрэг/-ийн 500.11.1.Замын цагдаагийн алба нь хамгаалалтын үед хөдөлгөөний аюулгүй байдлыг хариуцан замын хөдөлгөөний урсгал, чиглэлийг зохицуулах үүрэгтэй. 500.11.2.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалтыг нийслэлд Замын цагдаагийн алба, орон нутагт нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэс, тасаг, хэсэг, хэсгийн төлөөлөгч хариуцан гүйцэтгэнэ. 500.11.3.Төрийн тусгай хамгаалалтын үед хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба хариуцан гүйцэтгэнэ.
 - **Замын хөдөлгөөний талаар зөвшөөрөл олгох журам /код 611/**
- 611.4.1.Замын хөдөлгөөнд саад учруулахаар үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл а/замын хөдөлгөөний чиглэл, урсгалыг өөрчлөх нь өдөр тутмын замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлнө. Иймд Замын цагдаагийн алба нь зөвшөөрөл олгох ажиллагаанд болгоомжтой хандах хэрэгтэй. Зорчих хэсгийг нарийсгах, хөдөлгөөнд саад учруулахаар үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг олгоход замын хөдөлгөөний ослоос сэргийлэх арга хэмжээний талаар энэ чиглэлийн мэргэжилтэн, албан хаагчидтай зөвшилцөнө;¹³⁴
- **Албан үүрэг гүйцэтгэх үед алба хаагч хүнтэй харилцах, биеэ авч явах байдал /код 921/**
- 921.3.17.Замын хөдөлгөөн зохицуулах үүрэг гүйцэтгэж буй алба хаагч энэ журмын 921.3-т заасан хүнтэй харилцахад тавигдах шаардлагаас гадна дараах харилцааг баримтална.¹³⁵ а/тээврийн хэрэгслийг шалгах, зогсоох болсон шалтгаан, хууль тогтоомжийн холбогдох заалтыг товч, тодорхой тайлбарлах; б/хүнээс шаардсан

¹³² Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. – Уб.,2022. 519 дэх тал

¹³³ Мөн бүтээл. 663 дахь тал

¹³⁴ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. – Уб.,2022. 830 дахь тал

¹³⁵ Энэ хэсгийг ЦЕГ-ын даргын 2021 оны А/274 дүгээр тушаалаар нэмсэн.

тохиолдолд албаны үнэмлэхийг түүний гарт нь өгөхгүйгээр харуулах, хувийн дугаараа хэлэх; в/бичиг баримтыг даруй хугацаанд цагдаагийн шалгах төхөөрөмж, мэдээллийн санд шалгах, тээврийн хэрэгсэл, ачаа тээшинд үзлэг хийх; г/тухайн харилцах үеийн нөхцөл байдлыг үнэлэх, шаардлага тавих, шаардлагыг биелүүлээгүй, эсхүл эсэргүүцсэн тохиолдолд хуульд заасан албадлагын арга хэмжээ хэрэглэх талаар тайлбарлах; д/шийтгэлийн хуудас эсхүл бичиг баримтыг гарт нь буцаан өгөх, цаг агаарын нөхцөл байдал, замын эвдрэл гэмтлийн талаар анхааруулж, зөвлөмж өгөх.¹³⁶

- **Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам** /Хууль зүйн сайдын 2019 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн А/101 дүгээр тушаалаар баталсан/
- 2.16.Гэрлэн дохиогоор зохицуулдаг уулзвар, гарц, явган хүний гарц, төмөр замын гарам дээр дараах тохиолдолд замын хөдөлгөөнийг биечлэн зохицуулна: 2.16.1.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд заасан төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, иргэн замын хөдөлгөөнд оролцоход; 2.16.2.замын хөдөлгөөнд оролцогчдод аюултай нөхцөл байдал /зам, замын байгууламж эвдэрсэн, байгалийн гамшиг, гал түймэр, халдварт өвчин гэх мэт/ үүсэхэд; 2.16.3.эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийн дагуу нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахад; 2.16.4. зам тээврийн осол, гэмт хэрэг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, байгалийн гамшиг, гал түймэр зэрэг шаардлагатай үед;¹³⁷
- **Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио тавьж хэрэглэх журам** /Хууль зүй, дотоодын хэргийн сайдын 2017 оны А/292 дугаар тушаалаар баталсан/
- **Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам**¹³⁸ /Хууль зүйн сайдын 2019 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн А/101 дүгээр тушаалаар баталсан/

Дээрхи бүх хууль, дүрэм, журмууд нь жагсаал, цуглааны үеийн замын цагдаагийн албаны алба хаагч нарын үйл ажиллагаандаа дагаж мөрдөх боловч ямар харилцаанд оролцохоос хамаарч, харилцан адилгүй байдлаар ашиглагдана.

Дүгнэлт. Жагсаал, цуглааны үеийн замын цагдаагийн албаны алба хаагч нарын үйл ажиллагаандаа дагаж мөрдвөл зохих хууль тогтоомжийн хувьд бүрдсэн гэж үзэж болох боловч ямар харилцаанд оролцохоос хамаарч, харилцан адилгүй байдлаар ашиглагдахаар байна.

Гэвч жагсаал, цуглааныг тээврийн хэрэгсэл ашиглан зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулсан журам, заавар байхгүй байгаа нь тулгамдсан асуудал гэж үзэж байна. Учир нь сүүлийн жилүүдэд хууль бус жагсаал, цуглааны үеэр тээврийн хэрэгсэл ашиглан согтууруулах төрлийн ундаа талбай руу нэвтрүүлэх, жагсагчдад хууль бус эд зүйл нэвтрүүлэн тараах зэрэг сөрөг явдал гарах болсон нь энэ чиглэлийн эрх зүйн журам, заавар зайлшгүй шаардлагатай болсоныг харуулж байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. үүнд:

1. Тээврийн хэрэгсэл ашиглан зохион байгуулж байгаа жагсаал, цуглаантай холбоотой харилцааг зохицуулсан тусгайлсан журмыг боловсруулах
